

ДЭЛХИЙ ДАХИНЫ

ХҮНИЙ ЭРХИЙН

ТӨЛӨВ БАЙДАЛ

2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САР



**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг. Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

© Эмнести Интернэшнл 2025

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензтэй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаас үзнэ үү:

www.amnesty.org

Анхны хэвлэлт 2025 он

Эмнести Интернэшнл

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

Индекс: POL 10/8515/2025

ISBN: 978-0-86210-510-5

Эх хэл: Англи

amnesty.org

amnesty.mn

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ӨМНӨХ ҮГ	5
ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	12
Зэвсэгт мөргөлдөөний хүчирхийлэл	12
Өөрөөр сэтгэгчдийг дарангуйлсан нь	14
Ялгаварлан гадуурхалт	16
Эдийн засаг болон уур амьсгалын шударга бус байдал	18
Технологи ба хүний эрх	21
АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	24
АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	34
АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	44
ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	54
ОЙРХ ДОРНОД БОЛОН ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	65

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

AI – ЭЙАЙ/ЭИ

Artificial intelligence
Хиймэл оюун ухаан

ASEAN – АСЕАН

Association of Southeast Asian Nations
Зүүн өмнөд Азийн орнуудын хамтын
нийгэмлэг

AU – АХ

African Union
Африкийн холбоо

CEDAW – ЭАБХУК

UN Convention on the Elimination of All
Forms of Discrimination against Women
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг
устгах тухай НҮБ-ын конвенц

CEDAW Committee –ЭАҮУХ

UN Committee on the Elimination of
Discrimination against Women
Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг
устгах НҮБ-ын хороо

CERD – АҮАҮБХҮОУК

International Convention on the Elimination
of All Forms of Racial Discrimination
Арьс үндсээр алагчлах үзлийн бүх
хэлбэрийг устгах тухай олон улсын
конвенц

CERD Committee – АҮАҮҮ хороо

UN Committee on the Elimination of Racial
Discrimination
Арьс үндсээр алагчлах үзлийг устгах
НҮБ-ын хороо

COP29 – COP29

The 29th Conference of the Parties (COP)
to the UN Framework Convention on
Climate Change
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн
суурь конвенцийн Талуудын 29 дүгээр
Бага хурал

ECOWAS –БАУЭЗХН

Economic Community of West African
States
Баруун Африкийн улсуудын Эдийн
засгийн хамтын нийгэмлэг

Escazzy Agreement –Эсказугийн хэлэлцээр

Regional Agreement on Access to
Information, Public Participation and
Justice in Environmental Matters in Latin
America and the Caribbean
Латин Америк ба Карибын тэнгисийн
орнуудын хүрээлэн буй орчны
асуудлаарх мэдээллийн хүртээмж, олон
нийтийн оролцоо, шударга ёсны тухай
бүс нутгийн хэлэлцээр

EU – ЕХ

European Union -Европын холбоо

European Committee for the Prevention of Torture

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хороо

European Committee for the Prevention
of Torture and Inhuman or Degrading
Treatment or Punishment
Эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу
хүний нэр төрийг доромжлон харьцаж,
шийтгэхээс урьдчилан сэргийлэх
Европын хороо

European Convention on Human Rights Европын Хүний эрхийн конвенц

(European) Convention for the Protection
of Human Rights and Fundamental
Freedom
Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах
Европын конвенц

ICC – ОУЭШ

International Criminal Court
Олон улсын Эрүүгийн Шүүх

ICCPR – ИУТЭОУП

International Covenant on Civil and Political Rights

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

ICESCR – ЭЗНСЭОУП

International Covenant on Economic, Social and Cultural Rights

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

ICRC – ОУУЗХ

International Committee of the Red Cross
Олон улсын Улаан Загалмайн Хороо

ILO – ОУХБ

International Labour Organization
Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага

International Convention against enforced disappearance
Хүчээр алга болгохын эсрэг олон улсын конвенц

International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц

INGO – ОУТББ

International non-governmental organization
Олон улсын төрийн бус байгууллага

LGBTI – ЛГБТИ

Lesbian, gay, bisexual, transgender and intersex
Лесбиан, гей, бисексуал, трансжэндэр, интерсекс

MP – ПГ

Member of parliament
Парламентын гишүүн

NATO –НАТО

North Atlantic Treaty Organization
Умард Атлантын Гэрээний Байгууллага

NDC –ҮТХН

Nationally determined contribution
Үндэсний тодорхойлсон хувь нэмэр

NGO – ТББ

Non-governmental organization
Төрийн бус байгууллага

OAS – АУБ

Organization of American States
Америкийн улсуудын байгууллага

ООНА – ХХЭГ

United Nations Office for the Coordination of Humanitarian Affairs
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүмүүнлэгийн хэрэг эрхлэх газар

ОНЧР the UN human rights office- ХЭДКГ

Office of the United Nations High Commissioner for Human Rights
НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар

OSCE – ЕАБХАБ

Organization for Security and Co-operation in Europe
Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага

UN – НҮБ

United Nations
Нэгдсэн Үндэстний Байгууллага

UN Convention against Torture
НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц

Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц

UNDP – НҮБХХ

UN Development Programme
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

UN Refugee Convention
НҮБ-ын Дүрвэгсдийн тухай конвенц

Convention relating to the Status of Refugees
Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц

UN Special Rapporteur on climate change

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the promotion and protection of human rights in the context of climate change

Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extrajudicial executions

Шүүхээс гадуур цаазлах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extrajudicial, summary or arbitrary executions

Шүүхээс гадуур буюу дур мэдэн цаазлах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extreme poverty

Нэн ядуурлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extreme poverty and human rights

Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on freedom of expression

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on racism

Арьс үндсээр алагчлах үзлийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance

Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture

Эрүүдэн шүүхийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on violence against women and girls

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special rapporteur on violence against women, its causes and consequences

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UNESCO – ЮНЕСКО

United Nations Educational, Scientific and Cultural Organization

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага

UNHCR, the UN refugee agency

ДДКГ, Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Дээд комиссар

Office of the United Nations High Commissioner for Refugees

Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Дээд Комиссарын Газар

UNICEF – ЮНИСЕФ

United Nations Children’s Fund

НҮБ-ын Хүүхдийн сан

UPR – ЭДХ

UN Universal Periodic Review

НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг

WHO – ДЭМБ

World Health Organization

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөн түүхийн чухал уулзварт ирээд байна. Урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр хүч албадлага хэрэглэж, хүний эрхийн үзэл санааг ангуучилж, Дэлхийн II дайн, түүний сүйрэлд өртсөн олон сая хүний цус, зовлон зүдүүрээр бий болгосон олон улсын тогтолцоог сүйтгэн нураахаар зэхэж байна. Улс орнууд хооронд болоод улс орон дотор тэгш бус байдалд тулгуурласан эдийн засгийн дэг журмыг тогтоохын төлөөх шашин, арьс үндэс, патриарх тэмцэл нь өнгөрсөн 80 жилийн хугацаанд арай хийн олж авсан тэгш байдал, шударга ёс, хүний эрхэм чанарыг аюулд оруулж байна. Хүний эрхийн зөрчилд ногдуулах хариуцлагын эсрэг, олон улсын эрх зүйн эсрэг, НҮБ-ын эсрэг олон төрлийн дайралт үргэлжилсээр байгааг АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын 2025 оны «засаглалын» эхний 100 хоногийн үйл явдлууд бэлхнээ харуулав. Гэвч дэлхий дахины ядуурлыг бууруулах, мөн арьс үндэс, хүйсээр ялгаварлах, хүчирхийллийг зогсоохын эсрэг үйлдэж буй ийм увайгүй, хариуцлага хүлээлгэвэл зохистой зөрчлүүд зөвхөн энэ оноос эхлээгүй юм. Эдгээр тулгамдсан асуудлыг нэг шөнийн дотор өргөс авсан мэт шийдвэрлэх ч боломжгүй.

Эмнести Интернэшнл болон бусад хүний эрхийн байгууллагуудаас урьдчилан анхааруулсан боловч эдгээрийг үл тоомсорлож, хоёр дахь удаагаа тангараг өргөснөөс хойш Ерөнхийлөгч Трампын үйл ажиллагаа анхааруулгын эсрэг чиглэж байна. Трампын энэхүү замнал сүүлийн 10 жилийн хугацаанд гарсан системтэй, зориуд хэт нэг талыг барьсан шийдвэрүүдтэй нэгдэн үргэлжилж, 2025 онд хямралыг шинэ байдлаар улам гүнзгийрүүлээ.

Бид алдах эрхгүй. Энэ бол зөвхөн Ерөнхийлөгч Трампын тухай асуудал биш. Үндэс суурь нь илүү гүнзгий. Үүний эсрэг хамтдаа, зоригтой эсэргүүцэхгүй бол энэхүү үйл явдлууд нь түүхийн шилжилт болон хувирч, өөрчлөлтийн эрин үе биш харин эрин үеийн өөрчлөлт болох болно.

ААЖМААР ӨРНӨСӨН ХАР ДАРСАН ЗҮҮД

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд дэлхийн улс орнуудад дарангуйллын бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа аажмаар түгж, иргэний орон зайг хумьж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө улам хэврэгшлээ. Бодлогын сонголтууд нь тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж, ядуурлыг нэмэгдүүлж, тэрбумтнуудыг тэжээн тэтгэсээр байна. Хүчирхэг улс орнуудын хэт их шунал, арьс үндсээр ялгаварлан гадуурхах, хувиа хичээх байдлыг Ковид цар тахлын үед олон сая хүнийг үхэлд хүргэхэд бэлэн байснаар нь бид харсан. Мөн уур амьсгалын хямралтай нүүр тулаад байгаа үед улс орнууд 2015 онд Парист өгсөн амлалтаа биелүүлж чадсангүй.

Онцгой анхааруулга бүхий олон тооны түгшүүрийн дохио өгсөөр атал 2024 онд геноцид буюу төрлөөр нь устгах гэмт хэрэг үйлдэгдлээ.

2024: ГЕНОЦИД ҮЙЛДЭЖ БАЙГААГ ДЭЛХИЙ НИЙТЭЭР ШУУД ҮЗЭВ

2023 оны 10 дугаар сарын 7-ноос эхлэн Хамас бүлэглэл Израилын иргэд, бусад хүний эсрэг аймшигт гэмт хэрэг үйлдэж, 250 гаруй хүнийг барьцаалснаас хойш геноцидын гэмт хэргийн талаарх мэдээллийг дэлхий нийтээрээ шууд ил тод харах боломжтой болсон. Израил улс мянга мянган палестинчуудыг хөнөөж, гэр бүлүүдийг хэдэн үеэр нь хүйс тэмтэрч, орон байр, амьжиргаа, эмнэлэг, сургуулийг сүйтгэж байхад бусад улс орнууд хүчин мөхөс мэт хөндлөнгөөс харсаар байв.

АНУ, Герман зэрэг Европын бусад улс дэмжсэнээр Израилын цэргийн эзлэн түрэмгийлэл улам бүр увайгүй, үхлийн аюултай болж байгаагаар 2024 он түүхэнд дурсагдах болно; НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн гал зогсоох тогтоолд Байдены захиргаан дор АНУ удаа дараа хориг тавьж, улс орнууд Израил руу зэвсэг нийлүүлэлтээ үргэлжлүүлэв.

2024 онд Израил болон түүний хүчирхэг холбоотнууд, тэр дундаа АНУ тэргүүтэй улс орнууд олон улсын шүүхийн шийдвэр, Олон улсын эрүүгийн шүүхийн яллах дүгнэлтийг санаатайгаар үл тоомсорлож, олон улсын эрх зүй тэдэнд үйлчлэхгүй мэт мэдэгдэл хийж, үйл ажиллагаа явуулав.

2024 онд Ерөнхийлөгч Владимир Путин Украин дахь энгийн иргэдийн амьдарч буй орчин руу удаа дараа халдан 2023 оноос илүү олон энгийн иргэдийг хөнөөлөө. Украины дулааны цахилгаан станцуудын дийлэнх хэсгийг ОХУ устгаж, эсхүл эзлэн авч олон мянган хүний цахилгаан эрчим хүчийг тасалдуулав. Түүнчлэн ОХУ болон Украины эзлэн авсан бүс нутагт олон тооны Украины олзлогсодтой хууль бусаар харьцсан.

2024 онд өрнөсөн дэлхийн хамгийн том албадан нүүлгэлтийн хямрал нүүрлэсэн Судан улсад мөргөлдөөн, өлсгөлөнгийн улмаас олон мянган хүн амь үрэгдэж, Ардчилсан Бүгд Найрамдах Конго, Буркина Фасо, Нигер, Мьянмар зэрэг улсад нэмэгдэж байгаа хоморголон устгалыг дэлхий нийтээр үл тоомсорлолоо. Зэвсгийн худалдааг хязгаарлах боломжийг үл ойшоон, зэвсгийн хориг тавих уриалгыг дүлий мэт өнгөрөөв.

Зүй зохистой эсэх, мөн үзэн ядалтаас улбаалан бий болох хор уршгийг үл харгалзан улс орнууд сошиал медиа алгоритм, олны танил хүмүүсийн дуу хоолойг ашиглан зэвсэгт мөргөлдөөний талаар суртал ухуулга хийх, үүнийг улам ихээр явуулах эрмэлзэлтэй байгааг 2024 он бидэнд бэлхнээ харууллаа.

Товчхондоо 2024 он бидний хүнлэг байдлыг шалгалаа.

ОЛОН УЛСЫН ШҮҮХ БОЛОН ОЛОН ТАЛТ ҮЗЭЛ

Харин өөр сонголт хийх боломж байгаа гэдгийг Өмнөд Африк улс бидэнд харууллаа. Геноцидийн конвенцийг зөрчсөн хэмээн Израил улсын эсрэг Олон улсын эрүүгийн шүүхэд Өмнөд Африкийн гаргасан маргаан нь шударга ёсны төлөөх чухал алхам юм. Олон улсын эрүүгийн шүүхээс Израилын Ерөнхий сайд Бенжамин Нетаньяху, Батлан хамгаалахын сайд асан Йоав Галлант, Хамас бүлэглэлийн цэргийн дарга Мохаммед Аль-Масри нарыг дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн баривчлах тогтоол гаргасан нь түүхэн амжилт байлаа.

Гэвч Украины хүүхдүүдийг хулгайлсан хэрэгт буруутган Ерөнхийлөгч Путиныг яллах талаарх ОУЭШ-ийн шийдвэрийг тууштай дэмжиж байсан улс орнууд Израилд хандахдаа тэс өөр хариу үйлдэл үзүүлээ. 2024 онд АНУ-ын хэд хэдэн сенатор ОУЭШ-ийн прокурорыг заналхийлж, дараа нь Ерөнхийлөгч Дональд Трамп 2025 онд түүнд санкц тавьсан.

Дэлхийн II дайны дараа бий болгосон дүрэмд суурилсан НҮБ-ын тогтолцоо ялгавартай үйлчилж байгаа тухай харамсаж суух цаг нэгэнт өнгөрсөн. 2024 онд улс орнууд тус тогтолцооны институц болон үнэт зүйлсийнх нь эсрэг ажилласны улмаас анх байгуулах болсон үндсэн зорилгынх нь багахан хэсэг тэсэж үлдэв.

Ужгирч бугласан гажуудлынх нь супер хурдасгуур бол Ерөнхийлөгч Трамп юм.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БОЛОН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ: АЮУЛЫН ХАРАНГА ДЭЛДЭВ.

2020 онд Эмнести Интернэшнл улс орнуудын дарангуйллын хандлагын талаар анхааруулсан. Бидний энэхүү санаа зовнил зөв байжээ. 2024 онд дарангуй хууль олноор баталж, хэрэгжүүллээ. Хүмүүсийг хоморголон баривчлах мөн хүчээр алга болгох явдлууд гарч өөр үзэл санаатай хүмүүсийн эсрэг халдлага дайралт эрчимжлээ. Олон ТББ, улс төрийн намуудыг “хэт туйлшрагч” хэмээн дур зоргоор тодорхойлж, хүчээр татан буулгаж, үйл ажиллагааг нь зогсоож, ониллоо. Иргэний үл захирагдахуйн эсрэг хэр хэмжээнээс хэтэрсэн хариу арга хэмжээ авч хүний эрх хамгаалагчид, уур амьсгалын эсрэг тэмцэгчид, оюутнууд болон Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн бусад хүмүүсийг урьд өмнө хэзээ ч байгаагүй хэмжээнд эрүүгийн ялаар шийтгэлээ. Тэдний олонхийг “террорист” хэмээн цоллов. Феминистууд, эмэгтэйчүүд болон ЛГБТИ хүмүүсийн эрхийн төлөө тэмцэгчид асар ширүүн эсэргүүцэлтэй тулгарсаар байна. Наанадаж 21 улсад үг хэлэх эрх чөлөөг дарангуйлж, хэвлэлийн эрх чөлөөг хориглох зорилготой хуулийн төслийг өргөн барьсан. Амиа алдсан сэтгүүлчдийн тоо 2024 онд өсөн нэмэгдэж урьд байгаагүй хэмжээнд хүрсэн. Сэтгүүлчдийг хамгаалах хороо ТББ-ын мэдээлсэнээр өнгөрсөн онд хамгийн багадаа 124 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан амь үрэгдсэний бараг гуравны хоёр нь Израилын гарт амиа алдсан Палестинчууд байлаа.

«УХААД БАЙ, УХААД БАЙ» ГЭДЭГ НЬ «ШАТААГААД БАЙ, ШАТААГААД БАЙ» ГЭСЭНТЭЙ УТГА НЭГ БУС ҮҮ

2024 онд уур амьсгалын хямралд өртөөгүй бүс нутаг гэж үлдсэнгүй. Өмнөд Азид хэт хүчтэй халалтын дараа нүүрлэсэн үерийн гамшигт олон сая хүн өртөж, олон мянган хүнийг нүүлгэн шилжүүллээ. Өмнөд Америкт гарсан урьд өмнө тохиож байгаагүй түймрийн улмаас Амазоны ширэнгэн ой шатаж, улс орнуудыг бүхэлд нь хамарсан экосистемийг сүйтгэлээ. Сомалид ган гачиг, үерт олон хүн нэрвэгдэж, орон нутгийн эдийн засаг сүйрч, гэр бүлүүдийг, олон тооны иргэдийг нүүлгэн шилжүүлэв.

2024 он бол дэлхийн дундаж температур 1850-1900 оны дунджаас 1.5 хэмээс дээш өссөн анхны хуанлийн жил байлаа.

Аагим халуун температурын өсөлт нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа явуулах шинэ санаачилгыг шаардаж байна. Гэвч

улс орнууд чулуужсан түлшний хэрэглээг үе шаттайгаар зогсоох үүрэг амлалтаа биелүүлж чадаагүйн дээр COP29 хэлэлцээр нь бага орлоготой орнуудыг өрийн дарамтын эргэлтэд оруулах эрсдэлтэй санхүүжилтийн гэрээ байгуулахад хүргэлээ.

Ерөнхийлөгч Трампын «ухаад бай, ухаад бай» гэж хэлсэн нь 2025 онд АНУ-ын Парисын уур амьсгалын хэлэлцээрээс гарах шийдвэрийг зөгнөж, үүнийг чулуужсан түлшнээс хамааралтай бусад улс орнууд сайшаан дэмжлээ.

Үүний уршгаар цаашид дэлхий даяар олон хүн шатсаар, живсээр, амиа алдсаар байх болно.

САЯ САЯ ХҮНИЙ ЭСРЭГ ХОРТ ХОЛИМОГ

Дэлхийн банк 2024 онд «Ядуурал, хөгжил цэцэглэлт ба дэлхий өртөнц: олон хямралаас гарах зам» тайландаа .."Дэлхийн ядуурлын бууралт сүүлийн таван жилийн хугацаанд бараг зогсонги байдалд орсон нь 2020-2030 оныг алдагдлын арван жил болох вий гэсэн болгоомжлолыг төрүүлж байна»... хэмээн анхааруулсан.

Ядуурал, мөргөлдөөн, улс төрийн дарангуйлал, уур амьсгалын хямрал зэрэг хорт холимогийн уршгаар 2024 онд ойролцоогоор 110 сая хүн нүүлгэн шилжүүлэлтэд өртөв. Гэвч улс орны засгийн газрууд, улс төрийн хөдөлгөөнүүд үндсэн шалтгааныг арилгахын оронд гааднынхныг үзэн ядах, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэн ядалтыг өдөөн турхирсан үг хэллэгийг зэвсэг болгон ашиглаж байна. Тэд шүүхийн шийдвэрийг үл тоомсорлож эсхүл тойрон гарч, өөрийн улсад хууль бусаар ирж буй хүмүүсийг зогсоохын тулд ноцтой арга хэмжээ авч хэрэгжүүлээ.

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ ХАА БАЙНА? ЭМЭГТЭЙЧҮҮД, ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ХАЛДЛАГА

Афганистан улс дахь нийт хүн амын 50%, түүний дотор охид, эмэгтэйчүүд "чимээгүй үхэл"-д өртөж байна.

Талибаны засгийн газар охид, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог гэмт хэрэгт тооцож, хөдөлмөрлөх, сурч боловсрох эрхийг нь үгүйсгэсэн "ёс суртахууныг дэмжиж, ёс суртахуунгүйг эсэргүүцэх" (vice and virtue laws) гэсэн нэр бүхий хууль, тогтоомж баталлаа. Жагсаал цуглаанд оролцсон олон арван эмэгтэйг хүчээр алга болгож, дур зоргоороо цагдан хорив.

Иран улсын нүүрээ халхлах тухай шинэ хууль нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг дарангуйллыг эрчимжүүлж, ташуурдах шийтгэл болон үлэмж хэмжээний торгууль ногдуулах, хатуу хорих ялаар шийтгэж байгаа бол эсрэгээрээ охид, эмэгтэйчүүдийг хууль зөрчсөнийх нь төлөө ноцтой халдлага үйлдсэн албан тушаалтнууд, хууль зөрчигчид ял шийтгэл хүлээдэггүй байна.

Аргентинаас эхлээд ОХУ зэрэг олон улс орнуудын засгийн газар бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг хязгаарласан хууль, бодлогыг нэвтрүүлснээс гадна ЛГБТИ хүмүүсийн эрхийг зөрчих явдал улс орнуудад улам бүр газар авсаар байна. АНУ-д Meta болон TikTok үр хөндөлтийн талаарх зарим цахим мэдээллийг устгасан. Түүнчлэн, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа эмэгтэй хүний амь насыг хөнөөх, зэвсэгт мөргөлдөөн дэх бэлгийн хүчирхийлэл дэлхийн улс орнуудад нэмэгдэж байна.

ЭНЭ НЬ НЭГ ЭРИН ҮЕИЙН ТӨГСГӨЛ ГЭЖ ҮҮ?

Хүчирхэг улс гүрнүүд бидний түүхэн амжилтыг тохуурхан даажигнаж байна. Тэд 1930, 1940-өөд оны сургамж болох Геноцидийн эсрэг конвенцоос эхлээд Женевийн конвенц, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, НҮБ-ын дүрэм зэргийг үл тоомсорлож, үгүйсгэж, үгүй хийж болно хэмээн үзэж байна.

Дональд Трамп сонгогдож, засаг захиргаанд нь томоохон корпорацууд шургалснаар цэрэг, эдийн засгийн хүчээр хүний эрх, дипломат харилцааг дэвсэлж, жендэрийн болон арьс өнгөний дээрэнгүй үзэл, бодлогыг тодорхойлж, бусдыг үгүйсгэсэн үндсэрхэг үзлээр олон улсын харилцааг хардаг харгис эрин рүү бид шидэгдчихлээ.

БИД ХЭРХЭН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ВЭ?

2024 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гишүүн 193 улс түүхэнд анх удаа хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн конвенци байгуулах арга замыг эрэлхийлэхээр хэлэлцэн тохиролцсон. Мөн 2024 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей Олон улсын татварын хамтын ажиллагааны суурь конвенцыг бий болгож, татварыг буруугаар ашиглах явдлыг таслан зогсоох олон улсын хамтын ажиллагааны замыг нээж, хүний эрхийг хангахад шаардлагатай чухал санхүүжилт олгохоор тохиролцсон. 2024 онд Гамби улс эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг хориглох 2015 оны нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг буцаасан. Польш улс зөвшилцөлд хүрээгүй бол хүчинд тооцох зохицуулалттай Европын 19 дэх улс болсон бол Болгарын парламент гадаадын агентуудын бүртгэлийг бий болгох Оросын загвар бүхий хуулийн төслийг дэмжсэнгүй. 2024 онд Бельгийн үндэсний шүүхүүд колоничлолын үед тус улсын үйлдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн 2025 оны эхээр Филиппиний эрх баригчид Ерөнхийлөгч асан Дутертег хар тамхитай тэмцэх дайны үед олон хүнийг хоморголон алсан үйлдлийнх нь төлөө хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган ОУЭШ-д хүлээлгэн өгсөн юм.

2024 оны 9 дүгээр сард болсон Ирээдүйн төлөөх НҮБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр улс орнууд олон төрлийн асуудалтай нүүр тулгарав. Гэвч улс орнууд Аюулгүйн зөвлөлд олон орны, тэр дундаа Африкийн төлөөллийг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн бүтцийг өөрчлөх, өрийн хямралыг шийдвэрлэх, хөгжлийн санг нэмэгдүүлэх замаар илүү тэгш эрхтэй олон улсын тогтолцоог бий болгохоор тохиролцов.

Хамгийн чухал нь 2024 онд дэлхий даяар 64 улсад өрнөсөн сонгуулийн жилд хүний эрхийн эсрэг хүчнийхэн ялалт байгуулсангүй. Дэлхий даяар олон олон иргэд өөр замыг сонгохын төлөө саналаа өгсөн нь авторитар дэглэм түгэх нь зайлшгүй, гарцаагүй тохиох зүйл биш, үүнийг эсэргүүцэх боломжтой гэдгийг бидэнд харууллаа.

Ирээдүй тодорхой биш, дэлхий ертөнц олон замын уулзварт ирлээ. Трампын засаглал эхэлснээс хойш зуун хоног болоход зарим улс түүний бодлогыг сөрж, дийлэнх нь чимээгүй харзнаж байна. Хааны хувцас сайхан зохижээ гэж цөөнгүй хэд нь магтаад өөрсдөө ч тийм хувцас өмсөж дуурайх ажээ. Нүцгэн үнэн нь тэс өөр байна: үзэл бодлыг хянаж, академик эрх чөлөөг боомилж, цэргийн зардлыг нэмж, тусламжийг цөллөмж, худалдааг зэвсэг болгож байна. Энэ бол гүнзгий хямарсан дэлхий ертөнцийн нүцгэн үнэн юм.

Тийм ээ, хүний эрхийг дээдлэж чадаагүй олон улсын системийн гажигийг бид өнөөдөр засах ёстой. Гэтэл тэгш эрх, шударга ёсыг хангахын оронд хүний эрхийг хамгаалахгүй хаясан. Шударга ёсыг дээдэлж хууль ёсыг хамгаалахын оронд шударга ёсыг хөсөрдүүлж ашиг хонжоог хамгаалсан цоо шинэ системийг цогцлоохоор улангасан зүтгэж байгаа хүчинтэй бид туллаа.

Эдгээр хүчний эсрэг зохион байгуулалттайгаар тэмцэх нь зүгээр нэг чухал зүйл биш ээ, энэ бол бидний цорын ганц хууль ёсны арга зам юм. Иргэний нийгмийн байгууллагууд болон хүний эрх хамгаалагчид урьдын адил улс орнуудын хүний эрхийн зөрчлийн эсрэг сөрөн зогсож, бидний нийтлэг эрхэм чанарт увайгүй байдлаар халддаг эрх мэдэл, эд баялгийн дэглэмийг эсэргүүцсээр байна. Иргэний нийгэм бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тэргүүн эгнээнд үргэлж зогсож байдгийг тэд дахин батлан харууллаа.

Бид эсэргүүцэх ёстой. Бид эсэргүүцсээр байх болно.

Агнес Калламард
Ерөнхий нарийн бичгийн дарга
2025 оны 4 дүгээр сар

ДЭЛХИЙ ДАХИНЫ

ХҮНИЙ ЭРХИЙН

ТӨЛӨВ БАЙДАЛ

**ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ,
БҮС НУТГИЙН ТОЙМ**



ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмнести Интернэшнлийн 2024 онд хийсэн судалгаа зэвсэгт мөргөлдөөний үеэр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн, өөрөөр сэтгэгчдийг нухчин дарсан, ялгаварлан гадуурхалт, эдийн засгийн болоод уур амьсгалын шударга бус байдал, технологийг урвуулан ашиглаж хүний эрхийг зөрчсөн явдал байгааг дэлхийн хүний эрхийн чиг хандлагын гол сэдэв хэмээн онцоллоо. Зарим нэг эерэг өөрчлөлтийг эс тооцвол, улс орнуудын ялангуяа хүчирхэг улсууд олон улсын дүрэмд суурилсан тогтолцоог сүйтгэж, өөр өөр тивд дарангуйлал тархахад ихээр нөлөөлсөн хүний эрхийн энэ төлөв 2025 он болон түүнээс хойш улам даамжирсан хүний эрхийн ухралт руу түлхэж болзошгүй байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ХҮЧИРХИЙЛЭЛ

2024 онд өөр өөр улсад өрнөсөн дайны гэмт хэрэг, Газын зурвас дахь геноцидтэй энгийн иргэд нүүр тулсан бөгөөд энэ байдал 2025 онд ч үргэлжилсээр байна. Олон улсын шударга ёсны механизм зарим хэрэгт хариуцлага тооцох чухал алхмыг хийсэн боловч хүчирхэг улсын засгийн газрууд харгислалыг таслан зогсоох дорвитой арга хэмжээ авах оролдлогод удаа дараа хаалт хийв.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Этиоп, Ирак, Израил болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Ливи, Мали, Мозамбик, Мьянмар, Нигер, Нигери, Судан, Өмнөд Судан, Сомали, Сири, Украин, Йемен зэрэг улсад өрнөж байгаа зэвсэгт мөргөлдөөн дэлхийн сая сая хүний амьдралыг сүйтгэж байна. Мөргөлдөөнд оролцогч талууд болох засгийн газрын зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэд болон иргэний дэд бүтцэд шууд халдах, энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдэж хөнөөх, шархдуулах зэргээр дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн.

Олон хүн, ялангуяа эмзэг гадуурхагдсан бүлгийн иргэд боловсрол, хоол хүнс, ус, шаардлагад нийцсэн орон байр, эрүүл мэнд, аюулгүй байх эрхээ эдэлж чадсангүй. 2024 оны наймдугаар сард НҮБ-аас Суданы дүрвэгсдийн Замзам хуаранд өлсгөлөн нүүрлэсэн болохыг зарласан. 2024 онд 11 сая дотооддоо шилжин суурьшигчидтай Судан улс дэлхийн хамгийн том дүрвэгсдийн хямралтай тулгарч байна. Орос улс Украины хүн ам төвлөрсөн төвүүд дэх энгийн иргэд болон иргэний дэд бүтцийг пуужин, дроноор онилсоор байгаа нь Украины энгийн иргэдийн амьдрах суурь нөхцөлийг огцом дордуулж, хүүхэд, өндөр настан, бусад эрсдэлт бүлгийн хүмүүс илүү ихээр хохирч байна. Мөн Орос улс Украины баривчлагдсан энгийн иргэд болон цэргийн олзлогдогсдыг хүчээр алга болгон, эрүүдэн шүүж зүй бусаар харьцаж байна.

Израилын Газын зурвас дахь үйл ажиллагааны улмаас нас барагчдын тоо ноцтой хэмжээнд хүрч, геноцид үйлдэгдлээ. Үүний зэрэгцээ, Израилын апартейд, хууль бус эзлэн түрэмгийллийн тогтолцоо нь эзлэгдсэн Баруун эрэгт улам ширүүсэж, дур зоргоор цагдан хорих, хуулиас гадуурх аллага үйлдэх, Израилын оршин суугчид Палестины энгийн иргэд рүү төрийн дэмжлэгтэйгээр халдах явдал эрс нэмэгджээ.

2024 онд зарим улс оронд мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн хэргүүд ноцтой хэмжээнд хүрсэн. ТАБНУ-д оны эхний хагасын байдлаар жендэрт суурилсан хүчирхийллийн 11,000 гаруй тохиолдол бүртгэгджээ. Тус улсад Шуурхай туслах хүчний гишүүд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн болохыг НҮБ-ын Суданы асуудал эрхэлсэн олон улсын бие даасан төлөөлөгчийн газар тогтоожээ.

Зэвсэгт мөргөлдөөн дэх зарим зөрчил охид, эмэгтэйчүүдэд илүү хүнд тусаж байна. Газад өрнөсөн албадан нүүлгэлтийн ар араасаа үргэлжилсэн давлагаа нь сая гаруй палестинчуудыг хүнлэг бус нөхцөлд хүргэж, ялангуяа жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд илүү их уршиг авчирлаа. Сирийн зүүн хойд хэсэгт эрэгтэй хамаатныг нь Исламын улсын зэвсэгт бүлэглэлтэй холбоотой байж болзошгүй гэх үндэслэлээр олон мянган охид, эмэгтэйчүүдийг ямар нэг ял шийтгэл болон шүүх хуралгүйгээр хоуран, хорих газарт таван жил гаруйн хугацаанд хорьсоор байна.

Израилд улс төрчид палестинчуудын эсрэг хүнлэг бус үг хэллэг ашиглах, арьс үндсээр нь системтэйгээр ялгаварлан гадуурхаж, зөрчилдөөнийг улам өрдлөө. Мьянмарт Рохинжа нар арьс үндсээр ялгаварлан гадуурхах дайралтад өртсөөр байгаа нь олон хүнийг Ракхай дахь эх нутгаасаа дүрвэхэд хүргэжээ. Суданд зарим Шуурхай туслах хүчнийхэн угсаатныг ялгаварлах үзэлд үндэслэн энгийн иргэд рүү халдлага үйлдсэн. Үүний зэрэгцээ Орос улс Украины эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн ам зүйн байдлыг өөрчлөхийг хичээж, Украин болон бусад орон нутгийн хэл, соёлыг дарангуйлсаар байна.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын үйлдэж буй гэмт хэргийн эсрэг дэлхий даяар сая сая хүмүүс эсэргүүцлээ илэрхийлж байна. Гэвч олон талт байгууллагууд, ялангуяа НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг дагаж мөрдөх, хүмүүнлэгийн тусламжийг энгийн иргэдийн хэрэгцээнд нийцүүлэхийн тулд зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудад шахалт үзүүлэх боломжгүй, эсхүл ийм хүчин чармайлт гаргахыг хүссэнгүй. Үр дагаварт нь эдгээр байгууллага хууль ёсны байдлаа алдаж, цаашид оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болж байна.

2024 оны турш засгийн газрууд дангаараа болон олон талт хамтын ажиллагаагаараа ч харгислал хэрцгийллийг таслан зогсоох дорвитой арга хэмжээ авсангүй. АНУ, Их Британи болон ЕХ-ны олон улс Израил улсын Газын зурваст явуулж буй үйл ажиллагааг илт дэмжсэн. АНУ хориг тавих эрхээ урвуулан ашигласны улмаас НҮБ-ын Аюулгүйн зөвлөл хэдэн сарын турш үр дүнтэй арга хэмжээ авч чадаагүй бөгөөд зөвхөн 2024 оны 3 дугаар сарын 25-нд нэн даруй боловч хэсгчлэн гал зогсоохыг уриалав. Тэр үед ч АНУ өөрийн холбоотноо дээрх шийдвэрийг дагаж мөрдөхөөс хамгаалахын тулд уг тогтоолыг хүчин төгөлдөр бус хэмээн зарлаж Аюулгүйн Зөвлөлийн үйл ажиллагааг саатуулсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2024 оны 9 дүгээр сард Израилыг Палестины эзлэн түрэмгийллээ 12 сарын дотор зогсоохыг шаардсан тогтоол, 2024 оны 12 дугаар сард Газад бүрмөсөн гал зогсоож, барьцаалагдсан бүх хүнийг суллах, хүмүүнлэгийн тусламжийг Газын нутаг дэвсгэрт бүрэн, түргэн шуурхай, найдвартай, аюулгүй нэвтрүүлэхийг шаардсан хоёр тогтоолыг баталж, Палестины дүрвэгсдийн асуудал эрхэлсэн НҮБ-ын агентлагт бүрэн дэмжлэг үзүүлэхээ дахин баталгаажуулсан. 2024 оны арван нэгдүгээр сард Суданд энгийн иргэдийн эсрэг халдлагыг зогсоохыг шаардаж, тэнд гачигдаж байгаа сая сая хүмүүст хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг уриалсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд ОХУ хориг тавьсан.

Засгийн газрууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг шинэчлэх шаардлагатай бөгөөд ингэснээр байнгын гишүүд хориг тавих бүрэн эрхээ харгис хэрцгий гэмт хэргийг таслан зогсоох, шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд саад учруулахад ашиглахгүй байх ёстой. Мөн тусламж хэрэгцээтэй байгаа энгийн иргэдэд үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

ХАРИУЦЛАГА

Афганистан, Нигери зэрэг зарим улсад хариуцлага тооцох арга хэмжээ хангалтгүй байсан ч Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) Израил, Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Ливи, Мьянмарт хариуцлага тооцох чиглэлээр чухал алхмуудыг хийлээ. 2024 оны 10 дугаар сард ОУЭШ-ээс Ливи дэх Аль-Каниат зэвсэгт бүлэглэлийн зургаан удирдагч, ахлах болон бусад гишүүдийг дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах шийдвэр гаргаснаа зарласан. 2024 оны арван нэгдүгээр сард ОУЭШ-ын прокурорын зүгээс тэргүүн генерал /Senior General/ Мин Аун Хлайнг 2017 онд явуулсан цэргийн ажиллагааны үеэр Рохинжа нарын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах хүсэлт гаргасан. Мөн сард ОУЭШ-ээс Израил болон Хамас бүлэглэлийн удирдагчдыг дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр баривчлах шийдвэр гаргасан.

Зарим улс Израилын албан тушаалтнуудыг баривчлах талаарх ОУЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхээ тодотгов. Харин Израилын хэд хэдэн холбоотон энэ шийдвэрийг хэрэгжүүлэхгүй гэдгээ зарлав. Ромын дүрмийн оролцогч тал болох Монгол Улс ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиныг 2024 оны есдүгээр сард тус улсад айлчлах үеэр дайны гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах тухай ОУЭШ-ийн 2023 оны гуравдугаар сард гаргасан шийдвэрийг биелүүлсэнгүй.

2024 онд Олон улсын шүүх Геноцидийн конвенцыг үндэслэн Израилын эсрэг Өмнөд Африкийн гаргасан хэргийн дагуу гурван багц түр арга хэмжээ авч, Палестины газар нутгийг Израил улс эзлэн түрэмгийлсэн нь хууль бус хэмээн үзэж зөвлөх дүгнэлт гаргасан. Бельги, Испани зэрэг зарим улс НҮБ-ын шинжээчдийн гаргасан Израил руу зэвсгийн экспортоо зогсоох уриалгыг биелүүлэв. Иргэний нийгмийн байгууллагууд Дани, Франц, Нидерланд, Их Британи зэрэг орнуудын зэвсэг нийлүүлэлтийг эсэргүүцэж шүүхэд нэхэмжлэл гаргасан. АНУ Израилд хамгийн том зэвсэг экспортологч хэвээр байна. Чех, Франц, Герман зэрэг Европын зарим улс урьд өмнө үйлдсэн зөрчилдөө хариуцлага хүлээгээгүй байгаа Израил, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират зэрэг хүний эрхийн ноцтой зөрчил үйлдэх, эсхүл дэмжих эрсдэлтэй улс орнуудад зэвсэг нийлүүлсэн хэвээр байна.

Засгийн газрууд ОУЭШ-д дэмжлэг үзүүлж, ОУЭШ болон ажилтнуудыг нь хориг арга хэмжээ болон бусад аюул заналхийллээс хамгаалах шаардлагатай. Мөн хариуцлагагүй зэвсэг нийлүүлэлтийг зогсоох ёстой.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ ДАРАНГУЙЛСАН НЬ

Улс орнуудын эрх баригчид өргөн хүрээнд дарангуйллын арга хэрэглэж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах шинэ арга хэмжээг нэвтрүүлсэн. Тэд энэ аргыг болон бусад хууль тогтоомжийг хүний эрх хамгаалагч, шүүмжлэгч, өрсөлдөгчдийг дарангуйлах, эсвэл өөрсдийгөө хариуцлагаас мултлах, эрх мэдлээ бэхжүүлэх арга болгон ашигласан.

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

2024 онд Аргентин, Гүрж, Никарагуа, Пакистан, Перу зэрэг улсад жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласан шинэ зохицуулалтыг баталж, эсхүл ийнхүү хязгаарлах санал оруулав. Турк зэрэг зарим улсад эрх баригчид эсэргүүцлийн жагсаалыг бүхэлд нь хориглосон.

Аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаалыг ихэвчлэн харгис хэрцгий, амь насанд аюултай байдлаар тарааж, нухчин дарахын тулд олноор нь хоморголон дур зоргоор баривчилж, хүчээр алга болгосон. 2024 онд Бангладеш, Египет, Гүрж, Гвиней, Энэтхэг, Индонез, Йордан, Кени, Мозамбик, Балба, Нигери, Пакистан, Сенегал зэрэг улсууд олон тооны жагсагчдыг хөнөөж, хоморголон баривчилсан. Бангладеш улсад өрнөсөн оюутнуудын эсэргүүцлийн жагсаалын үеэр зэвсэгт

хүчнийхнийг байрлуулж, «харсан даруй буудах» тушаал өгснөөс мянга орчим хүн нас барж, олон хүн шархаджээ.

Канад, Египет, Фижи, Финлянд, Герман, Энэтхэг, Итали, Малайз, Мальдив, АНУ зэрэг дэлхийн өнцөг булан бүрт Газын зурвас дахь дайныг зогсоох, Палестины эрх ашгийг хамгаалахыг дэмжигчид хүчирхийлэл, дарамт шахалт, баривчилгаанд өртсөөр байна.

Жагсагчдын эсрэг амь насанд аюултай, үхэлд хүргэх зэвсгийг ашиглаж байгаа нь дэлхий даяар хүний амь нас хохироход хүргэсээр байна. Гэхдээ Эрүүдэн шүүхээс ангид худалдааны олон улсын, заавал биелүүлэх гэрээ байгуулах дэлхий дахины иргэний нийгмийн кампанит ажил хүрээгээ тэлж, гэрээ байгуулах хэрэгцээнд улс орнуудын анхаарлыг хандуулж, НҮБ-ын хэд хэдэн тусгай процедурын дэмжлэгийг авсан.

2024 оны 7 дугаар сард Баруун Африкийн улсуудын эдийн засгийн нийгэмлэгийн шүүхээс Нигер улсыг #EndSARS эсэргүүцэгчдийн эрхийг зөрчсөн хэмээн үзсэн бол 5 дугаар сард Их Британид жагсаал цуглааныг хязгаарлах цагдаагийн эрх мэдлийг нэмсэн зохицуулалтыг хууль бус хэмээн үзэн цуцалсан нь эерэг алхам байлаа.

2024 оны арван хоёрдугаар сард Өмнөд Солонгосын ерөнхийлөгч цэргийн онц байдал зарласны дараа үндсэн эрх, тэр дундаа тайван жагсаал, цуглаан хийх эрхийг түдгэлзүүлэх үед ард түмэн дээрх шийдвэрийг эсэргүүцсэн. Үндэсний Ассамблей уг асуудлыг шуурхай өөрчилж, ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулсан.

Засгийн газрууд жагсагчдын эсрэг амь насанд халтай зэвсгийг хууль бусаар ашиглахыг зогсоож, НҮБ-ын Эрүүдэн шүүхээс ангид худалдааны гэрээг хэлэлцэх, батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагатай.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

2024 онд Афганистан, Бангладеш, Беларусь, Буркина Фасо, Хятад (Хонконг оруулаад), Экваторын Гвиней, Гамби, Гүрж, Герман, Энэтхэг, Киргиз, Лесото, Молдав, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Орос, Шри Ланка, Тажикстан, Узбекистан, Вьетнам зэрэг улсад үг хэлэх эрх чөлөөг дарангуйлах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох эрсдэлтэй хууль, хуулийн төслийг өргөн барьж, эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах, шинэ хязгаарлалт нэвтрүүлэхийг оролдсон.

Кот-д’Ивуар, Этиоп, Гүрж, Гвиней, Унгар, Киргиз, Никарагуа, Парагвай, Орос, Руанда, Тажикстан, Тайланд, Тунис, Уганда, Венесуэл зэрэг улсын эрх баригчид эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах шинэ арга хэмжээг авч ТББ, улс төрийн намуудыг татан буулгах, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, эсвэл «хэт даврагч» гэж цоллох арга хэмжээ хэрэгжүүлсэн.

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд халдсан дайралт өргөн хүрээнд үргэлжилсээр байна. Засгийн газрын дарангуйллын тактикуудад шүүмжлэгчид болон эсэргүүцэгчдийг дур зоргоор цагдан хорих, эрүүдэн шүүх, шударга бусаар ял шийтгэх, тагнах программ ашиглах зэрэг багтсан. Зарим тохиолдолд шүүмжлэгчдийг хууль бусаар алж, хүчээр алга болгож, цаазаар авах ял оноож байна. Тэдгээр онилогдсон хүмүүсийн дотор сэтгүүлчид, цахим сэтгэгдэл бичигчид, улс төр, үйлдвэрчний эвлэлийн идэвхтнүүд, хүний эрх хамгаалагчид, тэр дундаа эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, ЛГБТИ хүмүүс, гадуурхагдсан бүлгийнхэн багтжээ. 2024 онд Беларусь, Хятад, Киргиз, Орос, Саудын Араб, Тажикстан, Турк зэрэг улсад хүмүүсийг шударга бус шүүх хурлын дараа цахим олон нийтийн сүлжээгээр дамжуулан зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө эдэлснийх нь төлөө «терроризм» эсвэл «хэт даврагч үзэл»-тэй холбоотой эрүүгийн хэрэгт буруутган хорих ял оноожээ.

Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн хууль тогтоомж, практикийг хүчингүй болгох шаардлагатай.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Орогнол эрэгч, цагаачдын асуудлыг шийдвэрлэхэд улс орнуудад арьс үндэс, бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах хандлага давамгайлснаас гадуурхагдсан бүлгүүдийн эрх ноцтой хөндөгдөж байна. Үүнтэй зэрэгцээд, цаашид хүний эрхийг хязгаарлан хуульчлах, эрх мэдэлтнүүдийн хяналтын бүрэн эрхийг улам бэхжүүлэхийн тулд улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд заналхийлсэн хэмээн гадуурхагдсан бүлгүүдийг үндэслэлгүйгээр буруутгасаар байна. 2024 онд ЛГБТИ хүмүүсийн эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хүрээнд ахиц дэвшил, бас үхралт ч гарсан.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Арьс үндсээр ялгаварлан гадуурхах, дарангуйллын хэлбэрүүд нь олон улс оронд орогнол, цагаачлалын асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлсөөр байна. Ялгаварлан гадуурхах бодлого, үйл ажиллагаа цагаачид, дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүс, арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан бүлгүүдэд илүүтэй сөргөөр нөлөөлж байна.¹ Канад, Катар, Саудын Араб зэрэг хэд хэдэн улсад арьс үндсээр ялгаварлан гадуурхсан, цагаач ажилчдыг тодорхой ажил олгогчтой уялдуулсан визний схем ашиглан хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлийг нь нэмэгдүүлж байна. Мөн улс орнууд, төрийн бус оролцогч талууд цагаачлалын менежмент, орогнол олгох системд зүй бус цахим технологийг хэрэглэж, буруугаар ашигласан.²

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд хууль бусаар хил нэвтрэхээс сэргийлж, энэ тохиолдолд буцаахын тулд туйлын ноцтой, хүчирхийллийн арга хэмжээ авч байна. Эдгээрт, дүрвэгсэд болон цагаачдыг хариуцах үүрэг хариуцлагыг өөр улсад шилжүүлэх, хилийг хаах, бөөнөөр нь буцаах зэрэг арга хэмжээ багтсан. 2024 онд Египет улс олон зуун Суданы дүрвэгсдийг албадан буцаахаасаа өмнө дур зоргоор саатуулсан. Тэд хөрш зэргэлдээ орнуудад ихэвчлэн хүнд нөхцөлд амьдарч буй Суданы 3.2 сая гаруй дүрвэгсдийн нэгээхэн хэсэг юм. Пакистаны эрх баригчид хэдэн зуун мянган дүрвэгсдийг Афганистан руу хууль бусаар албадан буцаажээ. АНУ улс төрийн орогнол хүсэгчдийг АНУ-Мексикийн хилээр нэвтрүүлэхийг түдгэлзүүлсэн нь тэднийг хууртагдан мөнгөө алдах, хулгайлагдах, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөхөд хүргэж байна. Беларус ЕХ-той хил дагуу дүрвэгсэд болон цагаачдыг албадан гаргасаар байгаа нь зарим хүмүүсийг амь насаа алдахад хүргэсэн. Европын бусад орон болон ЕХ цагаачлалын менежментээ гуравдагч орноос хараат байдлаа бууруулж, дүрвэгсэдэд аюулгүй, хууль ёсны зам гаргаж чадсангүй.

Засгийн газрууд цагаач, орогнол хүсэгчид, дүрвэгсдийн эрхийн талаарх шүүхийн шийдвэрийг үл тоомсорлож, биелүүлэхээс зайлсхийн хууль дээдлэх ёсыг алдагдуулж байна. Грек улс Европын Хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийг үл тоомсорлов. Тухайлбал, 2014 онд далайд саатуулах ажиллагааны үеэр Грек улс хүний амьд явах эрхийг зөрчсөн хэмээн 2024 онд Европын хүний эрхийн шүүх шийдвэрлэсэн хэдий ч, эргийн хамгаалалтынхан хилийн хяналтын ажиллагааны үеэр галт зэвсэг ашигласаар байгаа нь санаа зовоосон асуудал хэвээр үлдэв. 2024 онд Их Британи улс орогнол хүсэгчдийг албадан буцаахад Руанда улсыг аюулгүй улс хэмээн үзээгүй бөгөөд Дээд шүүхийн 2023 оны шийдвэрийг хүчингүй болгохыг оролдлоо. Засгийн газар солигдсоны дараа уг схемийг цуцалсан юм.

Нөгөө талаар дэлхий даяарх олон нийтийн дэмжлэг бүхий бүлгүүд эв санаа нэгтэйгээр арьс үндсээр ялгаварлан гадуурхах, алагчлах явдлыг эсэргүүцсээр байв.

Засгийн газрууд тэгш бус байдал, алагчлалыг үр дүнтэй шийдвэрлэх цагаачлалын бодлогыг хэрэгжүүлэх ёстой.

АРЬС ҮНДСЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ

Арьс үндэс, угсаатны болон үндэсний цөөнх болон бусад байдлаар ялгаварлан гадуурхагдсан бүлгүүд системийн ялгаварлан гадуурхалт, хавтгайрсан тэгш бус байдалтай тулгарсаар байгаа нь тэдний хүний эрхэд ноцтой нөлөөлж байна.

2024 онд Тайваний уугуул иргэд Мандарин хэл дээрх хувилбараар бус уугуул нэрээ албан ёсны баримт бичигт ашиглах эрхтэй болсон нь нааштай өөрчлөлт юм. Гэвч уугуул иргэдийн эрхийг хүндэтгэх талаар хэд хэдэн улсад ухралт гарсан. Шинэ Зеландын засгийн газар Маоричуудын эрхийг дордуулсан шинэ хуулиудыг баталж, Боливи, Индонези, Малайз зэрэг улсын засгийн газрууд уугуул хүмүүсийн газар дээр олборлох болон бүтээн байгуулалтын төслүүдийг тэдний чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэй зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлсэн.

Хууль сахиулах, нийгмийн халамж зэрэг салбарт арьс үндсээр ялгаварлах институцлэгдсэн үзэл улам бүр даамжирч байгаа нь шударга бус байдлын үр нөлөөг илтгэж байна. Америк тивд хууль сахиулах ажиллагааны үр дагавар Бразил, Эквадор, АНУ зэрэг улс орнуудын афро үндэсний үр удамд илүү сөргөөр нөлөөлсөн. Ази тивд Хятад дахь Хан үндэстнээс бусад угсаатнууд, Тажикстан дахь Памирийн цөөнх зэрэг үндэстэн, шашны цөөнхүүд хавчлага, системт ялгаварлан гадуурхалттай тулгарсан. Европ тивд, Норвеги, Швейцар зэрэг улсад арьс үндсээр ялгаварлан гадуурхах шинжтэй үйлдэл бүртгэгдсэн бол Дани, Нидерланд, Шведэд автоматжуулсан халамжийн тогтолцоо арьс үндсээр нь, түүнчлэн эмэгтэй, бага орлоготой гэдгээр нь хүмүүсийг ялгаварлан гадуурхахад хүргэсэн.

Их Британи болон бусад улсад олон нийтийн сүлжээгээр хортой контент олширсон нь арьс үндсээр ялгаварлан гадуурхах, гаднынхныг үзэн ядах үзлийг дэвэргэсэн.

Колоничлолын асуудлаар ажиллаж буй шинжээч, идэвхтэн, байгууллагууд засгийн газруудад колоничлолын өнгөрсөн үе, хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг шийдвэрлэхийг уриалсаар байна. Наймдугаар сард Америк хоорондын Хүний эрхийн комисс институцлэгдсэн арьс үндсээр ялгаварлах үзэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах нь афро гаралтай хүмүүс болон овгийн бүлгүүдэд эрхээ бүрэн эдлэхэд саад учруулж байгааг хүлээн зөвшөөрч, зөрчигдсэн эрхийг сэргээх шударга ёсыг цогцоор нь хэрэгжүүлэхийг улс орнуудад хандан уриалсан. Арван нэгдүгээр сард мэргэжилтнүүд “140 жилийн өмнөх 1884-1885 оны Берлиний Африкийн бага хурлын колоничлолын эсрэг хувилбар” хэмээх Деколониале Берлиний Африкийн бага хурал дээр колоничлолын өнгөрсөн болон үргэлжилж буй нөлөөллийг шийдвэрлэхийг Европын засгийн газруудад уриалав.³

Засгийн газрууд хууль тогтоомж, практикт арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг эцэс болгож, боолчлол, колоничлолоос үүдсэн хүний эрхийн асуудлыг нөхөн сэргээх асуудлыг шийдвэрлэж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлын орчин үеийн хэлбэрүүд дэх эдгээр түүхэн шударга бус байдлын уламжлалыг эсэргүүцэх ёстой.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ

Жендэрийн тэгш байдлыг эсэргүүцэх байдал өргөн агуулгаараа улам бүр хурцадсан. Охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа ялгаварлан гадуурхалтын олон талт, огтлолцсон хэлбэр байсан хэвээр байна. Афганистанд охид, эмэгтэйчүүд жендэрийн дарамт шахалтад (хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг) өртсөөр байгаа бөгөөд Талибанууд 2024 онд илүү хатуу хязгаарлалт тогтоож, тэднийг олон нийтийн амьдралаас бүрмөсөн тасалсан. Аргентинд 2024 онд 33 цаг тутамд нэг эмэгтэй бусдын гарт алагдсан хэрэг бүртгэгдэж байна. Иранд эрх баригчид нүүрээ халхлахыг эсэргүүцсэн охид, эмэгтэйчүүдийг харгис хэрцгийгээр дарах арга хэмжээгээ эрчимжүүлэв.

Хэдийгээр ухралт гарч байгаа ч 2024 онд ЛГБТИ эрхийн талаар тодорхой ахиц дэвшил гарлаа. Тайланд улс ЛГБТИ хүмүүсийн гэрлэлтийн тэгш байдлыг хангасан Зүүн Өмнөд Азийн анхны улс болсон бол Японд ижил хүйстний гэрлэлтийг хориглосныг Үндсэн хуулийн бус хэмээн үзжээ. Грек, Чех улсад ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуульчилсан. Япон, Өмнөд Солонгос, Тайваньд шүүхүүд хүйсээ баталгаажуулахтай холбоотой трансжендэр хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрөхөд ахиц дэвшил гаргасан. Намиби улсын Дээд шүүх ижил хүйстнүүд зөвшилцлийн дагуу бэлгийн харьцаанд орохыг хориглосон хуулийг цуцалсан.

Үүний зэрэгцээ хүний эрх, жендэрийн эсрэг хөдөлгөөнөөс үүдэлтэй ялгаварлан гадуурхсан, дарангуйлсан хуулиудыг дэлгэрүүлэх замаар ЛГБТИ хүмүүсийн эрхийг дарангуйлсаар байна.⁴ Гана, Малави, Мали, Уганда зэрэг улсын хууль тогтоох болон шүүх эрх мэдэлтнүүд насанд хүрэгчдийн хооронд ижил хүйстний бэлгийн харьцааг хориглож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авчээ. Гүрж улс «Гэр бүлийн үнэ цэн ба насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах» тухай хууль тогтоомжийг баталж, ижил хүйстнүүд, трансфобикийн эсрэг олон арга хэмжээ авсан нь Оросын «Гей суртал ухуулгын» хуулийн ихэнх хэсгээс санаа авсан аж. Болгар улс сургуулиудад «ЛГБТИ суртал ухуулга» явуулахыг хориглов.

2024 онд хэд хэдэн улс бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн. Европт Франц улс үндсэн хуульдаа үр хөндөлтийг хамгаалагдсан эрх чөлөө хэмээн тухайлан тусгасан дэлхийн анхны улс болсон бол бусад хэд хэдэн улс үр хөндөлттэй холбоотойгоор өвчтөн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг хамгаалах арга хэмжээг дэмжсэн. Харин Афганистан, Аргентин, Чили, Пуэрто-Рико, Орос зэрэг бусад улс бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг бууруулах бодлогыг хууль, практикт нэвтрүүлсэн. Үүний зэрэгцээ Мета, Тикток зэрэг нийгмийн цахим сүлжээний хэрэгслүүд үр хөндөлтийн талаарх мэдээллийг устгасан.

Олон улс оронд үр хөндүүлэх тусламж үйлчилгээ авахад бэрхшээлтэй хэвээр байгаа бөгөөд үр хөндүүлэх эрхийг хамгаалдаг хүмүүс халдлагад өртсөөр байна. Идэвхтнүүд, эрх хамгаалагчид, эрүүл мэндийн ажилтнууд болон бусад хүмүүс гутаан доромжлол, заналхийлэлд өртөж, шударга бусаар яллагдах, мөрдөн байцаагдах, баривчлагдах зэргээр эрүүгийн хариуцлагад татагдаж байна.

Засгийн газрууд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг зогсоож, дарангуйллын хуулиа хүчингүй болгож, аюулгүй үр хөндөлт зэрэг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх иж бүрэн мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг хангах ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, УУР АМЬСГАЛЫН ШУДАРГА БУС БАЙДАЛ

Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн өсөн нэмэгдэж буй зардлыг шийдвэрлэхэд шаардлагатай хүчин чармайлтыг харуулж чадсангүй. Түүнчлэн инфляцийн өндөр түвшин, өрийн эргэн төлөлт, татварыг урвуулан ашиглах нь орлогын бүх түвшний, ялангуяа орлого бага орнуудын эдийн засаг, нийгмийн хамгааллын эрхийг алдагдуулж байна. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчний шилжилтэд “ховор” ашигт малтмалын эрэлт эрс нэмэгдэж, хүний эрхийн шинэ эрсдэл бий болж байна.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлт нэмэгдэж байгаа үед засгийн газрууд нутаг дэвсгэрийн дотор болон гадна хүний эрхийг хамгаалах үүргээ бүрэн биелүүлж чадсангүй. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс энэ зууны эцэс гэхэд дэлхийн аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс цельсийн 3 хэмээр дулаарна гэж мэдэгджээ. 2024 оны тавдугаар сард өмнөх 12 сарын дундаж температур аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 1.5 хэмээс илүү байсан гэж мэдээлсэн.⁵

2024 онд ч дэлхийн дулаарлын түвшинд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хүний эрхийн зардал хүлээн зөвшөөрч боломгүй дээд хэмжээнд хүрсэн. Уур амьсгалын өөрчлөлт нь хар салхи, циклон, ой хээрийн түймэр, их хэмжээний хур тунадас зэрэг байгалийн бус гэлтэй үзэгдлүүдийг нэмэгдүүлж, улмаар амь насаа алдах, албадан нүүлгэн шилжүүлэлт, өлсгөлөн болон хүний эрхийн бусад хохиролд хүргэж байна. 2024 онд Бангладеш, Энэтхэгт болсон үерийн улмаас олон зуун мянган хүн дүрвэсэн. Уур амьсгалын өөрчлөлт нь Африкт олон хүнийг орон гэрээсээ дайжихад хүргэж, дүрвэсэн сая сая хүмүүсийн тоог нэмэгдүүлж байна.⁶

Зарим засгийн газар эдийн засгаа өсгөхийг тулд хүний эрх, тэр дундаа эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчиж буй эдийн засгийн салбар, төслүүдэд хөрөнгө оруулалт хийх замыг сонгосон. Ийм хөрөнгө оруулалт нь ихэвчлэн зохицуулалт муутай байдаг бөгөөд хүний эрхэд учирч буй нэмэлт хохирлыг үл харгалзан ашиг орлогоо дээд хэмжээнд нэмэгдүүлэхэд түлхэц болдог. Тухайлбал, засгийн газрууд дэлхий даяар хүний эрхийн томоохон хохирол учруулж байгааг үл хайхран шууд болон шууд бус татвар төлөгчдийн санхүүжилтийн их хэмжээний татаасыг чулуужсан түлшний үйлдвэрлэл эрхлэгч нар, нүүрстөрөгчийг тогтоон барих, хадгалах, устөрөгчийн үйлдвэрлэл зэрэг хүний эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй нотлогдоогүй шийдлүүд, аялал жуулчлалын томоохон төслүүдэд олгосон. Зарим тохиолдолд эдгээр төсөл нь албадан нүүлгэн шилжүүлэлт, их хэмжээний бохирдол, хүний эрхийн бусад хохиролд хүргэсэн.

Нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт хамгийн өндөр улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн хор хөнөөлийг тэргүүн ээлжид амсаж байгаа орлого багатай орнуудад багахан хэмжээний санхүүжилтийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход зориулан олгосон. Уур амьсгалд дасан зохицох нь эрт сэрэмжлүүлэг, уян хатан эрүүл мэндийн систем, яаралтай тусламжийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар нас баралт, хүний эрхийн бусад хохирлыг багасгахад тусалж чадах юм. Гэвч олгож буй зарим санхүүжилт бага орлоготой орнуудыг өрийн дарамтад оруулах зээлийн системд тулгуурлаж байна.

Иргэд олон нийт, идэвхтнүүд уур амьсгалын шударга ёсыг шаардаж байна. Зарим нь засгийн газруудыг чулуужсан түлшнээс татгалзах үүрэг амлалт гаргуулахаар дотоодын болон олон улсын шүүхийн механизмыг ашигласан боловч гарсан шийдвэрүүдийг засгийн газрууд тэр бүр хэрэгжүүлсэнгүй. 2024 оны 4 дүгээр сард Европын хүний эрхийн шүүхийн гаргасан гурван шийдвэр нь уур амьсгалын хямралын нөхцөлд улс орнуудын хүний эрхийн үүргийг тодорхой болгосон.⁷ Үүний нэг шийдвэрт Швейцар улс хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах үүргээ биелүүлээгүй гэж үзсэн ч Швейцарын парламент шийдвэрийг хүлээн авахаас татгалзсан. Энэ хооронд Олон улсын шүүхээс Номхон далайн арлын Вануату улсын оюутнуудын санаачилсан уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар зөвлөлдөх саналын сонголлыг эхлүүлжээ.

Бүх улсын засгийн газар чулуужсан түлшнээс шуурхай, шударга байдлаар үе шаттай татгалзаж, чулуужсан түлшний үйлдвэрлэлд татаас олгохыг зогсоох ёстой. Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их хохирол амссан орлого багатай орнуудад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход зориулж буцалтгүй тусламжийн санхүүжилт олгох ёстой.⁸

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий дахины мөргөлдөөн, инфляци, өрийн эргэн төлөлт, компанийн хангалтгүй зохицуулалт, татварыг урвуулан ашигласнаас үүдэн улам бүр дордсоор байна.⁹ 2024 онд орлого багатай улс орнуудын өрийн төлбөр сүүлийн 30 жилд байгаагүй дээд түвшинд хүрч, олон тооны улсын эрүүл мэнд, боловсролын төсвийг бууруулжээ. Татварын шударга бус тогтолцоо, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн татвараас зайлсхийх, зугтах явдлыг хазаарлаж чадахгүй байгаа нь засгийн газруудыг хүний эрхийг хангахад шаардлагатай орлогыг улам бүр бууруулж байна. Үүний уршгаар нэн ядуурал, тэгш бус байдал гүнзгийрсээр байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган гачиг болон бусад байгалийн гамшиг нь ядуурал, зөрчилдөөнтэй хавсран олон зуун сая хүнийг хүнсний аюулгүй байдлын ноцтой асуудалд хүргэж байна. 2024 онд Газа, Гаити, Суданд өлсгөлөн нүүрлэснийг зарласан. Дэлхий даяар хүмүүнлэгийн тусламж нь яаралтай хэрэгцээг хангахад шаардагдах санхүүжилтийн талаас бага хувийг л хангасан.

Дээрх байдлыг эсэргүүцэж, идэвхтнүүд болон олон нийт өөрсдийнх нь эсэргүүцлийн жагсаал, иргэний үл захирагдахуйн үйлдэлд эрүүгийн ял хүлээлгэж байгааг үл хайхран амьжиргааны өртөгтэй холбоотой санаа зовнилоо илэрхийлсээр байна. Түүнчлэн 2024 онд Олон улсын татварын хамтын ажиллагааны тухай НҮБ-ын суурь конвенцын төслийг боловсруулах ажлын даалгаврыг баталсан. Энэхүү конвенц нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын эрхэд хөрөнгө оруулах засгийн газрын чадавхыг алдагдуулдаг татвараас зайлсхийлтээс урьдчилан сэргийлж, дэлхийн татварын илүү тэгш тогтолцооны үндэс суурийг тавих боломжтой юм. Санал хураалтад 110 улс дэмжиж, найм нь эсрэг санал өгч, 44 нь түдгэлзсэн байна.

Засгийн газрууд НҮБ-ын татварын конвенцын төслийг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх ажлыг шуурхай хийх, энэ хугацаанд татварыг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой.

КОМПАНИЙ ХАРИУЦЛАГА

Компаний оролцогчдын хууль болон бодлогод нөлөөлөх гэсэн оролдлого, компанийн оролцогчдын талаарх төрийн зохицуулалт сул, компаний хүний эрхийн үүргээ биелүүлээгүйгээс компаниуд иргэдийн ундны ус, загас агнуурын талбай, тариалангийн талбай, агаарыг бохирдуулж, мэдээлэл авах эрх болон зөвшөөрлийг уландaa гишгэх зэргээр хүний эрхийг өргөн хүрээнд зөрчихөд хүргэж байна.

Сэргээгдэх эрчим хүчний шилжилт хийхэд “чухал” ашигт малтмалын эрэлт мэдэгдэхүйц нэмэгдэж, хүний эрхийн шинэ эрсдэлүүдийг бий болгож байна. Цахилгаан машин үйлдвэрлэгч тэргүүлэгч компаниуд олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхээ харуулаагүй бөгөөд улмаар өөрсдийн бодлогоо ажил хэрэг болгоогүй байна.¹⁰

Гэхдээ зарим талаар ахиц гарлаа. Ялангуяа, ЕХ 2024 онд бизнесийн хариуцлагын шинэ зохицуулалтыг нэвтрүүлж томоохон корпорациудыг хүний эрх, байгаль орчны нөлөөлөл, уур амьсгалын талаарх шинэ дүрмийг хүндэтгэхийг шаардсан. Корпорацийн тогтвортой байдлын хэрэгжилтийг шалгах удирдамж нь томоохон сорилтуудтай тулгараад байгаа ч НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын дагуу хүний эрхийн хэрэгжилтийн шалгалтыг заавал хийхийг нэвтрүүлэх дэлхийн хамгийн чухал оролдлого хэвээр байна.

ЕХ нь Корпорацийн тогтвортой байдлын хэрэгжилтийг шалгах удирдамжид зааснаар улс орнууд хүний эрх, байгаль орчин, уур амьсгалын хамгаалалтыг сулруулах хүчин чармайлтаас татгалзах ёстой бөгөөд бусад бүс нутгийн улс орнууд өөрсдийн хэрэгжилтийн шалгалтын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

ТЕХНОЛОГИ БА ХҮНИЙ ЭРХ

2024 онд АНУ-д болсон сонгууль нь технологийн ашиглалт, зохицуулалт болон цагаачид, ЛГБТИ хүмүүс болон бусад хүмүүсийн эрхийг зөрчихөд Big Tech компаниуд нөлөөлснийг харуулсан бөгөөд дэлхий даяар технологийн зохицуулалтыг зайлшгүй хийх шаардлагатайг онцлон харууллаа. Улс орнууд зохистой зохицуулалтгүйгээр тагнах программ, бусад тандалтын хэрэгслийг ихээр ашиглаж, төрийн үйлчилгээний салбарт хиймэл оюуны шинэ технологид тулгуурлан тэгш бус байдлыг бий болгож байна. Энэ хооронд сошиал медиа компаниуд үзэн ядсан, хүчирхийллийн контентыг түгээсээр байна.

ТЕХНОЛОГИЙГ УРВУУЛАН АШИГЛАХ

Нүүр царай таних технологи нь дэлхийн олон бүс нутагт жагсаал цуглаан хийх эрхэд сөргөөр нөлөөлж байна. Зарим улсад цагдаа нар тайван жагсагчдыг дрон болон царай таних өндөр төвшний дэвшилтэт камеруудаар хянасаар байна. Энэ нь хувийн халдашгүй байх эрхийг зөрчиж, тайван жагсаал цуглаан хийх эрхэд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ ялгаварлан гадуурхах нөлөө үзүүлж болзошгүй юм.

Тагнах технологийг дэлхийн улс орнуудад өргөнөөр ашигласаар байна. Цахим зар сурталчилгааны тандалтыг урвуулан ашиглах, интернэт хэрэглэгчид зар сурталчилгаатай хэрхэн харьцаж буй талаарх мэдээлэл цуглуулах зэргээр цахим аюулгүй байдлын шинэ аюул заналхийлж байна. Түүнчлэн ил тод байдал, зохицуулалт дутмаг нь тагнах программ гэх мэт тандалтын технологийн наймааг халхалсаар байна. 2024 онд Индонезийн компаниуд, төрийн байгууллагууд тагнах, тандалтын бүтээгдэхүүн борлуулж, ашигласан нь ил болсон бол Хятад болон Хонконгийн гадаадад суралцаж буй оюутнууд хятадын болон бусад аппликейшн, дижитал платформ ашиглах явцдаа тандалтад өртсөөр байна. Технологи болон тандалтын дэмжлэгтэй жендэрт суурилсан хүчирхийлэл нь Тайланд, Уганда зэрэг улс орнуудад эмэгтэйчүүд, ЛГБТИ идэвхтнүүдийн эсрэг заналхийллийг нэмэгдүүлсээр байна.

Зарим улс орнуудын тагнах програмтай холбоотой хууль бус үйлдэлд хариуцлага тооцохыг иргэний нийгмийн идэвхтнүүд, тэр дундаа Эмнести Интернэшнл шаардсан. 2024 онд тагнах программ хангамжийн NSO группын эсрэг шүүх ажиллагаа Тайланд, АНУ зэрэг улсад үргэлжилсээр байна. Израил улс уг хүчин чармайлтад саад хийж байна. Гэхдээ олон талт түвшинд тагнах программыг зохицуулах хүчин чармайлт, сайн дурын зохицуулалтад анхаарлаа хандуулах хандлагатай байна. Тухайлбал, 2024 онд Франц, Их Британи улс арилжааны кибер халдлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд улс орнууд, хувийн хэвшил, иргэний нийгмийг нэгтгэх зорилгоор Pall Mall Process-ийг эхлүүлсэн. Үүний зэрэгцээ Эмнести Интернэшнл идэвхтнүүд өөрсдийгөө хамгаалах шинэ хэрэгслийг бий болгож, бэлэн болгосоор байна.¹¹

Засгийн газрууд хууль бус тандалт, танталтын хэрэгслийг хориглож, хүчирхийллээс хамгаалах, хохирогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авах иж бүрэн хамгаалалтыг бий болгох шаардлагатай.

ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ ХАНГАЛТГҮЙ ЗОХИЦУУЛАЛТ

Засгийн газрууд шинэ технологийг зохицуулах үүрэг амлалтаасаа ухарлаа. Үүнд салбарын ашиг сонирхол ихээхэн нөлөөлсөн бөгөөд зарим талаар АНУ-ын засаг захиргааны өөрчлөлт ч нөлөөлсөн. Улс орнууд хиймэл оюун ухааны технологийг төрийн үйл ажиллагаатай улам бүр нэгтгэхийн зэрэгцээ нийгмийн халамж, хэв журам, шилжилт хөдөлгөөн, цэргийн салбарт хиймэл оюун ухаанаар ажилладаг системийг хөгжүүлэн, өргөжүүлж байна. Ихэнхдээ эдгээр технологийг засгийн газрын үр ашиг, зардал хэмнэлт эсвэл бусад хэмнэлтийн арга хэмжээтэй холбон

тайлбарладаг боловч бодит байдал дээр одоо байгаа ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлж, жендэрийн тэгш бус байдлыг бэхжүүлж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах, нийгэм, эдийн засгийн эрх мэдлийн тогтолцоог улам лавшруулдаг.¹²

Улс орнууд нийгмийн хамгааллыг хангах, түүнд хяналт хэрэгжүүлэхдээ автоматжуулсан хэрэгслийг хэрэглэж байгаа нь ялгаварлан гадуурхсан, шударга бус үр дагаварт хүргэсэн.¹³ Тухайлбал Энэтхэг зэрэг улсад хувийн бүртгэлийг өөр өөр мэдээллийн санд холбож, тодорхойлолт бий болгодог нь зарим талаар “байгууллагын шийдвэр” мэт боловч ихээхэн хор уршигтай, техникийн алдаатай хэрэгжүүлэлт юм.¹⁴

Хүчний тулааны өрсөлдөгч АНУ, Хятадын нөхцөл байдлаас үүдэн дэлхийн хэмжээнд хиймэл оюун ухааны зохицуулалт хойшилж байгаа бөгөөд ингэснээр үндэсний аюулгүй байдлыг хангах үндэслэл, зохицуулалт болон инновацийн хоорондын хуурмаг хуваагдлын дор хиймэл оюуны ухааныг хяналтгүйгээр хурдацтай хөгжүүлэхэд хүргэж байна.

Засгийн газрууд хиймэл оюун ухааны технологи, түүнийг үйлдвэрлэдэг компаниудыг зохицуулахад илүү анхаарч, хүний эрх нь шинэ технологи зохион бүтээх, ашиглахад салшгүй холбоотой болохыг баталгаажуулах шаардлагатай.

СОШИАЛ МЕДИА КОМПАНИУДЫН БИЗНЕСИЙН ЗАГВАР

Хяналтгүй, эрх мэдэлтэй сошиал медиа компаниуд хамгийн гадуурхадсан, эрсдэлт бүлгийн хүмүүст учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хамгаалалтаас ухарсан. Тэд ашиг олоход тэргүүлэх ач холбогдол өгдөг бизнесийн загварыг үргэлжлүүлэн ажиллуулж, үзэн ядсан, хүчирхийлэлтэй контентыг түгээх боломжийг олгосон. Энэ нь хортой үр дагаврыг үл харгалзан, ялангуяа залуучуудыг платформ дээрээ улам бүр татсаар байна. 2024 онд дэлхийн даяар залуу идэвхтнүүд цахим заналхийлэл, дарамтад өртсөн.¹⁵ Филиппинд залуу идэвхтнүүдийг онилж коммунист, террорист хэмээн цоллож, төрийн дэмжлэгтэйгээр халдлага үйлдсэнийг Эмнести Интернэшнл баримтжуулсан.

ЕХ нь технологийн зохицуулалтын талаар холимог жишиг тогтоов. 2024 оны 2 дугаар сард бүрэн хүчин төгөлдөр болсон Цахим үйлчилгээний тухай хууль нь онлайн платформ болон хайлтын системд хүний эрхийг дээдлэх үүргийг хуульчилсан.¹⁶ Улмаар Европын Комисс TikTok-ыг залуу хэрэглэгчдийг хамгаалах зохицуулалтыг зөрчсөн байж болзошгүй хэмээн шалгахаар шийдвэрлэсэн.¹⁷ 2024 оны 8 дугаар сард хүчин төгөлдөр болсон ЕХ-ны Хиймэл оюун ухааны тухай хууль нь хиймэл оюун ухааны хэрэглээнд хүний эрхийг хамгийн ихээр зөрчиж буй зарим хэрэглээнд хязгаарлалт тогтоосон боловч хүмүүс болон хүний эрхийг асуудлын төвд тавьж чадаагүй.¹⁸

Этиоп улсад хүний эрхийн зөрчлийн хохирогчид Фэйсбүүкийн учруулсан эсхүл нэмэрлэсэн хохирлын асуудлаар Фэйсбүүк компанид хариуцлага тооцуулах шүүхийн маргаанд зарим дэвшил гарсан. Гэвч бусад улс оронд нийгмийн цахим сүлжээний хор уршгийг арилгах тухай хуулийн төсөл нь ихэвчлэн хэт ерөнхий, эсвэл компаниудын бизнесийн загварын үндсэн асуудлуудыг хөндөхгүйгээр, хүүхэд, залуучуудын санаа бодлыг хангалттай харгалзан үзэхгүйгээр нийгмийн цахим сүлжээнд хандах эрхийг хязгаарлах зорилготой байв.

Засгийн газрууд хүний эрхийг хамгаалахын тулд нийгмийн цахим сүлжээний компаниудыг зохистойгоор зохицуулах шаардлагатай. Компаниуд өөрсдөө хууль бус, тандалтад суурилсан бизнесийн загвараас татгалзах ёстой.

-
1. *Obligations of State Parties on Addressing and Eradicating Xenophobia and Its Impact on the Rights of Migrants, Their Families, and Other Non-Citizens Affected by Racial Discrimination*, 4 April ↑
 2. *Primer: Defending the Rights of Refugees and Migrants in the Digital Age*, 5 February; *The Digital Border: Migration, Technology and Inequality*, 21 May ↑
 3. "Global: Africans and people of African descent call on Europe to reckon with their colonial legacies", 18 November ↑
 4. *We Are Facing Extinction: Escalating Anti-LGBTI Sentiment, the Weaponization of Law and Their Human Rights Implications -in Select African Countries*, 9 January ↑
 5. "Global: Record-breaking 12-month run of global heat underlines urgency of action to deliver climate justice", 5 June ↑
 6. "Africa: Richer countries must commit to pay at COP29 as climate change forcibly displaces millions across Africa", 4 November ↑
 7. *Climate Inaction, Ruled Out! European Court Clarifies State Obligations to Tackle the Climate Crisis*, 21 August ↑
 8. Amnesty International Recommendations to Parties to the UNFCCC on Human Rights Consistent Climate Action in 2024, 23 October ↑
 9. What's Tax Got to Do with It: A Resource Guide on Tax and Human Rights, 17 September ↑
 10. Recharge for Rights: Ranking the Human Rights Due Diligence Reporting of Leading Electric Vehicle Makers, 15 October ↑
 11. "Amnesty International's Security Lab unveils new tools to support civil society against digital threats", 5 June ↑
 12. *Briefing: Gender and Human Rights in the Digital Age*, 10 July ↑
 13. *Briefing: Social protection in the Digital Age*, 6 March ↑
 14. *Use of Entity Resolution in India: Shining a Light on How New Forms of Automation Can Deny People Access to Welfare*, 30 April ↑
 15. "Three out five young activists face online harassment globally for posting human rights content", 1 July ↑
 16. "EU: Landmark Digital Services Act must be robustly enforced to protect human rights", 17 February ↑
 17. "EU/Global: European Commission's TikTok probe aims to help protect young users", 19 February ↑
 18. "Statement: EU takes modest step as AI law comes into effect", 1 August ↑

АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Африкийн бүс нутаг дахь зэвсэгт мөргөлдөөний улмаас бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэж, асар олон хүний амь насыг хохироон, энгийн иргэдийг тэвчихийн аргагүй зовлон зүдүүрт хүргэсэн ч олон улсын болоод бүс нутгийн хариу арга хэмжээ хангалтгүй хэвээр байж, энгийн иргэд мартагдсан мэт байв.

Хүнс, шатахуун, бусад өргөн хэрэглээний барааны үнэ огцом өсөхийн хэрээр амьжиргааны өртгийн хямрал гүнзгийрэв. Өндөр татвар, улсын өр, өргөн хүрээг хамарсан авлига, хурцадсан мөргөлдөөн, цаг агаарын эрс тэс үзэгдэл зэрэг нь хямралыг улам хурдасгав.

Эсэргүүцэл илэрхийлэх нь амь насаа аюул эрсдэлд оруулж байгаатай адил болов. Жагсаал цуглааныг харгис хэрцгий, амь насанд аюултай хүч хэрэглэн тарааж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхэд халдах зөрчил өргөн тархсан хэвээр байна. Өрсөлдөгч, шүүмжлэгч, хүний эрх хамгаалагч, идэвхтэн, сэтгүүлчдийг хүчээр алга болгох, дур зоргоороо баривчлах, цагдан хорих зэрэг дарангуйллын тактикийг Засгийн газрууд хэрэглэлээ.

Мөргөлдөөн, уур амьсгалаас үүдсэн цочрол нь албадан нүүлгэн шилжүүлэх үндсэн хүчин зүйл болсон хэвээр байгаа бөгөөд Судан улсад дэлхийн хэмжээнд дүрвэгсдийн хамгийн том хямрал үргэлжилсээр байна. Мөргөлдөөний бүсээс дүрвэн зугтагсдын тоо нэмэгдэж байгаа бөгөөд олон тооны дүрвэгсэд хүнд нөхцөлд албадан нутаг буцаагдахаас эмээн амьдарч байна.

Нийгмийн хэм хэмжээгээр улам бүр өдөөгдсөн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл охид, эмэгтэйчүүдийн өдөр тутмын амьдралын хэвийн үзэгдэл болжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг нөхцөлдүүлснийхээ төлөө гол хариуцлага хүлээх өндөр орлоготой улс орнууд алдагдал, хохирол, дасан зохицох арга хэмжээнд хангалттай санхүүжилт гаргаж чадсангүй. Үүний уршгаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн удаан хугацаанд үргэлжилсэн ган гачиг, ар араасаа үргэлжилсэн үер усны аюул, хүчтэй шуурга, хэт халалтын хүнд хэцүү дарамт бэрхшээлийг иргэд амссаар байна.

Ял шийтгэл оногдуулахгүй байх соёл олон улсын эрх зүйд заасан гэмт хэрэг болон хүний эрхийг ноцтой, бүдүүлгээр зөрчсөн бусад гэмт хэрэгтнүүдийг улам өөгшүүлж байна.

ХУУЛЬ БҮС ХАЛДЛАГА, АЛЛАГА

Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Этиоп, Мали, Мозамбик, Нигер, Нигери, Сомали, Өмнөд Судан, Судан зэрэг бүс нутгийн улс орнуудад засгийн газрын зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлийн хууль бус халдлага, аллагууд бүртгэгдлээ.

Засгийн газрын зэвсэгт хүчний явуулсан ажиллагааны үеэр энгийн иргэдийн амь нас хохирох явдал байнга шахам тохиолдов. Өнгөрсөн хоёрдугаар сард Буркина Фасо улсын цэргүүд Соро, Нодин тосгонд 223 энгийн иргэн, түүний дотор 56 хүүхдийн амь насыг хөнөөсөн. Өнгөрсөн тавдугаар сард зүүн нутгийн бүслэлтэд байгаа хотуудын эсрэг ажиллагааны үеэр цэрэг арми болон түүний итгэмжлэгдсэн зэвсэгт хүчний гарт олон зуун энгийн иргэд амь үрэгдсэн. Этиоп улсад 1 дүгээр сард

Амхара мужийн Мерави хотод засгийн газрын зэвсэгт хүчин болон цэргүүдийн хооронд өрсөсөн зэвсэгт мөргөлдөөний дараа засгийн газрын цэргүүд олон тооны энгийн иргэдийг гэр, дэлгүүр, гудамжнаас барьж, улмаар цаазлав.

Хэд хэдэн мөргөлдөөний үеэр засгийн газрын цэргийн хүчнийхэн агаарын довтолгоо болон дроноор дайралт хийсний улмаас энгийн иргэд амь үрэгджээ. Мали улсад армийн дроны халдлагын улмаас 3 дугаар сард 27 энгийн иргэн, түүний дотор 18 хүүхэд, 10 дугаар сард 8 энгийн иргэн, түүний дотор 6 хүүхэд амь үрэгджээ. Нигер улсад өнгөрсөн нэгдүгээр сард армийн дроны дайралтын улмаас Тиллабери мужийн Тиава тосгонд 50 орчим энгийн иргэн амиа алдсан хэмээн мэдээлсэн. Мөн Нигер улсын Кадуна мужид цэргийнхэн агаараас цохилт өгсний улмаас сүмд мөргөл үйлдэж байсан хүмүүс, худалдааны төвөөр үйлчлүүлж байсан хүмүүс зэрэг нэг тосгоны нийт 23 хүн амиа алдсан. Сомали улсад 3 дугаар сард Сомалийн цэргийн ажиллагааг дэмжиж Турк улсад үйлдвэрлэсэн хоёр удаагийн дроны халдлагын улмаас доод Шабелле мужид 23 энгийн иргэн, түүний дотор 14 хүүхэд амь үрэгдсэн.

Зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэдийн эсрэг хамгийн олон хүний аминд хүрсэн халдлагыг үйлдсэн. Буркина Фасогийн Ислам ба лалын шашинтнуудыг дэмжих бүлэглэл (GSIM) наймдугаар сард Барсалогод энгийн иргэдийг оролцуулаад 200 орчим хүнийг хөнөөсөн гэж мэдээлсэн. БНАКУ-д 3 дугаар сарын 23-ны хөдөлгөөн буюу Конгогийн хөгжлийн төлөөх нэгдэл, Холбоот ардчилсан хүчнийхэн (ADF) зэрэг зэвсэгт бүлэглэлүүд зүүн болон баруун хэсэгт засгийн газрын цэргийн хүчнийхэнтэй хийсэн тулалдааны үеэр ихэнх энгийн иргэдийн амь нас хохирсон. Зургадугаар сард Холбоот ардчилсан хүчнийхний хоёр өөр халдлагын улмаас 200 гаруй энгийн иргэн амь үрэгдсэн. Сомали улсад 1-9 дүгээр сарын хооронд тус улсад бүртгэгдсэн 854 энгийн иргэдийн амь насыг хөнөөсөн хэргийн 65 хувийг Аль-Шабааб бүлэглэл үйлдсэн хэмээн НҮБ-ын Тусламжийн төлөөлөгчийн газар мэдээлсэн. Суданд Шуурхай дэмжлэг үзүүлэх хүчин (RSF) энгийн иргэд рүү халдлага үйлдсэн хэвээр байгаа бөгөөд тэдний зарим нь угсаатны шалтгаантай байв. Аравдугаар сард Шуурхай дэмжлэг үзүүлэх хүчний цэргийн командлагч Суданы Зэвсэгт хүчинд урвасны дараа зүүн Гезира мужийн хот, тосгодод өгсөн хариу цохилтын улмаас долоо хоногийн дотор дор хаяж 124 энгийн иргэн алагдсан талаар НҮБ мэдээлсэн.

Зэвсэгт бүлэглэлүүд ихэвчлэн мөргөлийн газар, сургууль, эмнэлэг болон бусад иргэний объектуудыг онилов. Буркина-Фасо улсын Сахел мужийн Эссакане дахь католик сүмд 2 дугаар сарын 25-нд мөргөл үйлдэж байсан 15 хүнийг зэвсэгт бүлэглэлийнхэн хөнөөжээ. Мөн өдөр Ислам ба лалын шашинтнуудыг дэмжих бүлэглэл Эст мужийн Натиабони дахь сүмд халдлага үйлдэж хамгийн багадаа 14 мөргөл үйлдэгчийг хөнөөсөн. 8 дугаар сард Ислам ба лалын шашинтнуудыг дэмжих бүлэглэл Boucle du Mouhoun бүс нутгийн Коунла дахь сүмд халдлага үйлдэж 26 энгийн иргэнийг хөнөөсөн. Хоёрдугаар сард Мозамбикт зэвсэгт бүлэглэлүүд Чиуре дүүргийн гурван сүм, хоёр сургуулийг галдан шатааж, эмнэлгийг түймэрдсэн.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд энгийн иргэд, шашны болон боловсролын байгууллагууд, соёлын бусад өмчийг хамгаалах, энгийн иргэд болон иргэний дэд бүтцэд чиглэсэн халдлагыг зогсоох зэргээр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх ёстой.

МӨРГӨЛДӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БЭЛГИЙН БОЛОН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн хэргүүд түгшүүртэй түвшинд хүрч нэмэгдсэн. ТАБНУ-д оны эхний хагаст жендэрт суурилсан хүчирхийллийн 11,000 гаруй тохиолдол бүртгэгджээ. БНАКУ-д бүртгэгдсэн тохиолдлын тоо 2024 оны эхний улиралд 2023 оны мөн үетэй харьцуулахад хоёр дахин нэмэгджээ. Суданд Шуурхай дэмжлэг үзүүлэх хүчний гишүүд Дарфур бүс нутаг болон Их Хартумын хотуудад үйлдсэн халдлагын үеэр олон тооны бэлгийн хүчирхийлэл үйлдсэн болохыг НҮБ-ын бие даасан олон улсын баримт судалгааны баг тогтоожээ. Тэд ихэвчлэн Дарфур муж болон Гезира мужид охид, эмэгтэйчүүдийг гэр бүлийнхнийх нь нүдэн дээр хүчиндэж, бүлэглэн хүчирхийлдэг байжээ. Мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэл Сомали, Өмнөд Суданд өргөн тархсан. Сомалид болсон халдлагын үеэр Сомалийн үндэсний армийн хоёр ажилтан 15, 16 настай эгч дүүсийг хүчиндсэн байж болзошгүй байна.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн гишүүд, цэргүүд рүү хандсан бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлийг хориглох тухай тодорхой тушаалуудыг гаргах ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

ХООЛ ХҮНСТЭЙ БАЙХ ЭРХ

Бүс нутгийн хүн амын дийлэнх нь өлсгөлөнд нэрвэгдсэн хэвээр байна. Өмнөд Африкийн бүс нутгийн Ангол, Ботсвана, Лесото, Малави, Намиби, Замби, Зимбабве зэрэг улс El Niso-ийн нөлөөгөөр сүүлийн зуунд тохиолдож байгаагүй их ган гачигт нэрвэгдсэн бөгөөд зарим нь онц байдал зарлах хариу арга хэмжээ авчээ. Ган гачиг нь газар тариалан, мал сүргийг сүйтгэж, олон сая хүний хүнсний аюулгүй байдald заналхийлэв. 8 дугаар сард Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг Өмнөд Африкийн бүс нутгийн хүн амын 17% (68 сая хүн)-д тусламж хэрэгтэй байгааг зарлав.

Африкийн бусад хэсэгт, тэр дундаа ТАБНУ, Сомали, Өмнөд Суданд хүнсний аюулгүй байдал ноцтой хэмжээнд алдагдав. ТАБНУ-д 2.5 сая гаруй хүн хүнсний аюулгүй байдалд өртсөн бол Мбому, Хауте-Котто болон бусад бүс нутгийн хүн амын 50 гаруй хувь нь онц байдлын болон хүнсний аюулгүй байдлын хямралтай нөхцөлд аж төрж байна. Сомали улсад хамгийн багадаа 4 сая хүн хямрал эсвэл хүнсний аюулгүй байдлын яаралтай асуудалтай тулгарсан бөгөөд 0,5-5 хүртэлх насны 1.6 сая хүүхэд хоол тэжээлийн хурц дутагдалд өртсөн. Өмнөд Суданд ойролцоогоор 7.1 сая хүн (56.3%) жилийн турш хямралын түвшинд буюу түүнээс ч хүнд хүнсний аюулгүй байдлын асуудалтай тулгарсан бөгөөд 2.5 сая гаруй хүүхэд, эмэгтэйчүүд хоол тэжээлийн хурц дутагдалд орсон.

СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Африкийн Холбоо сурч боловсрох эрхийн талаар үүрэг хүлээсэн ч мөргөлдөөн, аюулгүй байдал нь олон сая хүүхдийг сургуулиас завсардуулав. Аюулгүй сургуулиудын тунхаглалыг (зэвсэгт мөргөлдөөний үед боловсролыг хамгаалах тухай засгийн газар хоорондын хэлэлцээр) зөрчсөний улмаас мөргөлдөөний бүс нутаг дахь олон зуун сургууль халдлагад өртөж сүйрсэн, эсхүл дүрвэгсдийн хорогдох байр болсон. Судан улсад 17 сая гаруй хүүхэд сургууль завсардсан бөгөөд 2023 оны 4 дүгээр сард мөргөлдөөн эхэлснээс хойш сургуулиуд руу үйлдэх халдлага нь дөрөв дахин нэмэгдсэн тухай Хүүхдийг Ивээх сангаас тавдугаар сард мэдээлсэн.

Баруун болон Төв Африкт 9 дүгээр сарын байдлаар мөргөлдөөний улмаас 14,000 гаруй сургууль хаагдсан бөгөөд 2,8 сая хүүхэд өртсөн хэмээн НҮБ-ын Хүүхдийн сан мэдээлэв. Буркина Фасо улсад 3 дугаар сарын байдлаар мөргөлдөөний улмаас 5,319 сургууль хаагдаж, нэг сая орчим хүүхдэд нөлөөлжээ.

ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

Засгийн газрууд 20 гаруй жилийн өмнө Абужагийн тунхаглалаар тодорхойлсон улсын төсвийн 15 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах амлалтаа биелүүлээгүй хэвээр байна. Засгийн газрууд улсын төсвийнхөө ердөө 7.4 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулснаар нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд арай ядан ажиллаж байв. Түүнчлэн, эрүүл мэндийн зардал өндөр хэвээр байгаа бөгөөд засгийн газруудын эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэд өөрсдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнийхээ төлбөрийг хувиараа төлдөг байдлаас ихээхэн хамааралтай байгаа нь бүс нутгийн хэмжээнд 150 сая гаруй хүнийг ядууралд оруулж байгааг ДЭМБ арван хоёрдугаар сард анхааруулсан. Кени улсын үндэсний эрүүл мэндийн даатгалын шинэ тогтолцоо нь олон тооны өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хүндрэл учруулсан. Зарим ахиц гарсан. Тухайлбал, Гана улс хумхаа өвчний эсрэг вакцины хэрэглээгээ өргөжүүлсэн бол Нигерийн засгийн газар өвчтөний эмчилгээ, лабораторийн шинжилгээ, дүрс оношилгоо, мэс заслын эмчилгээний төлбөрийг 50 хувиар бууруулж, улсын эмнэлгүүдийн төрөлт болон диализийн эмчилгээний төлбөрийг цуцаллаа.

Бурунди, Камерун, ТАБНУ, Конго, БНАКУ, Өмнөд Африк зэрэг улс орнуудыг хамарсан Сармагчны цэцэг өвчний дэгдэлт бүс нутаг даяар түгшүүр төрүүлэв. Долдугаар сарын 30-ны өдөр гэхэд 10 улсад Сармагчны цэцэг өвчний 14,250 тохиолдол, нас баралтын 456 тохиолдол бүртгэгдсэн нь 2023 оны мөн үетэй харьцуулахад тохиолдол 160%, нас баралт 19%-иар тус тус өссөн. БНАКУ-д бүртгэгдсэн нийт тохиолдол болон нас баралтын 96 гаруй хувийг эзэлж байна. Наймдугаар сард ДЭМБ бүс нутгийн Сармагчны цэцэг өвчний дэгдэлтийг “олон улсын анхаарал татсан нийгмийн эрүүл мэндийн яаралтай байдал” хэмээн зарлав.

АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

Конго, Зааны Ясан Эрэг, Кени зэрэг хэд хэдэн улсын засгийн газрын албадан нүүлгэн шилжүүлэлтийн улмаас олон мянган хүн орон гэргүй болж, гачигдалд өртөв. Конго улсын Коуилоу дахь Мпили хотын оршин суугчдыг Хятадын нэгэн компани калийн олборлолт явуулахын тулд албадан нүүлгэн шилжүүлжээ. Кени улсын засгийн газар хүчтэй аадар бороо, үерийн бүс дэх Найроби хотын Матаре, Мукуру Ква Нженга суурины дор хаяж 6000 айлын байшинг нураажээ.

Засгийн газрууд өлсгөлөнгөөс урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдал алдагдаж байгаагийн үндсэн шалтгааныг арилгах зэргээр нийгэм, эдийн засгийн хүндрэлийг шийдвэрлэх, Аюулгүй сургуулийн тунхаглалыг баталж, хэрэгжүүлэх, мөргөлдөөний бүс нутагт байгаа хүүхдүүдийн боловсрол эзэмших боломжийг хангах, Абужагийн тунхаглалд нийцүүлэн эрүүл мэндийн салбарын төсвийн хуваарилалтанд тэргүүлэх ач холбогдол өгөх; албадан нүүлгэлтийг зогсоож, албадан нүүлгэгдэх эрсдэлтэй хүмүүст зохих хууль эрх зүйн болон процедурын баталгааг бий болгох хүртэл тэднийг олноор нүүлгэн шилжүүлэхийг түр хориглох зэрэг арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРСАН НЬ

ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Аюулгүйн хүчнийхэн хүч хэтрүүлэн хэрэглэх нь нийтлэг байв. Гвиней, Кени, Мозамбик, Нигери, Сенегал зэрэг улсад цагдаа нар аллага үйлдэж, жагсагчдыг хоморголон баривчилж байсныг баримтжуулсан. Гвиней улсад хоёрдугаар сард болсон үйлдвэрчний эвлэлийн ажил хаялтын үеэр 17 настай жагсагч буудуулж амиа алдсан. Гуравдугаар сард Киндиа хотод цахилгаан тасалж байгааг эсэргүүцэн зохион байгуулсан жагсаалын үеэр 8 болон 14 настай хоёр хүү буудуулж амиа алдсан нь эсэргүүцлийн жагсаалыг улам хурцатгав. Сенегал улсад ерөнхийлөгчийн сонгуулийг хойшлуулахыг эсэргүүцсэн жагсаалын үеэр аюулгүй байдлын албаныхан 16 настай хүү зэрэг нийт дөрвөн хүний амь насыг хөнөөсөн. Кени улсад Санхүүгийн хуулийн төслийг эсэргүүцсэн жагсаалын үеэр зургаа, долдугаар сард 60 хүн нас барсан болохыг хүний эрхийн үндэсний байгууллага баримтжуулсан. 6-8 дугаар сарын хооронд 600 гаруй жагсагчийг баривчилжээ. Мозамбик улсад 10 дугаар сард болсон маргаантай сонгуулийн дараа аюулгүй байдлын хүчнийхэн жагсагчдын эсрэг хүч хэрэглэсэн нь сүүлийн хэдэн жилийн турш хэрэгжүүлсэн жагсагчдыг нухчин дарах ажиллагааг улам дордуулав. Наад зах нь 277 хүн нас барсны дотор хүүхдүүд болон жагсаалыг хөндлөнгөөс ажиглаж байсан хүмүүс багтжээ. Нигери улсад наймдугаар сард болсон #МуузасагалынТөгсгөл жагсаалын үеэр хамгийн багадаа 24 хүн амиа алдаж, 1000 гаруй хүн баривчлагдсан.

Ангол, Бенин, Ботсвана, Кот-д’Ивуар, Экваторын Гвиней, Уганда зэрэг улсад аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаалыг харгис хэрцгий байдлаар дарангуйлсан тухай мэдээлсэн. Чад, Танзани, Того, Замби зэрэг бусад улсын эрх баригчид эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахыг хориглов. Танзани улсад наймдугаар сард сөрөг хүчний Чадема намтай холбогдуулан 500 гаруй хүнийг залуучуудын чуулганыг хориглосон заалтыг зөрчсөн хэрэгт буруутган баривчилсан. Есдүгээр сард цагдаа нар Чадемагийн бүх эсэргүүцлийн жагсаалыг хориглосон тухай зарласан. Того улсад Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх талаар сөрөг хүчний улс төрийн намууд болон иргэний нийгмийн зүгээс зохион байгуулахаар төлөвлөсөн уулзалт, жагсаал, цуглааныг удаа дараа хориглосоор байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд шүүмжлэгчдийг айлган сүрдүүлэх, баривчлах, шүүхийн дарамт үзүүлэх зэргээр онилж байв. Камерун улсад 10 дугаар сард ерөнхийлөгч Биягийн эрүүл мэндийн талаарх цуурхал тарсны дараа нутаг дэвсгэрийн засаг захиргааны сайд “Ерөнхийлөгчийн нөхцөл байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцэхийг” хориглов. Эсватинийн эрх баригчид засгийн газрын шүүмжлэгчдийг онилохын тулд 2008 оны терроризмын эсрэг хуулийг үргэлжлүүлэн хэрэглэсээр байна. Мадагаскарын эрх баригчид улс төрийн сөрөг хүчний гишүүдийг хянахын тулд Предатор тагнах программыг ашигласан. Сенегал улсын улс төрч Ахмед Сюзанна Камараг тус улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдыг худалч гэж хэлснийх нь дараа “төрийн тэргүүнийг доромжилсон” хэрэгт буруутган долдугаар сард баривчилж, яллагагчаар татсан. Өөр нэг улс төрч Чейхна Кейта-г ерөнхийлөгч болон ерөнхий сайдын хооронд үүссэн хурцадмал байдлын талаар телевизээр ярьсны дараа есдүгээр сард баривчилжээ.

Уганда улсад өнгөрсөн дөрөвдүгээр сард олон нийтийн арга хэмжээний үеэр Ерөнхийлөгч Мусевенигийн хэлсэн үгийг шүүмжилсэн найман хөгжимчнийг цэргийнхэн баривчилсан. Мөн дөрөвдүгээр сард шүүхээс олон нийтийн цахим сүлжээний идэвхтэн Ибрахим Мусанаг үзэн ядах үг хэллэгийг сурталчилсан гэх

зэрэг хэрэгт холбогдуулан шалгаж түүнд холбогдох хэргийг шийдвэрлэх хүртэл Ерөнхийлөгч Мусевени зэрэг засгийн газрын хэд хэдэн албан тушаалтны нэрийг олон нийтийн сүлжээнд дурдахыг хоригложээ. Долдугаар сард Эдвард Авеба-г ерөнхийлөгчийг элэглэсэн бичлэг тараасан хэргээр шүүхээс зургаан жил хорих ялаар шийтгэсэн. Замби улсын эрх баригчид авлигын хэргийг илчилсэн, төрийн албан хаагчдыг шүүмжилсэн хэд хэдэн шүүмжлэгчдийг хангалттай нотлох баримтгүйгээр яллав. Тухайлбал, сөрөг хүчний Эх орончдын фронт намын ерөнхий нарийн бичгийн дарга Рафаэль Накасинда-г 2021 онд хүчингүй болсон хуулийн дагуу “Ерөнхийлөгчийг гүтгэсэн” хэрэгт буруутган 18 сар хорих ялаар шийтгэсэн.

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Сэтгүүлчдийг нүхчин дарах үйл ажиллагаа айдас хүйдэст автуулж, өөрсдийгөө цензурдэхэд хүргэв. Ангол, Чад, Гвиней, Кени, Лесото, Нигери, Танзани, Того, Зимбабве болон бусад улсад сэтгүүлчдийг заналхийлж, бие махбодод нь халдаж, дур зоргоор баривчилсан. Олон улсын сэтгүүлчдийн холбооны мэдээлснээр, арван хоёрдугаар сарын 10-ны байдлаар Африкт 8 сэтгүүлч алагдсаны 5 нь Суданд амь үрэгджээ. Чадын сэтгүүлч Идрис Яаяаг гуравдугаар сард заналхийлсний дараа эхнэр болон дөрвөн настай хүүгийнх нь хамт хөнөөсөн бөгөөд энэ нь Монго бүс нутагт нийгэм хоорондын мөргөлдөөн хурцдаж байгаа талаар мэдээлсэнтэй нь холбоотой хэмээн үзэж байна.

Эритрей улсад чөлөөт хэвлэлийг татан буулгаж эхэлснээс хойш хорь гаруй жилийн дараа бүртгэлтэй, хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл үлдсэнгүй. Бенин, Буркина Фасо, Гвиней, Танзани, Того болон бусад улсад эрх баригчид хэвлэл мэдээллийн байгууллага, сонины үйл ажиллагааг түр зогсоож, эсхүл түр зогсоохоор заналхийлэв. Буркина Фасогийн эрх баригчид Нодин, Сорогийн аллагын талаар мэдээлсний хариуд TV5 Monde, BBC, Voice of America зэрэг телевиз, түүнчлэн Буркинабегийн есөн хэвлэл мэдээллийн байгууллагын вэб сайт руу нэвтрэх эрхийг хоёр долоо хоногээр зогсоожээ. Гвиней улсын засгийн газар хэд хэдэн радио, телевизүүдийн тусгай зөвшөөрлийг “контентийн техникийн шаардлага хангаагүй” гэсэн үндэслэлээр цуцлах шийдвэр гаргасан. Танзани улсын зохицуулах байгууллагууд сураггүй алга болсон эсвэл алагдсан хүмүүсийн тухай видеотой холбогдуулан “үндэсний эв нэгдэл, нийгмийн амар амгаланг” эвдсэн материал нийтэлсэн хэмээн үзэж The Citizen цахим платформмыг 30 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн. Того улсын эрх баригчид дөрөвдүгээр сард болсон сонгуулийг сурвалжлах гадаадын бүх сэтгүүлчийн магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлэв.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаагаа чөлөөтэй зохион байгуулах, явуулах боломж улам хумигдсан. Зааны Ясан Эрэг улсын засгийн газар иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах шийдвэр гаргасан нь тэдний санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх болгоомжлолыг төрүүлэв. Этиоп улсын эрх баригчид хүний эрхийн үндэсний таван байгууллагын тусгай зөвшөөрлийг дур зоргоор түдгэлзүүлсэн бөгөөд жилийн эцсээр тэдний дөрвийнх нь эрхийг түдгэлзүүлсэн хэвээр байв. Гвиней улсын засгийн газар төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх хүртлээ буюу дөрвөн сарын хугацаанд үйл ажиллагаа явуулах лицензийг сунгахыг түдгэлзүүлсэн. Руанда улсын шинэ хуулиар үндэсний ТББ-уудын төсөв, удирдлагын шийдвэрт хязгаарлалт тогтоосон.

Уганда улсад ТББ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хагас бие даасан ТББ-ын Товчоог татан буулгаж улмаар Дотоод хэргийн яамны харьяа газар болгон дахин байгуулсан нь төрийн бус байгууллагуудтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлийг төвлөрүүлж, хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг

нэмэгдүүлэх чиглэлд шилжиж байгааг илтгэж байна. Зимбабве улсад оны эцсээр Сенатаар хэлэлцэхээр хүлээгдэж буй Хувийн сайн дурын байгууллагуудын хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл нь иргэний нийгмийн орон зайг хязгаарлах, иргэний нийгмийн байгууллагуудын оршин тогтнох, бие дасан байдал, үйл ажиллагаанд заналхийлэхэд ашиглаж болох заалтуудыг агуулж байсан.

Засгийн газрууд хууль сахиулах байгууллагуудыг хүч хэрэглэхгүй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван хуран цуглах эрхээ эдэлж буй хүмүүсийг дарамтлах бүх хэлбэрийг зогсоох, олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээнд нийцүүлэн иргэний нийгмийн байгууллагуудад үйл ажиллагаагаа явуулах аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхийг баталгаажуулах ёстой.

ДУР ЗОРГООР БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ, ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХ

Ангол, Бенин, Буркина Фасо, Бурунди, Чад, Экваторын Гвиней, Мали, Мозамбик, Нигер, Өмнөд Судан, Танзани, Того, Замби, Зимбабве зэрэг улсад сөрөг хүчний идэвхтнүүд, хүний эрх хамгаалагчдыг дур зоргоор баривчилж, цагдан хорьсон. Ангол улсад цагдан хоригдсон идэвхтэн Адольфо Кампос, Гилдо дас Руас нар эмнэлгийн тусламж авахаас татгалзсаны улмаас тэдний эрүүл мэнд эрс муудав. Чад улсад хоёрдугаар сард аюулгүй байдлын албаныхан намын төв байранд нь халдлага үйлдэх үеэр сөрөг хүчний удирдагч Яаяа Дилло алагдсаны дараа хамаатан садных нь 25 хүнийг баривчилсан бөгөөд тэдний ихэнх нь өмгөөллийн болон эмнэлгийн тусламж авах боломжгүй өндөр хамгаалалттай хорих газарт цагдан хоригдсон. Долоодугаар сард тэдгээрийн 14 хүнд 10 жилийн хорих ял оноож, 10 хүнийг цагаатгасан бол нэг хүнийг ямар ч үндэслэлгүйгээр цагдан хорьсон хэвээр байв. Гэвч 11, 12 дугаар сард тэднийг ямар ч тайлбаргүйгээр сулласан. Мали улсын жандармерийн алба өнгөрсөн зургаадугаар сард тус улсын нийслэл Бамако хотод уулзалт хийсэн 11 улстөрчийг “Нийгмийн хэв журам алдагдуулсан, төрийн эсрэг хуйвалдаан зохион байгуулсан” хэрэгт буруутган баривчилсан бөгөөд арван хоёрдугаар сард сулласан.

Бүс нутгийн бусад улсын эрх баригчид хүмүүсийг олноор нь бүслэн, хоморголон баривчлах нь нэмэгдсэн. Конгод Браззавиль хотын эрх баригчид гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цагдаагийн гэнэтийн ажиллагаа явуулсны дараа тав, зургаадугаар сард 580 хүнийг баривчилжээ. Этиоп улсад онц байдал тогтоосон нэрийдлээр олон зуун хүнийг үндэсний хэмжээнд баривчилсан. Амхара бүс нутагт холбооны арми болон аюулгүй байдлын хүчнийхэн есдүгээр сард хүмүүсийг хоморголон баривчлах шинэ кампанит ажил эхлүүлж, дөрвөн өдрийн дотор олон мянган хүнийг баривчилжээ. Мозамбикт 10 дугаар сард болсон бүх нийтийн сонгуулийн өмнө сөрөг хүчний нам болох Мозамбикийн хөгжлийн төлөөх намыг дэмжсэн, гишүүнээр элссэн олон зуун хүнийг баривчилсан. Мөн сонгуулийн дараа олон мянган хүнийг баривчилсан. Зимбабве улсын эрх баригчид 8 дугаар сарын 17-нд нийслэл Хараре хотод болсон Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэгийн төр, засгийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтын өмнө сөрөг хүчний гишүүд, үйлдвэрчний эвлэлийн удирдагчид, оюутнууд, сэтгүүлчид зэрэг 160 гаруй хүнийг баривчилж, тайван замаар шүүмжлэгчид, өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах ажиллагааг эрчимжүүлсэн. Зургаадугаар сарын эхээр цагдаа нар сөрөг хүчний “Өөрчлөлтийн төлөөх иргэдийн эвсэл” намын дарга Жэймсон Тимбагийн гэрт зохион байгуулсан цугларалтын үеэр 78 хүнийг баривчилжээ.

Ангол, Буркина-Фасо, Бурунди, Гвиней, Кени, Мали, Сьерра-Леон, Танзани зэрэг улсад хүчээр алга болгох нь өргөн хүрээнд явагдсан хэвээр байна. Кени улсад Санхүүгийн тухай хуулийн төслийг эсэргүүцсэн жагсаалын үеэр хамгийн багадаа 72

хүнийг хүчээр алга болгосон хэмээн Хууль зүйн нийгэмлэг мэдээлэв. Гвиней улсад 7 дугаар сард баривчлагдсан Үндсэн хуулиа хамгаалах үндэсний фронтын гишүүд болох Омар Силла, Мамаду Билло Бах болон 12 дугаар сарын эхээр баривчлагдсан сэтгүүлч Хабиб Маруана Камара нарыг оны эцсээр хүчээр алга болгожээ.

Засгийн газрууд хүний эрх хамгаалагч, идэвхтэн, сэтгүүлч, жагсагчид болон засгийн газрыг шүүмжлэгчдийг дур зоргоор баривчлах, цагдан хорих, хүчээр алга болгох явдлыг зогсоож, хүний эрхээ тайван замаар хэрэгжүүлснийхээ төлөө баривчлагдсан хүн бүрийг нэн даруй, болзолгүйгээр суллаж, хүчээр алга болгосон хүний нөхцөл байдал, хаана байгааг ил болгох ёстой.

ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд 2023 оны дөрөвдүгээр сараас хойш 11 сая гаруй хүн дотооддоо шилжин дүрвэсэн бөгөөд тэдгээрийн 8.6 сая гаруйг эзэлж байгаа Судан улс дэлхийн хамгийн том шилжилт хөдөлгөөний хямралд нэрвэгдсэн. Дотооддоо дүрвэгсдийн тоогоор тэргүүлж байгаа бусад улс орнуудад БНАКУ (7.3 сая), Буркина Фасо (2 сая), Өмнөд Судан (2 сая), Сомали (552,000), ТАБНУ (455,533), Мали (331,000) багтжээ. Дотооддоо дүрвэгсдийн хуарангийн нөхцөл байдал хүнд хэвээр байгаа бөгөөд зэвсэгт бүлэглэлийн тасралтгүй дайралт нөхцөл байдлыг улам хурцатгаж байна. НҮБ наймдугаар сард Суданы Хойд Дарфур муж дахь дүрвэгсдийн Замзам хуаранд өлсгөлөн нүүрлэсэн болохыг зарласан.

Мөргөлдөөний бүс нутгаас дүрвэж байгаа хүмүүсийн тоо нэмэгдсээр байна. Хөрш орнуудад дүрвэсэн Суданы иргэдийн тоо 3.2 сая давжээ. Тэд маш хүнд нөхцөлд аж төрж байгаа бөгөөд Египет улс тэдгээр иргэдийн Судан руу албадан буцаах хүртэл олон зуун хүнийг дур зоргоор цагдан хорив. 1-3 дугаар сарын хооронд Египетийн эрх баригчид Суданы 800 орчим иргэнийг албадан буцаажээ.

Алжир улсад 1-8 дугаар сарын хооронд янз бүрийн улс орны 20,000 гаруй цагаачдыг Нигерийн Агадез бүс нутгийн Ассамака хот руу хөөжээ. Тавдугаар сард хэд хэдэн хүн Ассамака руу явах, эсхүл ирэх замдаа хэт ядарсны улмаас нас барсан.

Засгийн газар дүрвэгсэд болон цагаачдыг эрх зүйн байдлаас нь хамааран дур зоргоороо баривчлахыг таслан зогсоож, тэднийг албадан буцааж, хоморголон хөөхөөс хамгаалах ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ, АЛАГЧЛАХ

Этиоп улсад долоон настай Хэвон Авотыг хүчиндэж хөнөөсөн хэрэг, Сьерра-Леон улсад гурван охиныг зэрэмдэглэж амь насыг хохироосон хэрэг бүс нутагт охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл улам бүр газар авсныг бэлхнээ илтгэв. Гэхдээ эерэг өөрчлөлтүүд хэд хэдэн улсад бүртгэгдсэн. Зааны Ясан Эрэг улсын Үндэсний ассамблей цус ойртолтын тохиолдолд үр хөндөлтийг зөвшөөрөх Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг баталсан. Экваторын Гвиней улсын засгийн газар жендэрийн ялгааг арилгах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээг тодорхойлсон тунхаглалыг баталсан. Гамби улсын парламент эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг хориглосныг хүчингүй болгох хуулийн төслийг буцаасан. Сьерра-Леон улс эрт болон бага насны гэрлэлтийг хуулиар хориглосон. Өмнөд Африк улсын Претория дахь Дээд шүүхээс бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн санаа зорилгын субъектив шалгуурыг үндэслэн гэмт этгээд гомдол гаргагчийг зөвшөөрсөн хэмээн алдаатай буюу үндэслэлгүй итгэсэн бол гэмт хэрэгт тооцохгүй байх зохицуулалт нь Үндсэн хуульд нийцэхгүй хэмээн үзсэн.

Идэвхтнүүд ЛГБТИ хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах тухай Хүний болон Ард түмний эрхийн тухай Африкийн Комиссын 275 тоот тогтоолын 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байхад, харин эрх баригчид тэднийг онилж, ялгаварлан гадуурхахын тулд эрх зүйн тогтолцоог зэвсэг болгон ашигласаар байна. Мали улсад ижил хүйстнүүд зөвшилцөн бэлгийн харьцаанд орсон тохиолдолд хорих эсвэл торгох ял оноох шинэ Эрүүгийн хууль батлагдсан. Буркина Фасод гэр бүлийн хуулийн төсөлд ижил хүйстнүүдийн зөвшилцлийн бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцохоор тусгасан нь эрсдэлд хүргэв. Гана улсын парламент ЛГБТИ хүмүүст эрүүгийн ял оноох хуулийн төслийг батлав. Малави болон Уганда улсын шүүхээс насанд хүрсэн ижил хүйстний зөвшилцөлд үндэслэсэн бэлгийн харьцааг хориглох шийдвэрийг хэвээр үлдээсэн. Эсватини улсын засгийн газар ЛГБТИ байгууллагыг бүртгэхээс татгалзсан хэвээр байна. Гэвч зарим эерэг өөрчлөлт гарсан. Ботсвана улсад интерсекс хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулсан бол Намиби улсын Дээд шүүх ижил хүйстнүүдийн харилцан тохиролцсон бэлгийн харилцааг хориглосон хуулийг цуцалсан.

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт, жендерт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэртэй тэмцэж, үндсэн шалтгааныг арилгах, хорт зуршлыг арилгах хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Засгийн газрууд ЛГБТИ хүмүүсийн эсрэг хуулиа хүчингүй болгож, ижил хүйстнүүдийн зөвшилцлийн бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцохоос татгалзах ёстой.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг нөхцөлдүүлснийхээ төлөө гол хариуцлага хүлээх өндөр орлоготой улс орнууд алдагдал, хохирол болон дасан зохицох арга хэмжээнд хангалттай санхүүжилт гаргаж чадсангүй. Үүний уршгаар олон сая хүн ган гачигт өртөж, олон мянган хүн аадар бороо, үерт нэрвэгдэв. Камерун, Кот-д’Ивуар, Мадагаскар, Мали, Нигер зэрэг улсад үерийн улмаас нас барсан тохиолдол бүртгэгдсэн. Нигер улсад үерийн улмаас хамгийн багадаа 339 хүн нас барсан бол Мали улсад 177 хүн амиа алджээ. Мадагаскарт Гаман хар салхины улмаас 18 хүн амиа алдаж, 20,737 хүнийг нүүлгэн шилжүүлж, зам, гүүр зэрэг үндсэн чухал дэд бүтэц эвдэрч сүйдсэн.

Уур амьсгалын өөрчлөлтийн хямралыг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн засгийн газар санхүүжилт авсан нь өрийн дарамтыг нэмэгдүүлсэн зардлыг л бий болгов. Зааны Ясан Эрэг уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч рүү шилжихийн тулд 1.3 тэрбум ам.долларын санхүүжилт авчээ. Намиби улс “ногоон устөрөгч” хэмээн нэрлэх хөгжлийн төсөлд 10 тэрбум ам.долларын санхүүжилт авчээ. Түүнчлэн Өмнөд Африкийн засгийн газар уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах, тэсвэрлэх чадвар бий болгох зорилгоор уур амьсгалын өөрчлөлтийн сан байгуулснаа зарлав. Мадагаскар улсын засгийн газар 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 28%-иар бууруулах үүрэг хүлээсэн. Конго улсын засгийн газар ойр орчмын хүн амын эрүүл мэнд, үүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлийг харгалзан Пуинте Нуар бүс нутгийн Виндулоу дахь Месса Конго дахин боловсруулах компаний үйл ажиллагааг түр зогсоосон. Сенегал улсын эрх баригчид олборлолтын явцад химийн бодис ашиглахтай холбоотой эрүүл мэнд, байгаль орчны асуудлаас үүдэн 2027 оны дунд үе хүртэл Фалеме голын эрэг дагуух бүх уурхайн үйл ажиллагааг зогсоосон.

Засгийн газрууд олон улсын тусламж болон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их хариуцлага хүлээх улс орнуудаас санхүүжилт эрэлхийлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалах, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдэд бэлэн байдлаа бэхжүүлэх арга хэмжээ яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨХ

Олон улсад ял шийтгэл хүлээхгүй байх нь өргөн тархсан хэвээр байв. Эсватини улсын засгийн газар 2021-2024 оны хооронд шүүхийн шийдвэргүйгээр хүний амь насыг хөнөөх хэрэг, тухайлбал 2023 онд хүний эрхийн хуульч Тулани Масекогийн амь насанд халдсан хэргийг мөрдөн шалгасангүй. Этиоп улсын засгийн газар хүний эрхийн байгууллагуудын баримтжуулсан гэмт хэргүүдийг хэрэгсэхгүй болгосон хэвээр байгаа бөгөөд “шилжилтийн шударга ёс” санаачилга нь зөвхөн эвлэрэх асуудлаар хязгаарлагдаж үр ашиггүй “цаасны ажил” болж үлдэв. Сенегал улсад 3 дугаар сард батлагдсан Өршөөлийн тухай хуулиар 2021 оны 3 дугаар сараас 2024 оны 2 дугаар сарын хооронд эсэргүүцлийн жагсаалд оролцсон болон хөндлөнгөөс харж байсан 64 хүнийг хөнөөсөн хэрэгт эрүүгийн ял оноох ажиллагааг зогсооход хүргэв.

Гэхдээ олон улсын эрх зүйн хүрээнд шударга ёсыг дэмжих, гэмт хэрэгт хариуцлага тооцох арга хэмжээ хэд хэдэн улсад бүртгэгдсэн. ТАБНУ-д НҮБ-ын дэмжлэгтэйгээр Эрүүгийн хэргийн тусгай шүүх хоёр сэжигтнийг баривчилсан бөгөөд ерөнхийлөгч асан Франсуа Бозизег 2009-2013 оны хооронд ерөнхийлөгчийн хамгаалалтын албаныг нь үйл ажиллагаатай холбоотойгоор хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр олон улсын баривчлах шийдвэр гаргажээ. Гамби улсын Үндэсний ассамблей 4 дүгээр сард Тусгай хариуцлагын Механизм болон Тусгай прокурорын газар байгуулах тухай хуулийг баталсан. Баруун Африкийн улс орнуудын Эдийн Засгийн Нийгэмлэг арван хоёрдугаар сард Гамби улсын асуудал хариуцсан тусгай шүүх байгуулахаар тохиролцсон нь ерөнхийлөгч асан Яхья Жаммегийн үед үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага тооцох ахиц дэвшлийг харуулсан юм. Өмнөд Суданд үнэнийг мэдэх эрх, хохирлыг барагдуулах комисс байгуулах хууль батлагдсан хэдий ч Өмнөд Суданы холимог хэлбэрийн шүүх байгуулах ажил гацсан хэвээр байв.

Гвинеи улсын Диксинн эрүүгийн шүүх 2009 оны есдүгээр сард цэнгэлдэх хүрээлэнд болсон аллагатай холбогдуулан ерөнхийлөгч асан Мусса Дадис Камара зэрэг найман хүнийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн буруутгах зэргээр хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн сэжигтнийг яллах дүгнэлт гарсан. Олон улсын эрүүгийн шүүхээс Аль Хассан Аг Абдул Азизд 2012 оны тавдугаар сараас 2023 оны нэгдүгээр сарын хооронд Малид үйлдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт 10 жилийн хорих ял оноолоо.

Засгийн газрууд олон улсын эрх зүйн эсрэг гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчлийг шуурхай, нягт нямбай, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн шалгах замаар ял завшихаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх ёстой.

АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Америк тивд хүний эрх хамгаалагчдыг дур зоргоор цагдан хорих, гүтгэх кампанит ажил өрнүүлэх, хүчээр алга болгох, албадан нүүлгэн шилжүүлэх, хууль бусаар тандах, заналхийлэх, эрүүдэн шүүх болон шударга бусаар шүүх зэргээр гутаан доромжилж, дарамталж, амь насанд нь халдаж байна.

Сэтгүүлчдийг хөнөөх, олон нийтийг хууль бусаар тандах зэргээр хэвлэлийн эсрэг халдлага, дарамт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эрсдэлд оруулж байна. Хязгаарлах зохицуулалт, хууль сахиулах байгууллагын дарангуйлал нь жагсаал цуглаан хийх эрхэд саад учруулав.

Улс орнууд хүнийг хүчээр алга болгох, шүүхээс гадуур цаазлах зэрэг хүний эрхийн ноцтой зөрчил болон олон улсын эрх зүйд заасан гэмт хэргийг мөрдөн шалгаж, гомдлыг шийдвэрлэж чадсангүй. Улс төрийн дарангуйлал, өнгөрсөн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэгт хариуцлага тооцоход зарим нэг ахиц дэвшил гарсан. Америк хоорондын хүний эрхийн тогтолцоо нь үнэн, шударга ёсыг тогтоох, хохирлыг нөхөн төлүүлэх бүс нутгийн хүчин чармайлтын гол оролцогч хэвээр байна.

Шударга бусаар шүүх, дур зоргоор хоморголон цагдан хорих нь дарангуйлал, аюулгүй байдлыг хангах стратегийн нэг хэсэг болж өдөр тутмын үзэгдэл болов. Зарим улсад хараат бус байдал нь алдагдсан шүүхээр яллаж байна.

Иргэдийг Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл, уугуул хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт өргөн тархсан хэвээр байна. Бүс нутаг даяар ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах нь бүртгэгдсэн. Хүчирхийлэл нь трансжендэр хүмүүст ноцтой нөлөөлсөн.

Улс орнууд уур амьсгалын хямралын хүний эрхийн нөлөөллийг багасгах талаар шаардлагатай арга хэмжээг авч чадсангүй. Түймэр, үерийн аюулд хэд хэдэн улс өртсөн.

Улс орнууд эдийн засаг, нийгмийн эрхийг хангах үүргээ биелүүлээгүй бөгөөд энэ нь ялгаварлан гадуурхалтад өртсөн нийгмийн бүлгүүдэд ноцтой нөлөөлсөн. Энэ бүс нутагт ядуурал, тэгш бус байдал газар авсан. Эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй, санхүүжилт хомс байсан бөгөөд хүнсний аюулгүй байдал алдагдсан нь олон сая хүнийг хамарсан.

Бүс нутаг даяар эмэгтэйчүүдийн амь насанд халдах, бэлгийн хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэл тасралтгүй үргэлжилсэн бөгөөд ял шийтгэл хүлээхгүй үлдэх нь хэвээр байна. Хууль болон практикт үр хөндүүлэхийг хориглож, хязгаарласан нь давхар алагчлалд өртдөг нийгмийн бүлэгт илүүтэй нөлөөлж байна. Хэд хэдэн улс нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг бууруулсан бодлогыг хууль болон практикт нэвтрүүлсэн.

Уугуул хүмүүс хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, алагчлалд өртсөн хэвээр байгаа бөгөөд хэд хэдэн улсад тэдний чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах эрхийг нь үгүйсгэв. Төрийн, төрийн бус оролцогчдын хүчирхийлэл нь ихэвчлэн газрын эзэмшил, газрын эрхийн асуудал, олборлох үйлдвэрлэлтэй холбоотой байв.

Мянга мянган хүмүүс хавчлага, хүний эрхийн зөрчил, аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавраас болж олон улсын хамгаалалтыг эрэлхийлж, улс орноо орхин бүс нутаг даяар нүүн шилжсэн хэвээр байна. Олон тооны цагаачид, дүрвэгсэд, орогнол хүсэгчид

хүчирхийлэл, гадныхныг үзэн ядах үзэл, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл, эрхээ хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн болон хүнд суртлын хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар байна.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ

Энэхүү бүс нутагт хүний эрх хамгаалагчдыг дур зоргоор цагдан хорих, гүтгэх кампанит ажил явуулах, хүчээр алга болгох, албадан шилжүүлэх, хууль бусаар тандах, амь насанд нь халдах, заналхийлэх, эрүүдэн шүүх, шударга бусаар шүүх зэрэг хүний эрхийн зөрчил үргэлжилсээр байна. Бүс нутгийн хэмжээнд эмэгтэйчүүд, афро үр удам, уугуул хүмүүс, ЛГБТИ хүмүүс хүний эрхийн хамгийн эмзэг бүлэгт хамаардаг. Сураггүй алга болсон хүмүүсийг хайж буй эмэгтэйчүүд өндөр эрсдэлтэй тулгарсан.

Газар, орон нутаг, байгаль орчныг хамгаалагчид Канад, Эквадор, Эль Сальвадор, Гватемал, Гондурас, Мексик зэрэг улсын засгийн газрын эрх мэдэлтнүүд болон төрийн бус оролцогчдын халдлага, дарамтад өртөх эрсдэлтэй байв. Боливи улсад Мадидигийн үндэсний цэцэрлэгт хүрээлэнг хамгаалж байсан хамгаалагчид заналхийлэл, халдлагад өртсөн бол Перу улсад газар, нутаг дэвсгэр, байгаль орчныг хамгаалагч дөрвөн хүн амь насаа алдсаны гурав нь уугуул хүмүүсийн удирдагч байв.

Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах механизмыг хангалттай баталгаажуулж чадсангүй. Бразил улс Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хөтөлбөрийг нийт улсын тал хүрэхгүй хэсэгт хэрэгжүүлсэн. Гондурас улсад орон нутгийн байгууллагууд үндэсний хамгаалалтын механизм сул, үр дүнгүй байгаа талаар асуудал дэвшүүлсэн. Перу улсын Дотоод хэргийн яам хүний эрх хамгаалагчдыг цагдаагийн байгууллагатай хамтран хамгаалах талаарх зохицуулалт дутмаг хэвээр байна. Гэвч зарим ахиц дэвшил гарсан. Гватемал улсын засгийн газар хүний эрх хамгаалагчдын эрсдэлд дүн шинжилгээ хийх үүрэгтэй албан ёсны байгууллагыг дахин сэргээсэн байна.

Хүний эрх хамгаалагчид айх айдасгүй, аюулгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжийг улс орнууд баталгаажуулах ёстой. ТББ болон хүний эрхийн бусад холбоо, хөдөлгөөнүүдийг хүндэтгэж, ажлаа явуулах боломж олгох ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрх чөлөөний уулзвар болох иргэний орон зай бүс нутгийн засгийн газруудын заналхийлэлд өртсөн бөгөөд цаашид өсөх хандлагатай байна.

Хэвлэл мэдээлэл рүү халдах, тэднийг дарамталж байгаагаас болж Аргентин, Бразил, Колумб, Куба, Сальвадор, Гватемал, Мексик, Никарагуа, Парагвай, Уругвай, Венесуэл зэрэг улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эрсдэлд оров. Колумб, Мексик улсад дээрх төрлийн хэд хэдэн хүчирхийллийн улмаас хүний амь нас эрсэдсэн. Аргентин болон Сальвадор улсад эмэгтэй сэтгүүлчид бэлгийн дарамт, цахим хүчирхийлэлд өртсөн.

Хэд хэдэн улсад сэтгүүлчдэд эрүүгийн ял оноож, эрх мэдэлтнүүд нь гутаан доромжлов. Кубад 9-10 дугаар сарын хооронд эрх баригчид хамгийн багадаа 20 сэтгүүлчийг дуудан авчирч эрүүгийн хэрэг үүсгэнэ хэмээн сүрдүүлж, өөрсдийгөө буруутгаж байгаа бичлэг хийхэд хүргэсэн. Тэдний гар утас, зөөврийн компьютерыг хураан авчээ. Никарагуад хэвлэл мэдээллийн байгууллагын хөрөнгийг хураан

авсан бол Венесуэлд радио станцууд хаагдсан хэвээр байгаа бөгөөд засгийн газар нийгмийн цахим сүлжээнд нэвтрэхэд саад учруулсан. Мексикт хамгийн багадаа дөрвөн сэтгүүлч амиа алдсан бөгөөд магадлан итгэмжлүүлэхээр ерөнхийлөгчийн албанд өгсөн 324 сэтгүүлчийн хувийн мэдээллийг задруулж, цахим хуудсанд нийтэлжээ.

Зарим улсын засгийн газар төрийн бус байгууллагуудыг хянах, хязгаарлах, хаах хүчин чармайлтаа үргэлжлүүлсэн хэвээр байв. Парагвай болон Венесуэл улсад иргэний нийгмийн байгууллагуудад тавих хяналтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь зогсоох, гишүүдийнх нь эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх зэргээр дур зоргоор хязгаарлах хуулийн төслүүдийг баталлаа. Перу улсад үүнтэй төстэй хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд оны эцсээр батлахаар хүлээж байв.

Хууль бус тандалт бусад хувийн нууцад халдах зөрчил үргэлжилсээр байна. Аргентин, Чили улсад нүүр царай таних болон бусад технологийг ашиглан хоморголон тандалт хийсэн мэдээлэл гарсан. АНУ-д цагаачлал, дүрвэгсэдтэй холбоотой ажиллагаанд заавал хэрэглэх нүүр царай таних, GPS-ийн хяналтын систем бүхий гар утасны программ нь дээрхтэй ижил санаа зовнилыг бий болголоо. Колумб улсад электрон төхөөрөмжид бүрэн, хязгаарлалтгүй нэвтрэх боломжтой өндөр халдлагын тагнах программ болох Pegasus-ийг 2021 онд худалдаж авсан талаарх маргаан гарсан.

Эсэргүүцлийн жагсаалыг дарах, саад учруулах нь бүс нутагт санаа зовоосон асуудал хэвээр байна. Аргентин, Куба, Мексик, АНУ, Венесуэл зэрэг улсын хууль сахиулах байгууллагууд эсэргүүцлийн жагсаалыг дарангуйлсаар байна. Канад, АНУ-д Израилын Газа дахь дарангуйллыг эсэргүүцэн оюутнуудын зохион байгуулсан тайван жагсаал цуглаан хууль сахиулах байгууллагын хүчирхийлэлтэй тулгарав. "Венесуэлийн Нийгмийн мөргөлдөөний ажиглалт" ТББ-ын мэдээлснээр, 7 дугаар сарын 29-30-ны хооронд тус улсад 915 эсэргүүцлийн жагсаал бүртгэгдсэнээс 138-ыг нь аюулгүй байдлын хүчнийхэн болон засгийн газрыг дэмжигч зэвсэгт бүлэглэлүүд даржээ. Аргентин, Никарагуа, Перу зэрэг улсад эсэргүүцлийн жагсаал хийх эрхийг хязгаарлах шинэ журмыг баталсан, эсхүл санал болгосон нь иргэний орон зай улам хумигдаж байгааг илтгэж байна.

Улс орнууд иргэний орон зайг хамгаалж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрх чөлөөнд саад учруулж буй хууль тогтоомж, практикийг халж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хууль бус тандалтыг хориглох ёстой.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨХ

Улс орнууд тус бүс нутаг дахь хүчээр алга болгох хэргийг шалгаж, шийдвэрлэж чадсангүй. Аргентин улсын засгийн газар 1976-1983 оны цэргийн дэглэмийн үед хүчээр алга болгосон хүүхдүүдийг эрэн сурвалжлах Тусгай мөрдөн байцаах албыг татан буулгах шийдвэр гаргасан. Перу улсад 2002 оноос өмнө үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох хууль хүчин төгөлдөр болов. Колумб, Куба, Эквадор, Мексик, Венесуэлд хүчээр алга болгох шинэ тохиолдлууд гарлаа.

Хууль бус аллагад ял шийтгэл оногдуулаагүй бөгөөд зарим нь шүүхээс гадуур цаазалсан хэрэг байж болзошгүй байна. Эквадор улсын Прокурорын газар оны эхний хагаст шүүхээс гадуур цаазаар авах ял нэмэгдэж магадгүй гэж мэдэгджээ. Мексикийн цэргийн албан хаагчид хэд хэдэн мужид цагаачид болон хүүхдүүд рүү халдаж, амь насыг нь хөнөөсөн. Венесуэлд ерөнхийлөгчийн сонгуулийн дараа засгийн газар эсэргүүцлийн жагсаалыг нухчин дарсны улмаас хамгийн багадаа

24 хүн амь үрэгджээ. Эквадор, Сальвадор, Никарагуа, Венесуэл зэрэг улсад хорих газарт ял эдэлж байгаа хоригдлуудыг эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан.

Гаитид гэмт хэргийн бүлэглэлүүдийн хүчирхийлэл тасралтгүй үргэлжилсээр байв. Тэдгээр бүлэглэлийг аллага, зэрэмдэглэх, хүчиндэх болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэр, түүнчлэн сургууль, эмнэлэг рүү халдсан, хүн хулгайлах, хүмүүнлэгийн тусламжийг тасалдуулах зэрэг тоо томшгүй олон хүчирхийлэлд буруутгасан.

Чили, Колумб, Эквадор, Гватемал, Гондурас, Никарагуа, Перу, Венесуэл зэрэг улсад өмнөх жилүүдэд өрнөсөн жагсаал цуглаан болон бусад улс төрийн дарангуйллын үеэр хүний эрхийг зөрчсөн үйлдэлд хариуцлага хүлээгээгүй хэвээр байна. Гэхдээ жилийн хугацаанд зарим эерэг өөрчлөлт бүртгэгдлээ. Чили, Перу улсад дарангуйллын хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн бол Бразил улсад 2014 онд хүчээр алга болгосон Дави Фиуза-г хулгайлж, хилс хэрэгт буруутган хорьсон хэрэгт холбогдуулан цэргийн цагдаагийн таван офицерыг яллагдагчаар татсан. Мөн аравдугаар сард 2018 онд хүний эрх хамгаалагч Мариэль Франко болон түүний жолооч Андерсон Гомес нарын амь насыг хөнөөсөн хэрэгт холбогдуулан хоёр эрэгтгэйд ял оногдуулсан. Парагвай улсад 1976 он буюу цэргийн дэглэмийн үед эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдсэн тухайн үед цагдаагийн албан хаагч байсан хүнд 30 жилийн хорих ял оноожээ.

Үнэнийг мэдэх, хохирлыг арилгах механизм үр дүнтэй байсан ч хангалтгүй хэвээр байна. Бразил улсад Улс төрийн аллага, сураггүй алга болгосон хүмүүсийн талаарх тусгай комиссыг дахин сэргээх зэргээр үнэнийг мэдэх бодлогод ахиц гарсан. Мексик улсад Үнэн ба түүхийг тодруулах механизм нь 1965-1990 оны хооронд өрнөсөн хүний эрхийн ноцтой зөрчлийн талаар хоёр илтгэл танилцуулсан. Перу улсын шүүхээс 1990-ээд оны үед албадан үргүйдүүлсэн хохирогчдод нөхөн олговор олгох үйл явцыг эхлүүлэх шийдвэрийг гаргасан. ОУЭШ-ээс Венесуэлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх хэргийг мөрдөн шалгах ажиллагааг сэргээх зөвшөөрөл олгосон.

Америк хоорондын хүний эрхийн систем нь үнэнийг мэдэх, шударга ёс, хохирлыг нөхөн төлөхөд чиглэсэн бүс нутгийн хүчин чармайлтын гол оролцогч хэвээр байна. Уг механизм нь Канад дахь уугуул хүмүүсийн мөнгөн усны хордлогын талаарх асуудалд байр сууриа илэрхийлж, Гондурасын Гарифуна бүлгийн газрыг нөхөн сэргээхийг дэмжиж, Никарагуад дур зоргоор баривчлагдсан хүмүүсийг хамгаалах тушаал гаргасан. Түүнчлэн “Хосе Альвеар Рестрепо” Хуульчдын хамтын нийгэмлэгийн эсрэг хяхан хавчих кампанит ажил зохион байгуулсан хэрэгт Колумб улсыг буруутгасан бол 1994 онд Аргентин, Израилын Хамтын нийгэмлэгийн төв байранд болсон халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй хэмээн Аргентин улсыг буруутгасан.

Улс орнууд хүний эрхийн зөрчил болон олон улсын эрх зүйн гэмт хэргийн талаар үнэнийг мэдэх эрх, шударга ёс, хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулж, гэмт хэрэгт сэжиглэгдсэн бүх хүнд хариуцлага хүлээлгэхийн тулд шүүхэд шилжүүлж, хэргийг ердийн шүүхээр шударгаар шүүх ёстой.

ДУР ЗОРГООР ЦАГДАН ХОРИХ, ШУДАРГА БУСААР ШҮҮХ

Шударга бусаар шүүх, дур зоргоор цагдан хорих үйл ажиллагаа нь өдөр тутам өрнөдөг дарангуйллын хэлбэр, олон нийтийн аюулгүй байдлын стратегийн нэг хэсэг болсон хэвээр байна. Кубын Нуэвитас хотод 2022 онд болсон тайван жагсаалд оролцсон 14 хүнд эрүүгийн ял оногдуулсан. Гватемал улсад прокурор асан Виржина Лапарраг дур зоргоор цагдан хорьж сулласны дараа төд удалгүй үндэслэлгүйгээр

эрүүгийн хэрэгт яллаж гэм буруутай хэмээн үзсэн нь түүнийг эх орноосоо хөөгдөхөд хүргэсэн. Никарагуа дахь Улс төрийн хоригдлуудыг хүлээн зөвшөөрөх Механизм нь тус улсад хамгийн багадаа 151 хүнийг улс төрийн шалтгаанаар цагдан хорьсон болохыг баримтжуулжээ. АНУ-д уугуул Америкийн идэвхтэн Леонард Пелтиер түүнд оногдуулсан бүх насаар нь хорих ял эдэлсээр байгаа бөгөөд түүнийг гэм буруутайд тооцож, ял оногдуулсан нь ноцтой санаа зовних асуудал байсан хэвээр байна. Венесуэл улсад хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчдийг гэмт хэрэгт яллаж, дур зоргоор баривчилсан хэвээр байгаа бөгөөд сонгуулийн дараа хамгийн багадаа 2000 хүн, түүний дотор 200 хүүхдийг дур зоргоор баривчилсан нь нийгмийн бүхий л түвшний хүмүүсийг эрсдэлд орууллаа.

Аюулгүй байдлын стратегитай холбоотойгоор хуулиар тогтоосон шударга журамгүйгээр хүмүүсийг хоморголон олноор нь цагдан хорих нь санаа зовоосон асуудал хэвээр үлдэв. Эквадор улсын хууль сахиулах байгууллагууд зөвтгөх үндэслэлгүйгээр олон мянган хүнийг дур зоргоор баривчилсан. Сальвадор оңц байдал зарласан нь хүмүүсийг хоморголон дур зоргоор баривчлахад хүргэсэн болохыг Америк хоорондын хүний эрхийн комиссын тайланд дурджээ. НҮБ-ын Дур зоргоор саатуулах ажлын хэсэг Мексикт дур зоргоор цагдан хорих, тэр дундаа arгаго (шийтгэл оногдуулахгүйгээр таслан сэргийлэх зорилгоор цагдан хорих) болон шүүхийн өмнөх шатанд шууд цагдан хорих үйл ажиллагааг системтэйгээр хэрэглэж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлэв. Гэвч үүнийг үл харгалзан Мексикийн конгресс шүүхийн өмнөх шатанд шууд цагдан хорих гэмт хэргийн жагсаалтыг нэмэгдүүллээ. АНУ-ын эрх баригчид цагаачдыг дур зоргоор олноор нь хоморголон цагдан хорих тогтолцоог өргөжүүлсэн.

Венесуэл зэрэг улсад дур зоргоор цагдан хорих үйл ажиллагааг богино хугацаанд хүчээр алга болгож, дараа нь хараат бус байдал хангагдаагүй шүүхээр шударга бусаар шүүж байна. Шүүгчдийн болон хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай Илтгэгч Болив улсад шүүхийн сонгууль жил гаруй хугацаанд хойшилсон нь хараат бус, шударга шүүгч байх эрхэд сөргөөр нөлөөлж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлэв. Америк хоорондын хүний эрхийн комисс Гватемал улсад хийсэн айлчлалын үеэр үндэслэлгүйгээр эрүүгийн ял оногдуулж байгаа нь тус улсад шүүхийн хараат бус байдал хангалтгүй байгаагийн нотолгоо хэмээн онцолсон. Мексик улс үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж бүх шатны шүүгчдийн сонгуулиар томилохоор хуульчилсан нь шүүхийн хараат бус байдлыг алдагдуулсан.

Эрх баригчид дур зоргоор цагдан хорихыг таслан зогсоож, шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулах шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Арьс үндсээр болон уугуул хүмүүсийг ялгаварлан гадуурхах нь бүс нутагт үргэлжилсээр байна. 8 дугаар сард Америк хоорондын хүний эрхийн комисс бүтцийн шинжтэй арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл болон арьс үндсээр ялгаварлан гадуурхалт нь афро гаралтай хүмүүс болон овгийн бүлгүүдийн эрхийг бүрэн хангахад саад учруулж байгааг хүлээн зөвшөөрч, улс орнуудыг нөхөн засварлах шударга ёсны тогтолцоог иж бүрэн байдлаар хэрэгжүүлэхийг уриалсан.

Бразил, Эквадор, АНУ-д хууль сахиулах үйл ажиллагаанд афрочуудын үр удмыг онилж, тэдэнд илүүтэй сөргөөр нөлөөлсөн. Канад улсын Холбооны шүүхээс ажилд авахдаа хар арьстнуудыг арьс үндсээр ялгаварлан гадуурхдаг болохыг тогтоолгох талаар төрийн нийтийн албанд ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан ажилтнуудын гаргасан хамтын нэхэмжлэлийг хэлэлцэв. Доминиканы Бүгд Найрамдах Улсад өргөн хүрээтэй, бүтцийн шинжтэй арьс үндсээр ялгаварлан гадуурхалт байсан хэвээр байна. Ялангуяа энэ төрлийн ялгаварлан гадуурхалтад

Гаити гаралтай Доминиканчууд болон хамгаалалт хүссэн Гаитигийн орогнол хүсэгчид ихээр өртөж байна.

Бразилын Уугуул хүмүүсийн яамны мэдээлснээр тус улсад 537,941 уугуул хүн хүнсний аюулгүй байдлын асуудалтай тулгарчээ. Канадын цагдаа нар нэг сарын дотор есөн уугуул хүнийг хөнөөсөн. Колумбын уугуул хүмүүс болон афрочуудын үр хойч хүний эрхийн зөрчил, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлийн үр дагаврыг илүүтэй амсаж байгаа бөгөөд томоохон хэмжээний албадан нүүлгэн шилжүүлэлтэд харьцангуй их өртсөн.

Аргентин, Бразил, Канад, Колумб, Куба, Гватемал, Гондурас, Мексик, Парагвай, Перу, Пуэрто-Рико, АНУ, Венесуэл улсад ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал бүртгэгдсэн. Хүчирхийлэл нь трансжэндэр хүмүүст илүү өртсөн. Gay da Bahia хүний эрхийн бүлгийн 2024 онд гаргасан тайланд дурдсанаар Бразил улсад 2023 онд хүний эрхийн хүчирхийллийн улмаас 257 хүн нас барсан бөгөөд үүнд голдуу хар арьст трансжэндэр залуучууд өртжээ. Колумб улсад 21 трансжэндэр эмэгтэй амь үрэгдсэн хэмээн Аффирматив Карибын тэнгис ТББ мэдээлсэн. Мексикт хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлснээр хамгийн багадаа 59 трансжэндэр эмэгтэй бусдын гарт амь насаа алджээ.

Улс орнууд арьс үндсээр болон үл тэвчих бусад хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг эцэс болгож, хохирогчдын эрхийг сэргээх шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Улс орнууд уур амьсгалын хямралын хүний эрхийн нөлөөллийг багасгах шаардлагатай арга хэмжээ авсангүй. Засгийн газрууд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, чулуужсан түлшний хэрэглээг үе шаттайгаар зогсоох амлалтаа зохих ёсоор биелүүлсэнгүй. Бразил, Эквадор, Венесуэл зэрэг улс газрын тос, газрын хийн олборлолтоо нэмэгдүүлсэн. Өндөр орлоготой, хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр Канад, АНУ эрчим хүчний үйлдвэрлэлд чулуужсан түлшний хэрэглээг шийдвэрлэж чадаагүй бөгөөд хүлэмжийн хийн гол ялгаруулагч хэвээр байна. Дээрх улс мөн COP29 хурлын үеэр уур амьсгалын шинэ санхүүжилтийн хэлэлцээрийг мухардалд оруулсан.

Бүс нутагт, ялангуяа Амазоны сав газарт гарсан түймэр нь эмзэг экосистемийг сүйтгэж дэлхийн дулаарлыг бууруулахад сөргөөр нөлөөлсөн. Аргентин, Боливи, Бразил, Канад, Колумб, Эквадор, Парагвай, Перу, АНУ-д их хэмжээний ой хээрийн түймэр нүүрлэв. Экосистем, хүний эрх, тэр дундаа уугуул хүмүүс, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийн эсрэг засгийн газруудын хариу арга хэмжээ хангалтгүй байв.

Далайн түвшний өсөлт, далайн эргийн элэгдэл, үер зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар нь Америк бүс нутагт бүхэлд нь нөлөөлөв. Бразил улсын Рио Гранде-ду-Сул хотод болсон үерт 2.3 сая хүн өртөж, 600 мянган хүн дүрвэсэн. Далайн түвшин нэмэгдсэний улмаас Гондурасын Фонсекагийн булангийн иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлсөн. Мексикт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн далайн түвшин нэмэгдсэний улмаас 2023 онд нүүлгэн шилжүүлсэн Эль-Боске бүлгийн өрхүүдийг хууль ёсоор нүүлгэн шилжүүлж, шинэ орон сууцтай болжээ.

Засгийн газрууд чулуужсан түлшийг үе шаттайгаар хэрэглээнээс гаргах, олон улсын дэмжлэг, санхүүжилт эрэлхийлэх, арга хэмжээ авах зэргээр орон нутаг, үндэсний болон бүс нутгийн уур амьсгалын хямралын хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг яаралтай шийдвэрлэх ёстой. Өндөр орлого, өндөр ялгаруулалттай улс орнууд шаардлагатай санхүүжилтийг гаргах ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Улс орнууд хүний эдийн засаг, нийгмийн эрхийг хангах үүргээ биелүүлээгүй бөгөөд энэ нь ялангуяа ялгаварлан гадуурхалтад өртөж буй бүлгүүдэд сөргөөр нөлөөлөв. Бус нутагт ядуурал, тэгш бус байдал асуудал хэвээр байна. Аргентин улсын хэмнэлтийн арга хэмжээ нь хүүхэд, ахмад настнуудад харьцангуй ихээр нөлөөлсөн.

Бразил, Куба, Гватемал, Гаити, Мексик, Парагвай, Перу, Пуэрто-Рико, Уругвай, Венесуэл зэрэг улсад эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй, санхүүжилт дутмаг байсан нь эрүүл мэндийн үйлчилгээ, эмийн хүртээмжид сөргөөр нөлөөлсөн. Бразил улсад Денгүе нэрт халууралтын улмаас 2023 онд 1179 хүн нас барсан бол энэ тоо 2024 онд нэмэгдэж 6041-т хүрсэн. Гаитид эрүүл мэндийн систем ноцтой сорилтуудтай тулгарч сүйрлийн ирмэгт хүргэсэн. Пуэрто Рикод эрчим хүчний хангамж тасалдсаны улмаас эрүүл мэнд, амь нас нь электрон төхөөрөмжөөс хамааралтай хүмүүс эрсдэлд орсон. Уругвай улсад сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, эрэлт хэрэгцээ нь улам нэмэгдэж байна. Пан Америкийн эрүүл мэндийн байгууллагаас ДНБ-ий эрүүл мэндийн зардлыг 6% байхаар зөвлөсөн ч Мексик улс ДНБ-ий дөнгөж 2.9%, Парагвай 4%-ийг хуваарилжээ.

Аргентин, Боливи, Бразил, Куба, Гаити, Венесуэл зэрэг улсад хүнсний аюулгүй байдал алдагдаж олон сая хүнд тэр дундаа сая сая хүүхдүүдэд нөлөөлөв. Аргентинд тэтгэврийн доод хэмжээ амьжиргааны зардлыг нөхөж чадсангүй. Куба улсын засгийн газар хөнгөлөлттэй үнээр олгодог “үндсэн хүнсний сагс”-ын нийлүүлэлтийг мэдэгдэхүйц бууруулсан нь хүмүүс хүнсний бүтээгдэхүүн авахын тулд урт дараалалд зогсоход хүргэсэн. Гаити улсын хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн дутагдал онцгой түвшинд хүрч, хүн амын бараг тал хувьд хүмүүнлэгийн тусламж хэрэгцээтэй болов. НҮБ-ын Хүнсний эрхийн асуудал хариуцсан Тусгай Илтгэгч Венесуэлд айлчилсан бөгөөд тус улсын хүн амын бараг 53 хувь нь “үндсэн хүнсний сагс” худалдаж авахад хүрэлцэхгүй орлоготой, нэн ядууралд нэрвэгдсэн хэмээн дүгнэсэн.

Улс орнууд ядуурал, тэгш бус байдалтай тэмцэх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх хүний эрхийн үүргээ биелүүлэхийн тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой.

БЭЛГИЙН БОЛОН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бус нутаг даяар бэлгийн хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн амь насанд халдах явдал тасралтгүй үргэлжилсэн бөгөөд ял шийтгэл хүлээхгүй хэвээр байна. Боливи, Бразил, Колумби, Куба, Мексик, Парагвай, Перу, Пуэрто-Рико, Уругвай, Венесуэл зэрэг улсад эмэгтэй хүний амь насыг хөнөөсөн тоо түгшүүрийн хэмжээнд хүрснийг олон эх сурвалж мэдээлэв. Куба болон Доминиканы Бүгд Найрамдах улсын аль алинд эмэгтэй хүний амь насыг хөнөөх гэмт хэргийг хуульчлаагүй.

Аргентин улсад 33 цаг тутамд нэг эмэгтэй бусдын гарт амь насаа алдаж байгаа тохиолдол бүртгэгдсэн. Гэвч тус улсын засгийн газар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсвийг танах бодлого хэрэгжүүлсэн. 2000-аад оны эхээр Мария Изабель Велиз Франко, Клаудина Веласкес нарын эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөсөн хэргийн хариуцлагыг Гватемала улсын засгийн газар хүлээх ёстой талаарх Америк хоорондын Хүний эрхийн шүүхээс 2014, 2015 онд гаргасан шийдвэрийг тус улсын засгийн газар хүлээн зөвшөөрснөөр бага ч болов ахиц гарсан.

Бус нутгийн охид, эмэгтэйчүүд бусад хэлбэрийн хүчирхийллийн бай болсоор байна. Бразилд Холбооны Улсын Прокурорын газар эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт

суурилсан улс төрийн хүчирхийллийн хэргийг идэвхтэй хянав. Канад улсад хэд хэдэн байгууллагууд ойр дотны хүмүүсийн хүчирхийллийг тахал хэмээн нэрлэхийг Онтарио мужийн засгийн газар болон хотын захиргааны байгууллагуудад хандан уриалав. Доминиканы Бүгд Найрамдах улсад цагаачлалын ажиллагааны үеэр бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгдсэн талаар хэвлэлүүд мэдээлсэн. Гаити улсад бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа хүчингийн хэрэг оны эхний хагаст нэмэгджээ. Перу улсын засгийн газар охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн 12924 хэргийг бүртгэжээ. АНУ-ын засгийн газрын тоо баримтаас үзэхэд Америкийн индианчууд болон Аляскийн уугуул эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал уугуул бус эмэгтэйчүүдээс 2.8 дахин их байна.

Эрх баригчид охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэгт ял оногдуулдаггүй байдалд цэг тавьж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх ёстой.

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Үр хөндөлтийн хүртээмжийг хууль болон практикт боомилсон хэвээр байгаа нь ялгаварлан гадуурхалтын огтлолцсон хэлбэрүүдэд өртдөг бүлгүүдэд харьцангуй ихээр нөлөөлж байна. Доминиканы Бүгд Найрамдах улс, Сальвадор, Гаити, Гондурас, Никарагуа зэрэг улсад ямар ч нөхцөлд үр хөндөлтийг хатуу хориглосоор байна. Үр хөндөлтийн зарим тохиолдлыг гэмт хэрэгт тооцох асуудал түгшүүр төрүүлсэн хэвээр байна. Бразил улсад үр хөндөлтийг хориглосон нь ядуу амьдарч буй эмэгтэйчүүдэд харьцангуй их нөлөөлсөн хэмээн Эмэгтэйчүүдийн яам мэдээлсэн. Перу улсад зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаар үр хөндүүлэхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн боловч энэ төрлийн үр хөндөлтийн хүртээмж хангалтгүй байв. Венесуэл улс бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг сайжруулах чиглэлд ахиц дэвшил гаргаагүй бөгөөд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцсон хэвээр байна.

Хэд хэдэн улсад нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг бууруулах бодлогыг хууль болон практикт хэрэгжүүлэв. Аргентин улсад Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний төв үр хөндөлтийн үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай хангамжийн хомсдолтой байгааг мэдэгдэв. Чили улсад эрүүл мэндийн төвүүд, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрсдийн ёс суртахуун, шашны үзлээс шалтгаалан үр хөндөлтийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж, жирэмсэн хүмүүсийн үр хөндөлт хийлгэх эрхийг алдагдуулж байна. Пуэрто Рикогийн хууль тогтоох байгууллага PS 495 хуулийн төслийг баталж, насанд хүрээгүй хүүхдүүдийн үр хөндөлтийг хязгаарлаж, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг шаардаж эхлэв. АНУ-д үр хөндөлтийн хориглолт, хязгаарлалт нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд заналхийлж, хар арьст болон бусад арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хүмүүс, уугуул хүмүүс, бичиг баримтгүй цагаачид, трансжэндэр хүмүүс, орон нутгийн оршин суугчид, ядууралд өртсөн хүмүүсийн үр хөндүүлэхэд учрах саад бэрхшээлийг улам нэмэгдүүлээ. Эмнэлгийн мэргэжилтнүүд үр хөндөлтийг хатуу хориглосон мужуудыг орхин явах үзэгдэл нэмэгдсэн нь бус нутгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг тэгш бус байдлыг нэмэгдүүлж, орон нутаг болон орлого багатай бус нутгуудад ихээхэн нөлөөлж байна.

Гэхдээ зарим ахиц гарлаа. Колумб улсын Үндсэн хуулийн шүүхийн 2022 онд гаргасан шийдвэрт заасны дагуу Колумбын эрүүл мэндийн байгууллагууд жирэмсний 24 долоо хоног хүртэл хууль ёсны үр хөндөлтийн үйлчилгээнд хамрагдах эрх олгох журмыг баталлаа. Мексик улсын долоон мужид үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх тухай хууль баталсан бол нэг мужид үр хөндөлт хийлгэх хугацааг 12 долоо хоногоос зургаан долоо хоног болгон бууруулсан.

Эрх баригчид үр хөндөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн бусад эрхийг найдвартай байх баталгааг хангах ёстой.

УУГУУЛ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Уугуул хүмүүсийг ялгаварлан гадуурхах, алагчлах явдал үргэлжилсээр байгаа бөгөөд улс орнууд тэдний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлсэнгүй. Чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах эрхийг хэд хэдэн улс үгүйсгэлээ. Бolivийн засгийн газар уугуул хүмүүсийн газар нутагт нөлөөлөх олборлох төслүүдэд уугуул хүмүүсийн зөвшөөрлийг баталгаажуулах утга учиртай үйл явцыг хэрэгжүүлж чадсангүй. Канад улс Эквадор улстай чөлөөт худалдааны гэрээ байгуулахдаа нөлөөлд өртөх уугуул хүмүүстэй зөвлөлдсөнгүй.

Төрийн болон төрийн бус оролцогчдын зүй бус үйлдэл нь газрын эзэмшил болон газрын эрхтэй ихээхэн холбоотой байв. Бразил улсад уугуул хүмүүст сөргөөр нөлөөлж буй олон зуун мөргөлдөөн нь газрын хил хязгаарыг тогтоогоогүйгээс үүдэлтэй бөгөөд хилийн зааг тогтоох үйл явц удаашралтай байна. Гватемал улсад олон арван тариалан эрхлэгчид (кампесино) болон уугуул хүмүүс албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртөх эрсдэлд байв. Парагвай улсын Ава Гуарани Парананс дахь Текоха соусын уугуул хүмүүс Итайпу Бинационал усан цахилгаан станцын улмаас өвөг дээдсийнхээ нутаг дэвсгэрийг алдсаны хохирлыг нөхөн төлөхийг хүлээсээр байв. Америк хоорондын хүний эрхийн комисс Венесуэл улс дахь хууль бус олборлолт нь Яномами хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, эсэн мэнд аж төрөхөд сөргөөр нөлөөлж байгаа талаар санаа зовниж байгаагаа илэрхийлэв.

Уугуул хүмүүс бүс нутгийн хэмжээнд дарамт шахалт, хүчирхийлэлд өртсөөр байна. Бразил улсад уугуул хүмүүсийн эсрэг хүчирхийллээс хамгаалах төрийн хамгаалалт хангалтгүй байгаа бол Чили улсад хууль сахиулах ажилтнуудын дарамт, Мексик, Никарагуа улсад дотооддоо албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртөж байна. Колумбын Омбудсмены Газраас зэвсэгт бүлэглэлд элсүүлсэн хүүхдүүдийн 50 % нь уугуул хүмүүс байсан хэмээн мэдээлсэн. Канадын Бие даасан тусгай Интерлокуорын тайланд Индианчуудын суурьшлын сургуулиуд нь “геноцидын колони байгууллага” байсан болохыг хүлээн зөвшөөрсөн. АНУ-ын Дотоод хэргийн алба Индианчуудын сургуулийн дотуур байрны санаачилгын талаарх эцсийн тайланд тэмдэглэснээр 65 сургуульд тэмдэглэгдсэн болон тэмдэглэгдээгүй 74 оршуулгын газарт 973 хүн нас барсан болохыг тогтоожээ.

Улс орнууд газар нутаг болон байгалийн нөөцийг эзэмших, хараа хяналтаа хэрэгжүүлэх зэрэг уугуул хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, тэднийг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалах ёстой.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Мянга мянган хүмүүс хавчлага мөрдлөг, хүний эрхийн зөрчил, аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийн улмаас эх орноо орхин, бүс нутаг дамнан, нүүн шилжсээр байна. Цагаачид, дүрвэгсэд болон орогнол хүсэгчид Америк бүс нутагт гадны улсын иргэдийн үзэн ядах, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэлтэй тулгарсаар байв. 2015 оноос хойш 2024 оны эцэс гэхэд Венесуэль улсыг 7,89 сая гаруй хүн орхин дүрвэсэн бол хүчирхийлэл, хүний эрхийн зөрчлийн улмаас Куба, Сальвадор, Гаити, Гондурас зэрэг улсаас хүмүүс олноор дүрвэлээ. Америк хоорондын хүний эрхийн комисс 6 дугаар сард хийсэн мэдэгдэлдээ дүрвэгсэд, цагаачдыг нутаг дэвсгэрээсээ албадан гаргах, цэрэгжүүлэх, шударга хэм хэмжээгүйгээр албадан гаргах зэрэг улс орнуудын хариу арга хэмжээнд санаа зовниж байгаагаа тэмдэглэв.

Дүрвэгсэд, цагаачид эрхээ эдлэхэд хууль болон хүнд суртлын саад бэрхшээлтэй тулгарлаа. Канад улсын Гадаад ажилчны түр хөтөлбөр цагаач ажилчдын эрх зүйн байдал, хөдөлмөрийн нөхцөлийг ажил олгогчтой холбон хянадаг хэвээр байгаа нь цагаач ажилчдыг хөдөлмөрийн мөжлөгт өртөх эрсдэлд хүргэсэн. Доминиканы Бүгд Найрамдах улсын эрх баригчид шинээр ирсэн хүмүүст орогнол олгох үйл

явцын талаар мэдээлээгүй, виз болон оршин суух зөвшөөрөлд зүй бусаар саад учруулж, Гаитичуудыг хоморголон хөөж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах цагаачлалын бодлого хэрэгжүүлсэн. Мексик улсад Цагаачлалын үндэсний төв орогнол хүсэгчдэд хүмүүнлэгийн виз олгох ажлыг түргэсгэж чадаагүй нь эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд саад учруулсан. Перу улсын эрх баригчид цагаач, дүрвэгсдийг өөр улс хүлээж авах баталгаагүйгээр хөөсөөр байв. АНУ улс төрийн орогнол хүсэгчдийг АНУ-Мексикийн хилээр нэвтрүүлэхийг түдгэлзүүлж, аюулгүй байдал эрэлхийлэх эрхийг зөрчсөн бөгөөд тэднийг мөнгө, эд хөрөнгөө алдах, хулгайлагдах, ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн улсдаа орогнох зөвшөөрөл автлаа хүлээхийг албадаж байна.

Дүрвэгсэд болон цагаачид хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөөр байна. Доминиканы Бүгд Найрамдах Улсад хүчирхийлэл, хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн дайралт давтагдсан хэмээн орон нутгийн төрийн бус байгууллагууд мэдэгдэв. Чили улсын конгресс дүрвэгсэд, цагаачдыг гэмт хэрэгт тооцох тухай хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Эрх баригчид хууль бусаар албадан гаргахаа зогсоож, буцаан гаргахгүй байх зарчмыг хүндэтгэх ёстой. Улс орнууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл, гадныхныг үзэн ядах үзэлтэй тэмцэж, цагаачид, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүх эрхийг баталгаажуулах ёстой.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Улс төрийн үймээн самуун, дарангуйлал, зэвсэгт мөргөлдөөн зэрэг нь тус бүс нутагт санаа зовоосон хүний эрхийн дүр зургийг бий болгож байна. Гэхдээ хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд асар их эрсдэлийг үл тоон эрхээ шаардаж, дарангуйллын эсрэг дуу хоолойгоо үргэлжлүүлсээр байна.

Шинэ батлагдсан хууль, дүрмүүд нь хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам бүр хязгаарлах боллоо. Жагсаал цуглааныг хууль бусаар хүч хэрэглэн тараах нь улам нэмэгдэж, улмаар хүний амь нас хохирсон явдлууд ч гарч байна.

Улс төрийн өрсөлдөгчид, хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчид болон бусад хүмүүсийг мөрдөн тандаж, дур зоргоор саатуулж, эрүүдэн шүүж эсвэл бусад хэлбэрээр зүй бусаар харьцаж, хууль бусаар хөнөөх явдлууд гарсаар байна. Эдгээр хүний эрхийн зөрчлүүдэд ял шийтгэл оногдуулахгүй, улам дэвэргэж байгаа ч, Япон болон Өмнөд Солонгос улсуудад шүүхийн шийдвэр болон Үнэний комиссын зөвлөмжүүд нь хохирогчдын хохирлыг барагдуулах найдварыг төрүүлж байна.

Цаг агаарын онц ноцтой үзэгдэл, далайн түвшний өсөлт болон бусад гамшгууд удаан үргэлжлэх нь асар их сүйрэл учруулж байгаа ч засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход шаардлагатай яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлж чадахгүй хэвээр байна.

Мьянмар дахь зэвсэгт мөргөлдөөн улам хурцдаж, олон улсын эрх зүйн ноцтой зөрчилд хүрээд байна. Талибануудын засаглалын доор Афганистан дахь хүний эрх, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн эрх улам хязгаарлагдаж байгаа бол Хятад, Хойд Солонгост улс төрийн өөр үзэл бодлыг хавчин дарангуйлсаар байна.

Зарим улс орнуудад ЛГБТИ хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрөх ахиц дэвшил гарлаа. Гэвч охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл нийгэмд гүн гүнзгий нэвчсэн хэвээр байна. Олборлох болон бүтээн байгуулалтын төслүүдийн явцад нутгийн уугуул иргэд, угсаатан болон язгуур, үндэстний цөөнхийн эрхийг орхигдуулсаар байна. Эдийн засаг, нийгмийн эрх, тэр дундаа орон байр, боловсролын эрхийн зөрчил өндөр хэвээр байна. Мөргөлдөөн, дарангуйллаас зугтсан дүрвэгсэдийг албадан буцаах, тодорхой хугацаагүйгээр дур зоргоор цагдан хорих эрсдэлийг бий болгосоор байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зай улам хумигдсаар байна. Индонез, Балба, Папуа Шинэ Гвиней зэрэг улс орнуудад хэвлэл мэдээллийн ажилтнууд хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтэд өртөөд байна. Афганистанд олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглон, Талибануудыг шүүмжилсэн хоёр хувийн телевизийн үйл ажиллагаагаа зогсоожээ. Мьянмарт сэтгүүлчдийг урт хугацаагаар хорих ялаар шийтгэсэн байна. Пакистанд хамгийн багадаа долоон сэтгүүлчийг онилж, амь насыг нь хороосон бол олон арван сэтгүүлчид Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн хэргээр баривчлагдан яллагджээ.

Бангладеш, Малайз, Пакистан, Вьетнам улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шинэ хуулиуд хэрэгжиж эхлээд байна. Шри Ланка улсын шинээр батлагдсан Цахим аюулгүй байдлын тухай хуульд тусгасан гэмт хэргийн заалт нь тодорхойгүй, өргөн хүрээний эрх мэдлийг эрх баригчдад олгосон учраас тус хуулийг цаашид үг хэлэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглах вий хэмээн эмээж байна. Энэтхэг улсад колоничлолын үеийн хууль тогтоомжийн оронд шинээр батласан хуулиуд нь мөн л хүний эрхийг хязгаарласан зүйл заалттай бөгөөд засгийн газрыг шүүмжлэгчдийг нухчин дарах зорилгоор ашиглаж болох “үймээн самуун дэгдээх гэмт хэрэг” зэргийг хүчинтэй хэвээр үлдээжээ. Хятадын засгийн газар эх газрын интернэт хэрэглэгчид цахим цензурээс бултах зорилгоор хар ярианы хэллэг болон бусад “тодорхой үг хэллэгийг” ашиглахаас сэргийлэх шинэ арга хэмжээг нэвтрүүлээд байна. Хонконгийн эрх баригчид Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах журмыг шинээр батлахдаа эх газрын Хятадын “Үндэсний аюулгүй байдал” болон “төрийн нууц” гэсэн өргөн хүрээний тодорхойлолтуудыг тусгаж, хууль сахиулах эрх мэдлийг төвлөрүүлж, ял шийтгэлийг улам чангатгажээ.

Олон улс оронд засгийн газрыг шүүмжлэгчдийг яллаж байна. Тайландад ардчиллын төлөө тэмцэгчдийг эзэн хааныг гутаан доромжлох болон бусад хязгаарлалт бүхий хуулийн дагуу шүүж, цагдан хорьсоор байна. Камбожид кибер луйврын бүлэглэлийн хүний эрхийн зөрчлийг ил болгож, олон улсад танигдсан сэтгүүлчийг баривчилж, өдөөн турхирсан хэргээр яллагдагчаар татжээ. Сингапурт засгийн газрыг шүүмжлэгчид, түүний дотор цаазаар авах ялыг эсэргүүцэгчдийг “цахимаар худал мэдээлэл” тараасан хэмээн буруутган “залруулга мэдээлэл” нийтлэхийг шаардсан байна. Лаос улсад авто замын нөхцөл муу байгааг олон нийтийн цахим сүлжээгээр шүүмжилсэн хошин урлагийн хоёр уран бүтээлчийг цагдан хорьсон бол Хятадад Коммунист намын удирдлагыг шүүмжилсэн арав гаруй жилийн өмнөх бүтээлүүдийнх нь төлөө нэрт зураачийг мөн баривчлан хорьжээ.

Зарим улсад цахим болон цахим бус харилцаанд тавьсан хатуу хяналт нь мэдээллийн хүртээмж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байна. Хойд Солонгосын засгийн газраас гадаад ертөнцтэй харилцахыг хориглосон хэвээр байна. Пакистанд гэнэт интернэтийн хязгаарлалт хийсэн. Бангладеш болон Энэтхэг улсын эрх баригчид хууль, дэг журмыг сахиулах зорилгоор интернэтийг түр хугацаагаар хязгаарласан хэмээн тайлбарлаж байгаа ч бодит байдалд улс төрийн шүүмжлэгч нарыг нухчин дарах зорилгоор интернэтийг хязгаарласан. Малайз улсад өмнө нь уран бүтээлийг нь дэлгэцээр цацахыг хориглосон хоёр кино найруулагчийг “шашны итгэл үнэмшилд хохирол учруулсан” хэргээр буруутган ялажээ.

Тандах технологийн хэрэглээ санаа зовинуулсаар байна. Индонезид төрийн байгууллагууд болон хувийн компаниуд халдах чадвар өндөртэй тагнах программ худалдаалж, ашиглаж байгааг Эмнести Интернэшнл баримтжуулсан. Тайланд улсад ардчиллын төлөө тэмцэгч өөрийнх нь гар утсыг Pegasus тагнуулын программыг ашиглан хакердсан хэргээр Кибер тагнуулын программ үйлдвэрлэгч NSO Group-ийн эсрэг мэдүүлсэн хэргийг шүүхээс хэрэгсэхгүй болгожээ.

Зарим улсын засгийн газраас хилийн чанадад байгаа шүүмжлэгчдийн дуу хоолойг нухчин дарах оролдлого улам бүр газар авч байна. Гадаадад суралцаж буй эх газрын Хятад, Хонконгийн оюутнуудыг цахим орчинд мөрдөн тандсаар байна. Хонконгийн эрх баригчид хилийн чанадад амьдарч буй ардчиллын төлөө тэмцэгчдийг баривчлах тушаалыг гаргасаар байгаа бөгөөд паспортыг нь хүчингүй болгох, тэднийг баривчлахад туслах мэдээлэл өгвөл санхүүгийн урамшуулал санал болгосон. Улс төрийн хэргүүд дээр ажиллаж байсан хүний эрхийн хуульчийг 2023 онд Лаос улсаас Хятадад албадан авчирч, шүүхээс өмнөх шатанд цагдан хорьсон байна.

Засгийн газрууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн аливаа хууль тогтоомжийг халах эсвэл өөрчлөх, улс төрийн болон бусад санаа бодлоо илэрхийлэх, тэр дундаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах арга хэмжээ авах ёстой.

ХУРАН ЦУГЛАХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Ази тивийн засгийн газрууд эсэргүүцлийн жагсаалд дарангуйллын хариу арга хэмжээ авч байна. Бангладеш улсад тусгаар тогтнолын дайны ахмад дайчдын үр садад төрийн албанд ажиллах квот олгох тухай хуулийг сэргээснийг эсэргүүцсэн оюутнуудын жагсаал, цуглааны эсрэг хууль бус хүч хэрэглэжээ. Засгийн газрын эсрэг жагсаал газар авахтай зэрэгцэн зэвсэгт хүчнийг ашиглаж, “харсан даруй буудах” тушаал гаргасны улмаас мянга гаруй хүний амь насанд хүрч, олон хүнийг шархдуулсан байна. Индонез улсад сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэн жагсаалын эсрэг цагдаа нар зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэжээ. Хэдийгээр хожим нь нэмэлт өөрчлөлт оруулах төслийг эргүүлэн татсан боловч олон жагсагчдыг шархдуулж, хэдэн зуун хүнийг дур зоргоор баривчилсан байна.

Непал улсад эсэргүүцлийн жагсаалыг хүчээр тарааж, тайван жагсагчдыг цагдан хорьжээ. Нийслэл Катманду хотын цагдаа нар жагсаалыг тараахын тулд хэд хэдэн удаа нулимс асгаруулагч хий, усан хөөрөгт машин ашигласан байна. Энэтхэг улсад цагдаа нар тариачдын эсэргүүцлийн эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас наад зах нь нэг хүн амиа алджээ. Хонконгийн эрх баригчид 1989 онд болсон Тяньаньмэний жагсаалын дурсгалыг хүндэтгэх арга хэмжээ зохион байгуулахаас сэргийлэхийн тулд цагдаа нарыг дайчилсан байна. Өмнөх жилүүдийн нэгэн адил уг арга хэмжээнд оролцсоных нь төлөө хэд хэдэн хүнийг баривчилжээ. Папуа Шинэ Гвинейд цагдаа нар нийслэл Порт Морсби хотын албан бус суурингаас албадан нүүлгэхийг эсэргүүцэн жагссан хэд хэдэн хүнийг баривчилж, ял оногдуулжээ. Өмнөд Солонгосын ерөнхийлөгч онц байдал зарлаж, жагсаал, цуглаан хийх зэрэг үндсэн эрх чөлөө хязгаарлах гэж оролдсоныг Үндэсний ассамблей шуурхай хүчингүй болгов. Улмаар түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлж, арван хоёрдугаар сарын сүүлээр баривчлах шийдвэр гарсан юм.

Газын зурвас дахь дайныг зогсоох, Палестинчуудын эрхийг хамгаалахын төлөө тэмцэгчид дарамт шахалт, баривчилгаанд өртөж байна. Фижигийн цагдаа нар жагсагчдыг Израил, Палестины далбааг авч явахыг хориглож, тайван жагсагчдыг айлган сүрдүүлсэн байна. Сингапурын эрх баригчид Израилд зэвсэг худалдаалахыг эсэргүүцсэн хэд хэдэн хүнийг шалгаж, Ерөнхийлөгчийн ордонд дайны эсрэг уриалга хүргүүлэхийг завдсан өөр гурван хүнд ял оногдуулжээ. Мальдив улсад Израилын бүтээгдэхүүнийг бойкотлохыг шаардсан жагсаалын үеэр хоёр эмэгтэйг баривчлав. Цагдаа нар Малайз улсын нийслэл Куала Лампур дахь АНУ-ын элчин сайдын яамны гадаа Палестиныг дэмжсэн жагсагчдыг баривчилжээ.

Эвлэлдэн нэгдэх эрхэд ч улам халдах боллоо. Тайланд улсад шүүхээс 2023 оны парламентын сонгуулиар хамгийн олон суудал авсан сөрөг хүчний “Урагшаа хөдөл” намыг татан буулгах шийдвэрийг гаргажээ. Мөн тус намын 11 удирдах албан тушаалтныг сонгуульд нэр дэвшихийг нь хориглосон байна. Филиппин улсын засгийн газар хориотой коммунист бүлгүүд буюу “улаан туузтан” хэмээн нэрлэгдсэн хүний эрхийн идэвхтнүүд, байгууллагуудыг терроризмтой холбоотой гэмт хэрэгт буруутгасан хэвээр байна. Бангладеш, Энэтхэг, Пакистан, Шри Ланкад оёдлын цехийн ажилчид хангалтгүй цалин, албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхэд нь саад учруулав. Бангладеш улсад цалин нэмэхийг шаардсан жагсаалын үеэр цагдаа нар гал нээсний улмаас наад зах нь нэг оёдолчин амиа алдаж, олон арван хүн шархаджээ.

Засгийн газрууд тайван жагсаал хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалах ёстой. Жагсагчдын эсрэг хууль бус хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлж, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн хууль, бодлого, үйл ажиллагааг хянаж, өөрчлөх ёстой.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаг агаарын эрс тэс үзэгдлүүд, эрчимтэй гамшгийн давтамж нэмэгдэж, агаарын хорт бохирдол бүс нутгийн хэмжээнд улам дордож байгаа нь хамгийн ядуу, нийгмээс гадуурхагдсан хүмүүст илүү сөргөөр нөлөөлж байна. Уур амьсгалын санхүүжилтийг бага орлоготой орнуудад шаардлагатай байгаа зохих түвшинд тогтоох COP29 хурлын хэлэлцээрийг бүс нутгийн өндөр орлоготой, хүлэмжийн хий их ялгаруулдаг улс орнууд бусад өндөр орлоготой орнуудтай хамтран саатуулж мухардалд хүргэжээ.

Өмнөд Азийн орнууд хэт халалт болон үерийн гамшигт дахин нэрвэгдсэн нь сая сая хүний амьдралд сөргөөр нөлөөллөө. Энэтхэгийн Ассам мужид үерийн улмаас 113 хүн амиа алдав. Бангладеш улсад 500 мянган хүн дүрвэхэд хүрсэн байна. Афганистан, Пакистан, Непал улсуудад үер, хөрсний гулгалтын улмаас олон зуун хүн амиа алдаж, олон мянган хүн дүрвэжээ. Энэтхэг улсын нийслэл Дели болон Пакистан улсын хотуудын агаарын бохирдол өмнө нь байгаагүй, амь насанд хүрэхээр дээд хэмжээнд хүрсэн бөгөөд ялангуяа гадуурхагдсан бүлгийн иргэд нас барах нь олон байв.

Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, байгаль орчны хамгаалалтыг сайжруулах чиглэлд зарим нэг ахиц гарсан боловч ерөнхийдөө уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын эсрэг авсан бүс нутгийн хариу арга хэмжээ хангалтгүй байв. Хятадад анх удаа бусад эх үүсвэрээс гаргаж авсан эрчим хүч нь чулуужсан түлшнээс гаргасан эрчим хүчнээс давлаа. Гэвч Хятад улс гадны орнуудад нүүрсний цахилгаан станц барих нь эрчимтэй нэмэгдэж байгаа нь санаа зовиноож байна. Папуа Шинэ Гвинейн газар нутгийн 30%-ийг байгалийн нөөцөд авсан боловч чулуужсан түлшнээс ихээхэн хамааралтай хэвээр байна. Өмнөд Солонгос улсын шүүхээс ирээдүй хойч үеийн эрхийг хамгаалахын тулд хүлэмжийн хийг бууруулах зорилтыг шинэчлэхийг засгийн газраас шаардсан чухал шийдвэрийг гаргаад байна. Номхон далайн арлын улс орнууд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой улс орнуудын хүлээх үүрэг, хариуцлагын талаарх Олон улсын шүүхийн хэлэлцүүлэг эхлүүлэхийг дэмжлээ.

Гэвч бусад олон орны засгийн газрууд чулуужсан түлшийг бууруулах болон бусад зорилтдоо хүрч чадсангүй. Япон улс хилийн чандад шингэрүүлсэн байгалийн хийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийж байгаа нь чулуужсан түлшний хэрэглээг бууруулах дэлхийн хүчин чармайлтыг сулруулсаар байна. Австрали улс 2030 он гэхэд нүүрс, байгалийн хийн олборлолтоо багасгахын оронд нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа нь ахиц биш ухралт болж байна. Шинэ Зеланд улсад шинээр баталсан хууль нь байгаль орчны хамгаалалтыг сулруулж байгаа бол Индонезийн эрчим хүчний тухай хууль болон журмын төсөл нь хүлэмжийн хийн ялгаруулалтын тэглэх ногоон шилжилтэд дэмжлэг үзүүлж чадаагүй хэмээн шүүмжлэгджээ. Уур амьсгалын сөрөг нөлөөгөөр ноцтой хохирол амсаж байгаа ч Энэтхэгийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтууд “маш хангалтгүй” хэвээр байна.

Байгаль орчны хүний эрх хамгаалагчид бай болсон хэвээр байна. Эдгээрийн нэг нь Вьетнамд хоригдож байгаа уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөдөлгөөний тэргүүлэх зүтгэлтэн бөгөөд тэрээр цагдан хорих ангийн тэвчшгүй хүнд нөхцөлийг эсэргүүцэн гурав дахь удаагаа өлсгөлөн зарлаад байна. Камбож улсад Байгаль эх хөдөлгөөнтэй холбоотой байгаль орчныг хамгаалагч 10 идэвхтнүүдийг “хуйвалдсан” болон “эзэн хааныг доромжилсон” хэргээр яллажээ.

Засгийн газрууд гамшгийн бэлэн байдал, дасан зохицох ажиллагааны хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, шаардлагатай тохиолдолд олон улсын тусламж, уур амьсгалын санхүүжилтийг эрэлхийлэх зэргээр уур амьсгалын хямралд хамгийн ихээр өртөж буй гадуурхагдсан болон бусад эмзэг бүлгүүдийг хамгаалахад тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой. Өндөр орлоготой болон бусад хүлэмжийн хий их ялгаруулдаг улс орнууд нь

чулуужсан түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэхээ зогсоох, чулуужсан түлшний татаас дэмжлэгийг зогсоох зэргээр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад манлайлан оролцох үүрэгтэй бөгөөд тэдний уур амьсгалын бодлого нь дэлхийн дулаарлыг 1.5 хэмд байлгах зорилттой нийцэх ёстой.

ДУР ЗОРГООР БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ, ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД БАЙДЛААР ЗҮЙ БУСААР ХАРЬЦАХ

Бус нутгийн олон оронд хүний эрх хамгаалагчид, улс төрийн идэвхтнүүд болон бусад хүмүүсийг дур мэдэн баривчилж, цагдан хорьсон байна. Баривчлагдсан хүмүүсийн ихэнх нь эрүүдэн шүүлт болон бусад зүй бус харьцаанд өртжээ.

Афганистанд 20,000 гаруй хүн, түүний дотор 1,500 эмэгтэй хорих ангид хоригдож байгаа. Тэдний дотор Талибануудын ёс суртахууны дүрмийг зөрчсөн гэж буруутгагдсан улс төрийн өрсөлдөгчид болон хувь хүмүүс багтаж байна. Цагдан хоригдсон хүмүүс эрүү шүүлт болон бусад зүй бус харьцаанд өртөх эрсдэлтэй байна. Мөн цагдан хоригдож байсан хүмүүсийг шүүхээс гадуур цаазалсан хэргүүд ч гарчээ. Хойд Солонгос улсын эрх баригчид олон мянган хүнийг улс төрийн хорих лагерьд хорьсоор байгаа бөгөөд тэд хүнлэг бус нөхцөл байдал, эрүү шүүлт, бэлгийн хүчирхийлэл зэрэгт өртөж байна.

Хятадад хөдөлмөрийн эрхийн идэвхтнүүд, иргэн-сэтгүүлчид хүний эрх хамгаалсныхаа төлөө хорих ялаар шийтгэгджээ. Хонконгод ардчиллын төлөөх 45 идэвхтнийг албан бус сонгууль зохион байгуулсны төлөө “төрийг түлхэн унагахаар хуйвалдсан” хэргээр 10 хүртэлх жилийн хорих ял оноожээ. Вьетнамд засгийн газрыг эсэргүүцсэн хэргээр удаан хугацаагаар ял эдэлж байгаа хоригдлуудын эрүүл мэнд доройтсон боловч эмнэлгийн тусламж авахыг нь зөвшөөрөөгүй ажээ. Пакистан улсад 2023 онд Ерөнхий сайд асан Имран Ханыг баривчлахыг эсэргүүцэн жагссан 100 гаруй энгийн иргэнийг цэргийн хорих газарт хорьсон бол 85 хүнд цэргийн шүүхээс удаан хугацаагаар хорих ял оногдуулжээ. Сөрөг хүчний дээд удирдлагуудыг шүүхийн өмнөх шатанд цагдан хорьсоор байна. Шри-Ланка улсын засгийн газрын хар тамхины эсрэг хүчирхийллийн кампанит ажил нь ихээхэн шүүмжлэлийг дагуулдаг ч үргэлжилсээр байгаа бөгөөд голдуу нийгэм, эдийн засгийн гадуурхагдсан бүлгүүдийн олон арван мянган хүнийг дур зоргоор цагдан хорьж байна.

Эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, тайван хуран цуглах эрх чөлөө болон бусад хууль ёсны эрхээ эдэлж буй улс төрийн өрсөлдөгчид болон бусад хүмүүсийн эсрэг шүүхийн тогтолцоог урвуулан ашиглахгүй байх ёстой. Засгийн газрууд үндэслэлгүйгээр цагдан хоригдсон хүмүүсийг суллаж, нөхөн олговор олгохын зэрэгцээ эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдлыг хориглон, эрүүгийн ял хүлээлгэх ёстой.

ЯЛ ЗАВШИХ БОЛОН ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ

Хэд хэдэн улсад хүний эрхийн зөрчлийн хохирогчдын асуудлыг шүүхээр шийдвэрлэхэд тодорхой ахиц дэвшил гарсан ч, ял завших нь бүс нутагтаа хэвийн үзэгдэл хэвээр байгаа бөгөөд энэ нь хүний эрхийн зөрчлийг улам гааруулж байна.

Пакистан, Филиппин улсад хүчээр алга болох явдалд хариуцлага хүлээдэггүй жишиг олон жилийн турш тогтсон бөгөөд 2024 онд хүчээр алга болгосон хүмүүсийн

дотор хөдөлмөр эрхлэлт, газрын эрхийн төлөө тэмцэгчид, улс төрийн өрсөлдөгчид, сэтгүүлчид орж байна. Афганистанд шүүхийн хүртээмжгүй байдал нь ял завших соёлыг бий болгож, хүний эрхийн зөрчлүүд үргэлжилсээр байна. Хятадын засгийн газар Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Уйгур болон бусад лалын шашинт бүлэглэлийн гишүүдийн эсрэг үйлдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт харуцлага тооцоо ямар ч алхам хийсэнгүй. Энэтхэгийн засгийн газар Манипур муж дахь үндэстэн угсаатны эсрэг хүчирхийллийг таслан зогсоож чадаагүйн зэрэгцээ хүчирхийллийн үеэр хүний эрхийг зөрчсөн зэвсэгт бүлгүүдийн гишүүдийг шүүхийн өмнө авчирч чадаагүй юм. Индонезийн Папуа хотод салан тусгаарлагчдын зэвсэгт тэмцлийн хүрээнд энгийн номхон иргэдийг хууль бусаар хөнөөсөн хэрэг ямар ч ял шийтгэлгүй үргэлжилсээр байна.

Итгэл найдвар төрүүлсэн үйл явдлууд мөн өрнөв. Япон улсын Дээд шүүх хуучин “Хүний генетикийн чанарыг сайжруулах тухай” хуулийн хүрээнд албадан үргүй болгосон 16,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй болон архаг өвчтэй хүмүүст нөхөн төлбөр олгох шийдвэр гаргажээ. 1961-1987 онд олон мянган нярай хүүхдийг албадан үрчлүүлсэн хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгохыг Өмнөд Солонгос дахь Үнэний комисс тайландаа зөвлөсөн байна. Бангладеш улсын шинэ түр засгийн газар 2009-2024 оны хооронд хүчээр алга болгосон идэвхтнүүд, улс төрийн өрсөлдөгчид болон бусад хүний хэргийг мөрдөн шалгах комисс байгуулжээ.

Гэвч бусад улс орнуудад шударга ёсны төлөөх тэмцэл ээдрээтэй байна. Непал улсад зэвсэгт мөргөлдөөний үеийн харгислалын эсрэг шударга ёсыг сэргээх зорилготой шинээр батлагдсан хууль нь олон улсын хэм хэмжээнд бүрэн нийцээгүй бөгөөд зарим гэмт этгээдэд шийтгэл оногдуулахаас хамгаалсан. Шри Ланкад хохирогчидтой утга учиртай зөвшилцөөгүй, өмнө мөрдөн байцаах байгууллагуудын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг шалтгаанаар шударга үнэн болон эвлэрлийн комисс байгуулах тухай хуулийн төслийг иргэний нийгэм эсэргүүцсэн.

Засгийн газрууд олон улсын эрх зүйд заасан гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой хүчирхийллийг шуурхай, хараат бус, шударга, үр дүнтэй мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг шүүхэд шилжүүлж, хохирогчдод үр дүнтэй арга хэмжээ авах замаар ял завшихтай тэмцэх хүчин чармайлтаа улам нэмэгдүүлэх ёстой.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Мьянмар улсад зэвсэгт мөргөлдөөн улам хурцдаж, цэрэг арми болон зарим зэвсэгт сөрөг хүчнийг дайны гэмт хэрэг болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн хэмээн буруутгаж байна. 2021 оны төрийн эргэлтээс хойш энгийн иргэд болон иргэний дэд бүтэц рүү хамаагүй шууд дайрах цэргийн кампанит ажил эрчимжсэнээр амь насаа алдсан иргэдийн тоо 6000 гаруй болжээ. Олон улсын зүгээс түлшний ханган нийлүүлэлтийг зогсоох арга хэмжээ авсан хэдий ч цэргийнхэнд онгоцны түлш нийлүүлэгдсэн хэвээр байна. Зэвсэгт сөрөг хүчин болох Аракан Арми бүлэглэл Ракхайн мужид Рохинжа иргэдийн орон гэрийг галдан шатааж, иргэдийг хөнөөж, олон хүн эх нутгаасаа дүрвэхэд хүргэсэн хэмээн буруутгагдаж байна.

Афганистан улсад Хорасан мужийн Исламын зэвсэгт бүлэглэлүүд ихэвчлэн Ши-Хазара бүлгүүд рүү чиглэсэн халдлага үйлдсэний улмаас энгийн иргэд олноороо амь насаа алдсаар байна. Пакистаны цэргүүд хилийн дагуух Талибануудын байрлалыг агаараас бөмбөгдсөний дараа энгийн иргэд амиа алдсан тухай мэдээлжээ.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүхий л талууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэж, энгийн иргэд болон иргэний дэд бүтцийг ялгахгүйгээр шууд халдахыг зогсоох ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Афганистан дахь хүмүүнлэгийн хямрал улам хурцадлаа. НҮБ-ын мэдээлснээр хүн амын талаас илүү хувьд нь хүмүүнлэгийн тусламж шаардлагатай байгаа бөгөөд 85% нь өдөрт 1 доллараас доош орлоготой аж төрж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нийтээрээ асуудалтай байна. Ялангуяа охид, эмэгтэйчүүдийн зөвхөн 10% нь эрүүл мэндийн үндсэн үйлчилгээ авч байгааг Европын Холбооноос анхааруулжээ. Хойд Солонгост хүн амын 40 хувь нь хоол тэжээлийн дутагдалд орсон. Талибан болон Хойд Солонгосын засгийн газрын бодлого, үйл ажиллагаа нь хүмүүнлэгийн хүнд нөхцөл үүсэхэд хүргэж байна.

Хэд хэдэн улсын эрх баригчид орон байртай эрхийг зөрчин иргэдийг албадан нүүлгэн шилжүүлж, орон байрыг нь нураажээ. Энэтхэг улсад өнгөрсөн жилүүдэд лалын шашинтнуудыг нийтийн хүчирхийллийн төлөө “шийтгэх” засгийн газрын кампанит ажлын хүрээнд олон мянган байшинг сүйтгэсний дараа тус улсын Дээд шүүхээс эд хөрөнгийг албадан нураах нь хууль бус хэмээн шийдвэрлэсэн байна. Монгол улсад эрх баригчид нийслэл Улаанбаатар хотод 2000 орчим өрхийг амьдран суугаа газраас нь албадан нүүлгэжээ. Непалд албан бус сууринд амьдардаг, ихэвчлэн нийгэмд гадуурхагддаг Далит, Тару бүлгийн гэр бүлүүдийг албадан нүүлгэсэн. Өмнөх жилүүдэд Камбожийн Ангорын Дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газраас албадан нүүлгэн шилжүүлсэн олон мянган хүний зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх ямар ч арга хэмжээ аваагүй байна. Бусад олон хүн нүүлгэн шилжүүлэх аюул эрсдэлтэй нөхцөлд аж төрж байна.

Бүс нутгийн хэмжээнд хэдэн арван сая хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдсөөр байна. Талибууд охидыг бага сургуулиас бусад боловсрол эзэмшихийг хориглосон хэвээр байна. Мьянмар улсад зэвсэгт мөргөлдөөн болон цэргийнхэн боловсролын байгууламж руу санаатайгаар халдсаны улмаас сая сая хүүхэд сургууль завсардав. Хятадын засгийн газар сургуулиудыг үргэлжлүүлэн хаасаар байгаа нь Түвдийн хэл, соёлд заналхийлж байна. Лаос нийгмийн үйлчилгээ оруулж буй төсвийн хөрөнгө оруулалтаа бууруулж, ингэхдээ боловсролын салбарын төсвийг танаж байгаа нь НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын санаа зовнин хөндсөн асуудлын нэг байв.

Албадан хөдөлмөр болон хөдөлмөрийн нөхцөл тааруу гэсэн тайлан мэдээлэл үргэлжилсэн хэвээр байна. НҮБ-аас Хойд Солонгос дахь албадан хөдөлмөр эрхлэлтийг өргөн хүрээтэй, институцичлагдсан хэмээн тодорхойлсон бөгөөд хорих лагерьд албадан хөдөлмөрийг системтэйгээр ашиглаж байгаа нь хүн төрөлхтнийг боолчилсон гэмт хэрэг байж болзошгүй хэмээн мэдэгдэв. Малайяха Тамил цайны тариалангийн ажилтнууд Шри Ланкийн засгийн газрыг албадан хөдөлмөр эрхлэлт, өрийн боолчлол болон хүний эрхийн бусад зөрчлөөс хамгаалж чадаагүй гэж буруутгав.

Засгийн газрууд хүн бүрийг ялгаварлан гадуурхахгүйгээр хоол хүнс, эрүүл мэнд, орон сууц, боловсрол зэрэг эдийн засаг, нийгмийн эрхийг баталгаажуулж, албадан хөдөлмөр эрхлэлтийг эцэс болгох ёстой.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутагт охид, эмэгтэйчүүдийн эсрэг жендерийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл газар авсан хэвээр байна. Афганистан улсад охид, эмэгтэйчүүд хүмүүнлэгийн эсрэг гэмт хэргийн хохирогч болоод байгаа бөгөөд Талибанууд үндсэндээ тэдний амьдралын дийлэнх харилцаанд хязгаарлалтыг тавьж байна. Олон охид, эмэгтэйчүүдийг хувцаслалтын дүрмийг дагаж мөрдөөгүй гэх үндэслэлээр баривчилсан бөгөөд цагдан хоригдсон охид, эмэгтэйчүүд хүчингийн болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрүүдэд өртөж буй мэдээллүүд гарсан. Жендэрт суурилсан хүчирхийллийн түвшин эрс нэмэгдсэн бөгөөд үүний

улмаас өнгөрсөн жил 300 гаруй охид, эмэгтэйчүүд амь насаа алдсан хэмээн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагууд мэдээлжээ.

Бусад орны засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт, дарамт, хүчирхийллийн бусад хэлбэрийг арилгах зохих арга хэмжээ авч чадсангүй. Өмнөд Солонгост цахим орчинд хуурамч, зөвшөөрөлгүй зураг, видео олширч байгааг эмэгтэйчүүдийн бүлгүүд “үндэсний онц байдал” хэмээн нэрийдэж байна. Мальдив улсын засгийн газар эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн уламжлал, гэр бүлийн хүчирхийллийг тусгайлсан гэмт хэрэг хэмээн хуульчлах талаарх НҮБ-ын гэрээний байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлсэнгүй.

Энэтхэг улсад дадлагажигч эмчийг ажлын байранд нь хүчиндэж, хөнөөсөн хэрэг улс орон даяар эсэргүүцлийн жагсаал өрнөхөд хүргэв. Тус улсын кастад суурилсан ялгаварлан гадуурхалт нь Далит эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн болон бусад хүчирхийллийг улам бүр нэмэгдүүлсээр байна. Мадья Прадеш мужид нэгэн эмэгтэйг бэлгийн дарамтын эсрэг гомдол гаргасны дараа, түүнийг амьдаар нь шатаасан хэрэг гарчээ. Далит охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд ял шийтгэл хүлээлгэхгүй байх явдал Непал улсад ч өргөн тархсан байна.

Засгийн газрууд ялгаварлан гадуурхах үзлийн үндсийг арилгах, шударга ёсны хүртээмжийг хангах, хохирогчдыг хамгаалах, бусад дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг үйлдэгчдийн ял завших явдлыг таслан зогсоохын замаар охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах болон жендэрт суурилсан хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Тайланд улс ЛГБТИ хүмүүсийн гэрлэлтийн тэгш байдлыг хангасан Зүүн Өмнөд Азийн анхны улс болсон бол Солонгосын Дээд шүүх ижил хүйстэн хосууд гетеросексуал хосуудтай адил эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй хэмээн шийдвэрлэсэн. Хятад улсын шүүх ижил хүйстэн эмэгтэйд хүүхэдтэйгээ уулзах эрхийг олгожээ. Япон улсад ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хориглосон нь үндсэн хууль зөрчсөн болохыг хоёр тусдаа дээд шүүхийн шийдвэрээр тогтоосон. Непал улсын Дээд шүүхийн шийдвэрээр трансжендер эмэгтэй албан ёсны баримт бичиг дээр өөрийн хүйсийн баримжаагаа тусгуулж, хүлээн зөвшөөрүүлэх эрхийг хүлээн зөвшөөрчээ.

Гэвч ЛГБТИ хүмүүс хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртсөн хэвээр байгаа бөгөөд зарим орнуудад гэмт хэрэгт тооцож байна. Афганистанд ижил хүйстнүүдийн бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцож цаазын ял оноодог хэвээр байна. Хятад улсад ЛГБТИ хүний эрхийн идэвхтнүүд дур зоргоор цагдан хоригдох эрсдэлд байв. Трансжендэр хүмүүс хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлд өртсөн. Трансжендэр биеэ үнэлэгчийг хулгайлж, хүчиндсэний дараа амь насыг нь хөнөөсөн хэргийг Фижи улсын эрх баригчид үр дүнтэй мөрдөн шалгаж чадаагүйд хүний эрхийн байгууллагуудын ихээхэн шүүмжлэлтэй байна.

Засгийн газрууд ижил хүйстнүүдийн харилцааг гэмт хэрэгт тооцохгүй байх, ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц хууль тогтоомжийг батлах, жендерийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх зэргээр ЛГБТИ хүмүүсийн хамгаалалтыг бэхжүүлэх шаардлагатай байна. ЛГБТИ хүмүүсийг эсрэг хүч хэрэглэсэн эсвэл хүчирхийлсэн аливаа мэдээллийг үр дүнтэй шалгаж, буруутай этгээдийг шүүхийн өмнө авчрах ёстой.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Хэд хэдэн улсад уугуул иргэдийн эрхэд ухралт гарсны зэрэгцээ бүс нутгийн хэмжээнд уугуул хүмүүс, угсаатны үндэстний цөөнх алагчлал, ялгаварлан гадуурхалтад ихээр өртөж байна.

Тайваний албан ёсны баримт бичигт уугуул хүмүүсийн нэрийг Мандарин хэл дээрх хувилбараар бус уугуул нэрээр нь ашиглах эрхийг зөвшөөрсөн нь нэгэн зэрэг алхам байлаа. Харин үүний эсрэгээр Шинэ Зеландын засгийн газар Маоричуудын эрхийг хавчсан шинэ хуулиудыг баталж, бусад хэд хэдэн хуулийн төсөл санал болгосон нь улс даяар эсэргүүцлийн жагсаал өрнөхөд хүрээд байна. Индонез, Малайз зэрэг бусад орнуудад уугуул хүмүүсийн газарт тэдний чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэй зөвшөөрөлгүйгээр бүтээн байгуулалтын төслүүдийг үргэлжлүүлсэн. Монгол Улсад уул уурхайн үйл ажиллагаа малчдын амьдрал, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаад санаа зовниж байгаагаа НҮБ-ын уугуул хүмүүсийн эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч илэрхийлэв.

Австрали, Шинэ Зеланд улсуудад эрүүгийн шүүхэд татагдсан хүмүүсийн дийлэнхийг нутгийн уугуул иргэд эзэлж байна. Тэр дундаа австралид хоригдож байгаа хүмүүсийн дотор уугуул болон Торресийн Стрэйт Арлын хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байгаа бөгөөд Баруун Австралид гурван уугуул хүүхэд цагдан хоригдоход нас барсан тухай мэдээ гарсан. Вьетнам улсад Монтанардын уугуул иргэд ялгаварлан гадуурхалтад өртсөөр байгаа бөгөөд 2023 онд цагдаагийн пост руу халдсан хэргээр 100 гаруй хүнийг шударга бусаар шүүж, терроризмын хэргээр буруутган яллажээ.

Хятадын засгийн газар Хан үндэстний бус угсаатнуудыг дарангуйлсан хэвээр байгаа бөгөөд соёлын болон шашны зүтгэлтнүүдийг дур зоргоор цагдан хорьж байна. Энэтхэг улсад лалын шашинтнууд болон бусад шашны цөөнхийн эсрэг хэдэн зуун үзэн ядалтын гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд 2014 онд Далитчуудын гэрийг галдан шатаасан хэргээр 100 гаруй хүнийг яллажээ.

Эрх баригчид нутгийн уугуул иргэд, түүнчлэн угсаатан болон үндэстний цөөнхийн эрхийг баталгаажуулах бодит арга хэмжээ авах ёстой бөгөөд тэднийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, бодлогыг хүчингүй болгох, өөрчлөх, эрүүгийн шүүхийн тогтолцоон дахь бүтцийн ялгаварлан гадуурхалтыг арилгах бодлого, хөтөлбөрүүдийг нэн тэргүүнд авч үзэх, түүнчлэн уугуул иргэдэд нөлөөлөх аливаа бүтээн байгуулалт, төсөл, бусад шийдвэр гаргахдаа тэдний чөлөөт, урьдчилсан мэдээлэлтэй зөвшөөрөл авах мөн зөвлөдөх ёстой.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Австрали, Япон, Малайз, Тайланд зэрэг орнуудад дүрвэгсэд болон цагаачдыг тодорхой хугацаагүйгээр дур зоргоор цагдан хорихыг зөвшөөрсөн хэвээр байна. Малайз улсад хүүхдүүдийг цагдан хорьсон хэвээр байгаа нь санаа зовоож буй бөгөөд цагаачдыг саатуулах төвүүдийн нөхцөл байдал туйлын хангалтгүйн зэрэгцээ хүчирхийлэлд өртөж байгаа мэдээллүүд гарсан.. Тайланд улсад 10 гаруй жил хоригдож байгаа Уйгур үндэстний 40 гаруй орогнол хүсэгчдийг туйлын хүнд нөхцөлд цагдан хорьж байгаа нь эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсан үйлдэл хэмээн НҮБ үзжээ.

Зэвсэгт мөргөлдөөн, дарангуйллаас зугтаж буй дүрвэгсэд албадан буцаах эрсдэлтэй тулгарч байна. Бангладеш улсын хилийн албаныхан Мьянмарын Ракхайн мужид болж буй зэвсэгт мөргөлдөөнөөс зугтсан Рохинжачуудыг хууль бусаар буцаасан; Бангладеш дахь дүрвэгсдийн хуаранд Рохинжа үндэстнүүд туйлын хүнд

нөхцөл амьдарч байна. Тайланд улсын эрх баригчид хэд хэдэн Монтагнардын дүрвэгсдийг Вьетнамын засгийн газартай хамтран баривчилсан хэмээн буруутгагдаж байгаа бөгөөд тэдний дунд хүний эрх хамгаалагч байгаа ба түүнийг Вьетнам руу хүчээр буцаавал хүний эрхийн зөрчилд өртөж болзошгүй эрсдэл байна. Системт ялгаварлан гадуурхалт, дарангуйллаас зугтаж буй Афганчуудыг олон улсын хамгаалалтаар хангах уриалгыг Пакистаны эрх баригчид үл харгалзан албадан гаргах бодлого баримталж, олон зуун мянган дүрвэгсдийг Афганистан улс руу албадан буцаагаад байна.

Хэд хэдэн оронд цагаач ажилчид аюултай нөхцөлд ажиллаж, амьдарч байна. Бүс нутгийн хэмжээнд хүний наймаа мөн санаа зовнисон асуудал хэвээр байна. Өмнөд Солонгосын үйлдвэрт гал гарч 23 хүн амиа алдсаны ихэнх нь цагаач ажилчид байв. Тайван улсад Индонезийн иргэдийг загас агнуурын хөлөг онгоцон дээр жил гаруй цалин хөлсгүй, гадаад ертөнцтэй холбоогүй ажиллуулсан нь эрх бүхий байгууллагын шалгалтаар тогтоогджээ. Камбож улсад хүний наймаа, залилангийн төвүүдэд албадан хөдөлмөр эрхлэлт өргөн тархсан ба НҮБ-ын гэрээний байгууллагаас Лаос улсад бэлгийн мөлжлөг, хүний наймааны асуудлыг онцолсон юм.

Засгийн газрууд орогнол хүсэгчдийг зөвхөн цагаачлалын эрх зүй байдлаас нь хамааран цагдан хорихоо зогсоож, олон улсын хамгаалалтад орохыг зөвшөөрөх ёстой. Хууль бусаар албадан гаргахыг нэн даруй зогсоож, эрх нь зөрчигдөж болзошгүй газар руу буцаан шилжүүлэхгүй байх “non-refoulement” олон улсын зарчмыг хүндэтгэх шаардлагатай. Хүн худалдаалах, албадан хөдөлмөрөөс хамгаалах хамгаалалтыг бэхжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хууль эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Цаазаар авах ялаар шийтгэгдэж 45 гаруй жил хоригдсон 88 настай эрэгтэйд ял оногдуулах үндэслэл болсон нотлох баримт нь зохиомол болохыг хожим шүүхээс тогтоосны дараа түүнд оногдуулсан ялыг хүчингүй болгосноор Япон улсад цаазаар авах ялыг халах уриалга эрчимжлээ. Афганистан улсад олон нийтийн өмнө цаазаар авах ялыг гүйцэтгэх явдал үргэлжилсээр байгаа бөгөөд Талибанууд “садар самуун” хэрэгт буруутгагдсан эмэгтэйчүүдийг чулуугаар шидэж алах ялаар шийтгэж магадгүй гэсэн мэдээлэл байна.

Хятад, Сингапур зэрэг хэд хэдэн оронд хар тамхитай холбоотой хэргээр хүмүүсийг цаазаар авах ялаар шийтгэсэн хэвээр. Хятад, Хойд Солонгос, Вьетнам улсад цаазаар авах ялыг ямар хэмжээнд оноож буй нь тодорхойгүй байгаа ч өргөн хүрээнд хэрэглэж байгаа хэмээн таамаглаж байна. Хятад улсад шинэ хуулиар цаазаар авах явдлыг практикт хэрхэн хэрэглэж байгаа талаарх мэдээллийг задруулахгүй байх шаардлага тавьж, Тайван улсын тусгаар тогтнолыг дэмжигчдэд цаазаар авах ял оногдуулах шүүхийн шинэ удирдамж гарчээ.

Цаазаар авах ялыг халаагүй байгаа улс орнуудын засгийн газрууд уг ялыг цуцлах талаар яаралтай арга хэмжээ авч, энэ хугацаанд цаазаар авах ялын гүйцэтгэлээ зогсоох шаардлагатай.

ЕВРОП БОЛОН ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

ЗҮҮН ЕВРОП БОЛОН ТӨВ АЗИ

ОХУ-ын Украины эсрэг түрэмгийлэл үргэлжилсээр байгаа нь дэлхийн дахинд гарч буй хүний эрхийн ухралтаар тус бүс нутаг давамгайлахад хүргэв. Дайн, дарангуйлал нэмэгдсээр байгаа нь хүний эрхийн үүргээсээ татгалзах, үндэсний болон олон улсын байгууллагыг үл хайхрах улс орнуудын тоог ар араасаа нэмэгдэхэд хүргэлээ. Хүний эрхийн тэмцэгчдийг тал бүрээр хавчиж байна.

Орос улс олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг байнга зөрчиж, олон улсын эрх зүйд заасан гэмт хэрэг, тэр дундаа иргэний дэд бүтцэд шууд халдлага үйлдэж байгаа нь Украинд амь насаа алдагсдын тоог тасралтгүй нэмэгдүүлж, амьдралын үндсэн нөхцөлийг эрс доройтуулж, хүүхэд болон бусад эрсдэлт бүлгийн хүмүүсийн зовлон зүдүүрийг улам хүндрүүлж байна.

Эдгээр гэмт хэрэг болон Армени, Азербайжаны хоорондын мөргөлдөөний үеэр хүчирхийлэл үйлдэгчид ял шийтгэлгүй үлдсэний зэрэгцээ Зүүн Европ, Төв Азийн олон улс орны засгийн газрууд хүний эрхийн эсрэг үйлдсэн увайгүй халдлагынхаа төлөө хариуцлага хүлээх магадлал тун бага байв. Олон оронд иргэний нийгэм шууд халдлагад өртөн, хумигдаж, айдас дунд, нууцлагдмал орчинд ажиллаж байна. Хүний эрх хамгаалагчдыг хорих, эсхүл эх орноос нь хөөж байна. Тайван жагсагчид урьд өмнө байгаагүй хүчирхийллийг эс харгалзан өсөн нэмэгдэж буй хавчлагын эсрэг зоригтой сөрөн зогслоо. Гэвч энэ хүчин чармайлтаас үл хамааран хүний эрхийн байгууллагуудын үр нөлөө мэдэгдэхүйц буурсан.

Хэт даврагч, террористийн талаарх хууль тогтоомжийг урвуулан ашиглах, түүнчлэн «уламжлалт үнэт зүйлс» гэсэн үгээр жендэр, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг боомилж байна. Мониторинг, тэр дундаа олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа улам хязгаарлагдсан. Эх орноосоо цөлөгдсөн идэвхтнүүдийн эсрэг үндэстэн дамнанас хавчлага ихсэж байгаа нь хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм сул байгааг тодоор харууллаа.

Шашин шүтэх эрх чөлөө, итгэл үнэмшилтэй байх эрхэд ухралт гарлаа. Шүүхийн тогтолцоог өөрөөр сэтгэгчдийг дарангуйлахад зэвсэг болгон ашиглаж эрүүдэн шүүж, зүй бус харьцах явдал түгээмэл хэвээр байв. Жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн. Дүрвэгсэд болон цагаачдын эрх улам дордсоор байна

Чулуужсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээ өсөж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх агаарын бохирдлыг нэмэгдүүлээ.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Орос улс Украины иргэний дэд бүтцэд системтэйгээр халдаж, дайны гэмт хэрэг үйлдсээр байна. Энгийн иргэдийн хохирол 2023 оныхоос нэмэгдсэн. Орос улс хүн ам төвлөрсөн төвүүдийг пуужин, дроноор үргэлжлүүлэн онилсоор байгаа нь Украины энгийн иргэдийн амьдрах үндсэн нөхцөлийг эрс бууруулж, хүүхдүүд,

өндөр настнууд болон эрсдэлт бүлгийн бусад бүлгүүдэд ноцтой нөлөөлж байна. ОХУ Украины дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлын 70 хүртэлх хувийг сүйтгэж, эсхүл эзлэн авсан нь эрчим хүч байнга тасалдах шалтгаан болсон. Олон тооны Украины олзлогдогчдыг дайны үйл ажиллагаанд оролцсон хэргээр Орос болон Украины эзлэгдсэн бүс нутагт хууль бусаар шүүсэн.

Маргаантай байгаа Уулын Карабах бүс нутгийг тойрсон Армени болон Азербайжаны хооронд үүссэн мөргөлдөөнтэй холбоотойгоор урьд өмнө гарсан зөрчилд хэн ч шийтгэл хүлээсэнгүй. Европын Хүний эрхийн шүүх Гүрж дэх Өмнөд Осет, Абхазийн салан тусгаарласан нутаг дэвсгэрийн хилийн заагийг тогтоож, хяналт тавихдаа Орос улсыг хүний амьд явах эрх болон бусад эрхийг зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн.

Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг түгээмэл харьяаллын зарчмын хүрээнд шударгаар, хараат бусаар мөрдөн шалгах ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хэт даврагч, терроризмын эсрэг болоод ижил хүйстнүүдийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж ашиглан өөрөөр сэтгэгчдийн дуу хоолойг нухчин дарахын тулд “гадаадын агент” хэмээн цоллож, “уламжлалт үнэт зүйлс”-ийг алдагдуулсан, эх орноосоо урвасан, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хэмээн үзэх нь ихэссэн. Ингэхдээ хүний эрх хамгаалагчдаас эхлээд уран бүтээлч, сэтгүүлч, жүжгийн зохиолч, хуульч гээд хэнийг нь ч үлдээсэнгүй.

Беларусын “Хэт даврах үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн жагсаалт” 4700-аас давж, 2024 онд “хэт даврагч агуулгатай” хэмээн хориглосон онлайн, хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн материалын тоо бараг хоёр дахин нэмэгджээ. Гүржид өөрөөр сэтгэгчдийн эсрэг дарамт, хүчирхийлэл газар авч, олон идэвхтэн, жагсагчид харгис хэрцгий халдлагын хохирогч болж, зарим нь тодорхойгүй, эсхүл эрх баригчдын дэмжлэгтэй буюу тэдний өдөөн хатгасан халдлагад өртсөн.

Киргизд олон арван хараат бус сэтгүүлч, идэвхтэн, блогчид, нийгмийн сүлжээний коммент бичигчдийг шүүмжилсэн үйлдлийнх нь төлөө эрүүгийн хэрэгт ялав. Молдав улс эх орноосоо урвахтай тэмцэх хуулийн хамрах хүрээг энхийн цагт өргөжүүлэв. Тажикстан улс “Үндэсний соёлд харь” хувцас өмсөхийг хориглосон хууль баталсан. Узбекистаны Мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Салан тусгаарлах үзэл”, “Шашны хэт даврах үзэл”-ийг сурталчлах, төрийг үл хүндэтгэсэн мэдээлэл түгээхийг хориглосон.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах орчныг улам боогдуулж, гутаан доромжилж, аюул эрсдэлд оруулсан. Киргиз улс Оросын хэрэглэж байгаа загварт тулгуурлан “Гадаадын агент”-ын хууль тогтоомжийг баталсан. Гадаадаас санхүүжилт авч, “Улс төрийн үйл ажиллагаа” эрхэлж буй төрийн бус байгууллагуудыг “Гадаадын төлөөлөгч” хэмээн бүртгүүлэхийг үүрэг болгосноор олон байгууллагын үйл ажиллагаа хумигдаж, эсвэл төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулахаа болиход хүргэсэн. Дээр дурдсан улс төрийн үйл ажиллагаа гэх ойлголтыг хуулиар ойлгомжгүй тодорхойлсон. Үүний нэгэн адил Гүрж улс Гадаад нөлөөний ил тод байдлын тухай хуулийг баталж 20 хувиас дээш гадаадын санхүүжилттэй байгууллагуудыг гадаадын нөлөөний төлөөлөгч хэмээн зарлаж, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй шаардлагуудыг тогтоосон.

Азербайжан улсад бие даасан төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг бүртгэхээс татгалзах, тайлагналтад нүсэр шаардлага тавих зэрэг дур зоргоороо хязгаарлалт тавьсаар байна. Тажикистан улсад ТББ-уудыг хаасаар

байгаа бөгөөд хаагдсан байгууллагын тоо 700-д хүрчээ. ОХУ-д уугуул хүмүүсийн байгууллагыг оролцуулаад 55 байгууллагыг дур зоргоор “хэт даврагч” хэмээн зарлаж, “гадаадын агент” гэсэн тодотголтой хувь хүн, байгууллагын жагсаалтаа 169-оор нэмсэн.

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хэт хязгаарласан хууль тогтоомж, жагсагчдын эсрэг хууль бус хүч хэрэглэснээр тайван хуран цуглах орон зай улам хумигдсан. Энэ нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нухчин дарахын зэрэгцээ хүний эрхийн үйл ажиллагаанд оролцох, тэр дундаа дараагийн үеийн удирдагчдыг бүрдүүлж чадах хүмүүсийн оролцоог сулруулсан.

Гүрж улсын цагдаа нар хэдэн зуун жагсагчдыг зодож, гэмтээж, баривчлахаа зогсоосонгүй, харин ч идэвхтнүүдийн гэр, ажлын байранд нэгжлэг хийж, баривчилжээ.

Орос улсад сөрөг хүчний нэрт удирдагч Алексей Навальный хорих газарт гэнэт, сэжигтэй байдлаар нас барсны дараа олон нийтийн өмнө гашуудал, эмгэнэл илэрхийлсэн олон зуун хүнийг баривчлах, эсхүл торгох, цагдан хорих зэрэг захиргааны шийтгэл оногдуулсан. Армени улсад дөрөв, тавдугаар сард Ерөнхий сайд Никол Пашиняныг огцрохыг шаардсан томоохон хэмжээний эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдаа нар хэд хэдэн удаа жагсагчдын эсрэг хууль бус хүч хэрэглэсэн. Казахстанд жагсаал, цуглаантай холбоотой хууль зөрчихийг гэмт хэрэгт тооцон жагсагчдыг удаан хугацаагаар хорих эрхийг эрх баригчдад олгосон.

Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөөнд саад учруулж буй хууль тогтоомжийг хүчингүй болгож, ТББ-ын үйл ажиллагааг зогсоохын зэрэгцээ өөрөөр сэтгэгчдийг дарангуйлах, хүний эрхийн талаарх хэлэлцүүлгийг боомилох шалтаг ашиглахаа зогсоох ёстой.

ШАШИН ШҮТЭХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Зүүн Европ, Төв Азийн орнуудад шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөнд ухралт гарлаа. Украин улс ОХУ-д нөлөөллийн төвтэй холбоотой шашны байгууллагуудыг хориглох хуулийг баталсан. Түүнчлэн Орос улс дайны эсрэг үзэл бодлоо илэрхийлж байсан тус улсын Ортодокс санваартнуудын сахил санваарыг хураах, өөр бусад байдлаар буруутган, Еховагийн Гэрчүүдийг хорьсон хэвээр байв. Беларусь улсад төрийн бодлогод үл нийцэх шашны зүтгэлтнүүдийг дарамталж, баривчилжээ. Тажикстанд Памирийн цөөнхийн шашин шүтэх эрх, соёлоо уламжлан хадгалах эрх бүхэлдээ халдлагад өртсөөр байна.

Засгийн газрууд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг алагчлалгүйгээр бүрэн хамгаалах, хөхүүлэн дэмжих, баталгаажуулах эрх зүйн болон бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай.

ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал түгээмэл хэвээр бөгөөд түүнийг үйлдэгчдийн олонх нь шийтгэл хүлээсэнгүй.

НҮБ-ын бие даасан шинжээчид Орос улсын “Украины энгийн иргэд болон дайнд олзлогдогчдыг эрүүдэн шүүх төрийн зохицуулалттай бодлого”-ыг буруутгав. Амьд үлдэгсдийг хэрцгийгээр зодож, цахилгаанд цохиулж, бэлгийн хүчирхийлэл үзүүлж, нойргүйдэлд хүргэж, цаазална хэмээн тохуурхан айлгаж байгааг

хохилогчид мэдээлсэн. Азербайжан улсын цагдаа нарын үйлддэг өргөн хүрээг хамарсан эрүү шүүлт болон бусад зүй бус харьцааны талаарх удаан хугацааны асуудлыг тус улс шийдвэрлэхгүй байгааг Европын зөвлөл буруутгав. Беларусь улсад улс төрийн хилс хэргээр хорих газарт хоригдож байсан хүмүүсийн тав нь 2024 онд нас барсан бол бусад нь гадаад ертөнцөөс бүрэн тусгаарласан нөхцөлд удаан хугацаанд цагдан хоригдож байгааг хүчээр алга болгосонтой адилтгаж болохоор байна. Гүрж улсад 11, 12 дугаар сард болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдан хоригдсон 400 хүний дийлэнхтэй нь зүй бус харьцаны зэрэгцээ хүнд бэртлийн улмаас олон хүн эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд эмнэлгийн тусламж үзүүлэхээс татгалзсан олон тохиолдлууд гарсан. Тажикстан улсад шударга бусаар хоригдож буй Памирийн хүний эрхийн хуульч Манучехр Холикназаровын эрүүл мэнд нь ноцтойгоор доройтож, зохих эмчилгээ хийлгээгүй хүмүүсийн дунд байсан бөгөөд эрх баригчид түүнийг суллах талаар олон улсын уриалгыг үл тоомсорлов. Казахстан улсад 2022 оны 1 дүгээр сард болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр аюулгүй байдлын хүчнийхэн эрүү шүүлт тулгасан талаарх хэрэгт хариуцлага хүлээлгээгүй хэвээр байна.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдлыг эцэс болгохын тулд яаралтай арга хэмжээ авч, эрүүгийн гэмт хэрэгт буруутгасан хүмүүсийг шударгаар шүүх ёстой.

ШУДАРГА БУСААР ШҮҮХ

Киргизстан улсад Кемпир Абад гэх хэргийн 22 шүүгдэгчийг улс төрийн зорилго бүхий эрүүгийн хэрэгт цагаатгасан нь ховор тохиох эерэг үйл явдал болсон. Гэвч өөрөөр сэтгэгчдийг дарангуйлах зорилгоор шүүхийн тогтолцоог зэвсэг болгон ашиглах улс орнуудын тоо нэмэгдсэн байна. Тэдэнд холбогдох эрүүгийн хэргийг эзгүйд нь шийдвэрлэж ял оногдуулах нь өссөн.

Беларусь улс төрийн өрсөлдөгчид, хүний эрх хамгаалагчид, хуульчдыг онилон удаан хугацаагаар хорих ялаар шийтгэсэн: Сөрөг хүчний удирдагч Святлана Циханускаятай холбоотойгоор эх орноосоо хөөгдсөн 20 улс төрийн шинжээчид, сэтгүүлчдэд төрийн эсрэг гэмт хэрэг, “хэт даврагч үзэл”-ийн хэргээр 10-11 жил 6 сарын хорих ял оногдуулсан. ОХУ-д эх орноосоо урвасан, тагнуул хийсэн хэргээр шийтгэгдсэн хүмүүсийн тоо эрс нэмэгдсэн. Гүрж улсын эрх баригчид засгийн газрын эсрэг жагсаалыг нухчин дарахын тулд шүүхийн тогтолцоог зүй бусаар ашиглаж байгаа бөгөөд эрүүдэн шүүсэн талаарх нотлох баримтуудыг шүүх байнга үл тоомсорлосноор байна. Тажикстан улсад сөрөг хүчний бүлгийн гишүүдийг дур зоргоор хорьж байгаа бол хуульчид ажлаа хийснийхээ төлөө хатуу өшөө авалттай нүүр тулгарсан.

Эрх баригчид шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулж, шүүх тогтолцоог урвуулан ашиглахаас зайлсхийх ёстой.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Армен болон Казахстан улсад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн хамгаалалтыг сайжруулсан. Гэвч бусад улсад жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн. Украины эрх баригчдын мэдээлснээр 2023 онтой харьцуулахад гэр бүлийн хүчирхийллийн хэрэг 80%-иар өссөн бол Киргиз улсад энэ тоо өмнөх оныхоос 37%-иар өсжээ. Туркменистан улсын хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гэр бүлийн хүчирхийлэл гарсан тохиолдолд ч гэр бүл цуцлах хэрэгт эхнэр, нөхөр хоёрыг эвлэрүүлэх арга хэмжээг нэн тэргүүнд тавихыг шүүхэд үүрэг болгосон.

Засгийн газрууд жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэртэй нэн даруй тэмцэж, түүний үндсэн шалтгааныг арилгах ёстой.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

“Уламжлалт үнэт зүйлс”-ийг улам чухалчлах болсонтой холбоотойгоор ЛГБТИ хүмүүсийн эрх доройтож байв. Гүрж улс ижил хүйстнүүд, трансфобикийн эсрэг олон арга хэмжээ бүхий “Гэр бүлийн үнэ цэнэ ба насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тухай” хууль тогтоомжийг баталсан нь ОХУ-ын “Гей суртал ухуулгын” хуульд үндэслэжээ. Беларусь улс порнографын тодорхойлолтыг шинэчлэн “уламжлалт бус бэлгийн харьцаа ба/эсвэл бэлгийн зан үйл”-ийг хамруулахаар хуульчилсан. Казахстан улсад “ЛГБТИ суртал ухуулга”-ыг гэмт хэрэгт тооцох тухай хууль гаргах хүсэлт гаргасан нь ихээхэн шуугиан дагуулж, хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулав.

Туркменистан, Узбекистан улсад эрэгтэйчүүдийн харилцан тохиролцсон бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон хэвээр байв.

Засгийн газар ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, бодлого, практикийг хүчингүй болгох, тэр дундаа ижил хүйстнүүдийн зөвшилцсөн бэлгийн харилцааг гэмт хэрэг гэж үзэхгүй байх ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Хүүхдүүд хүний хөгжлийн зохих нөхцөлөөс улам бүр хоцорсоор байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээлснээр Тажикстаны хүүхдүүдийн 34 хувь нь нэн ядуу нөхцөлд амьдарч, 78 хувь нь хүнсний ядууралд нэрвэгджээ. Киргизийн хүн амын тал хувь нь хоол тэжээлийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй нөхцөлд аж төрж байгаа бол хүүхдүүд харьцангуй ихээр өртөж байна.

ОХУ болон тус улсад эзлэгдсэн Украйны нутаг дэвсгэрт хүүхдийн чанартай боловсрол эзэмших эрх зөрчигдөж, сургуулийн сургалтын хөтөлбөрт Оросын Украйны эсрэг дайныг алдаршуулсан хичээлийг оруулсан. Мөн ОХУ-д хууль ёсоор оршин байгаа цагаачдын хүүхдүүдийг орос хэлний шалгалтад тэнцээгүй тохиолдолд сургуульд элсүүлэхгүй байхаар хуульчилсан.

Засгийн газрууд хүн бүрийн амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрх, чанартай боловсрол эзэмших эрхийг хангах ёстой.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Дүрвэгсэд болон цагаачдын эрх улам бүр доройтсон. Уулын Карабахаас Арменуу дүрвэсэн 100,000 гаруй армян үндэстэн аюулгүй, нэр төртэйгөөр эргэн ирэх найдваргүй хэвээр үлдэв. Казахстан улсад Узбекистаны автономит Бүгд Найрамдах Каракалпакстан улсын идэвхтнүүд хүчээр нутаг буцаагдах, эрүүдэн шүүгдэх, урт хугацаагаар хоригдох эрсдэлтэй нүүр тулгарсан. Беларусын эрх баригчид дүрвэгсэд болон цагаачдыг тус улсын ЕХ-ны хиллэх хэсгээр нэвтрүүлэхийг хориглосон хэвээр байна. Цагаачдын эсрэг үг хэллэг хийж буй Оросын эрх баригчид болон Оросын бүс нутгууд цагаачдыг тодорхой мэргэжлээр ажиллахыг хориглосон хууль баталсан.

Засгийн газрууд хавчлага, хүний эрхийн зөрчлөөс зугтаж буй бүх хүмүүст аюулгүй байдал, олон улсын хамгаалалтад хамрагдахыг баталгаажуулахын зэрэгцээ хүний эрхийг ноцтой зөрчих бодит эрсдэлд хэн ч эргэж орохгүй байх баталгааг хангах шаардлагатай.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Азербайжан улс COP29-ийг зохион байгуулсан бөгөөд бүс нутгийн болон дэлхийн уур амьсгалын шударга ёсонд ахиц гаргасангүй. Тус улсын эрх баригчид Азербайжаны хүний эрх хамгаалагчид болон идэвхтнүүдийг дээд хэмжээний

уулзалтад оролцуулаагүйн зэрэгцээ арга хэмжээний өмнө болон дараа нь тэднийг мөрдөн хавчиж, өөрийгөө цензурдэх, эрчимтэй мөрдөн тандах орчныг бий болгосон. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл өссөөр байгаа боловч ихэнх улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх, чулуужсан түлшний хамаарлыг бууруулах үүрэг амлалтаа биелүүлсэнгүй.

Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр байгаа бөгөөд чулуужсан түлшийг үргэлжлүүлэн шатааснаар улам бүр дордов. Узбекистаны нийслэл Ташкент хотын агаарын бохирдлын улмаас жил бүр 3000 орчим хүн цаг бусаар нас барж байгааг Дэлхийн банкны судалгаагаар тогтоожээ.

Армен, Азербайжан, Гүржийн эрх баригчид байгалийн баялгийн олборлолтын улмаас учирч буй хор хөнөөлийг эсэргүүцэгчдийн дуу хоолойг боомилсон.

Зүүн Европ болон Төв Азийн хүлэмжийн хийн өндөр ялгаруулалт бүхий улс орнууд уур амьсгалыг бууруулах, тэр дундаа чулуужсан түлшний үйлдвэрлэл, татаасыг нэмэгдүүлэхээ зогсоох замаар манлайлах ёстой.

Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын эрс тэс нөхцөл байдлын эрсдэл, нөлөөллөөс хувь хүн, олон нийтийг хамгаалах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх ёстой.

БАРУУН, ТӨВ, ЗҮҮН ӨМНӨД ЕВРОП

Арьс үндэс, шашин шүтлэг, жендэр, бэлгийн харьцаагаар ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, дарамтлах зэрэг нь хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах бүх салбарт тархсан сэдэв болов. Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн бүртгэл нэмэгдсэн.

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөөг нухчин дарахын тулд терроризмын эсрэг хэт өргөн хүрээтэй, тодорхой бус хуулиудыг урвуугаар ашигласан. Цагдаа нар тайван жагсагчдын эсрэг шаардлагагүй буюу хэт их хүч хэрэглэсэн бөгөөд иргэний үл захирагдахуйн үйлдлийн төлөө зарим хүний эрх чөлөөтэй байх эрхийг хассан. Ноцтой нөлөө үзүүлэхийн тулд тандалтын технологийг өргөнөөр ашигласан.

Палестинчуудтай эв нэгдэлтэй байх эсвэл Газын зурвас дахь Палестинчуудын эсрэг Израилын төрлөөр устгах гэмт хэргийг шүүмжилсэн үйлдлийг таслан зогсоох, шийтгэх зорилгоор дайсагнасан, дарангуйлагч хуулиудыг ашигласан. Энэ асуудлаар Европын улс орнуудын засгийн газрууд олон улсын эрх зүйг дагаж мөрддөг эсэх нь тодорхой болсон бөгөөд зарим албан тушаалтнууд Израил улсад хариуцлага хүлээлгэхээс хамгаалах арга хэмжээ авсан. Олон улсын шүүх болон НҮБ-ын шинжээчид Израил руу зэвсэг нийлүүлэлтээ зогсоохыг улс орнуудаас шаардсан хэдий ч зарим нь зэвсэг, эд ангиудыг экспортолсон хэвээр байна.

Хилийн хяналт шалгалтыг дүрвэгсэд, цагаачдын эрхээс дээгүүр тавьсан. Ялангуяа цагаачид болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүдэн шүүж зүй бусаар харьцаж байгаа нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Хүйсээ солих үйлчилгээ авахад бэрхшээл тулгарсан. Жендэрт суурилсан хүчирхийлэл өргөн тархсан. Орон сууц, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муудсан. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, ялангуяа өмнөд Европын улс орнуудыг ихээхэн хэмжээний сүйрэлд хүргэв.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Ялгаварлан гадуурхах нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Эмэгтэйчүүд, хар арьстнууд, араб, цыган болон бусад арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хүмүүс, бүлгүүд, бага орлоготой хүмүүс шууд ялгаварлан гадуурхалттай нүүр тулгарч байгаа нь тэдний нийгмийн хамгаалал, улс төрийн төлөөлөл, хөдөлмөр эрхлэлт, боловсрол эзэмшихэд нь нөлөөлсөн. Герман, Их Британид өрнөсөн өдөөн хатгалгын дараа цагаачдын эсрэг болон исламофоби үзэн ядалтын гэмт хэрэг нэмэгдсэн. Ялангуяа, Францад антисемит, исламофоби, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэлтэй холбоотой гэмт хэрэг ихэссэн. Португал улс үзэн ядсан гэмт хэргийн ихэнх мөрдөн байцаалтыг хэрэгсэхгүй болгосон.

Норвеги, Швейцарь улс арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэлд үндэслэн гэмт хэргийг шийдвэрлэсэн. Дани, Швед, Нидерландад халамжийн автоматжуулсан систем нь эмэгтэйчүүд, арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хүмүүс, бага орлоготой хүмүүсийг ялгаварлахад хүргэсэн. Франц улс 2024 оны Парисын олимп, паралимпийн наадмын үеэр спортын хижабыг ялгаварлан гадуурхсан хориг тавьсан.

Грек, Чех улсад ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуульчилсан бол Их Британид бэлгийн баримжааг өөрчлөхийг практикт хориглох эзэх асуудал шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байна. Гэвч ЛГБТИ хүмүүс бэрхшээлтэй тулгарсаар байна. Серби, Болгарт жендэрийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх нь хүндрэлтэй хэвээр байсан бол Хойд Македонд зогсонги байдалд орсон. Польш, Словак улсад хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах явдал улам газар авсан бол Польш улсад үзэн ядалтыг хуулиар гэмт хэрэгт тооцоогүй хэвээр байна. Турк улсад ЛГБТИ хүмүүсийн жагсаалыг хууль бусаар хориглосоор байна.

Зарим улс оронд цыгануудыг нэгтгэх орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үл харгалзан цыгануудыг ялгаварлан гадуурхах, тусгаарлах, нийгмээс алагчлах явдал гарсаар байв. Итали улс цыгануудын орон байртай холбоотой Европын Нийгмийн Хартиг зөрчсөн. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо Ирланд, Сербийн цыгануудад хандаж буй бүтцийн шинжтэй арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг онцлон тэмдэглэв. Словак улс цыган хүүхдүүдийг ялгаварлан тусгаарлаж байгаа нь Европын комисст гомдол гаргахад хүргэсэн бөгөөд Хойд Македон, Болгар, Босни Герцеговина зэрэг улсад ялгаварлан тусгаарласан хэвээр байна. Хорват дахь цыган, Украйнаас дүрвэсэн цыганууд Румын улсад нэн шаардлагатай үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байв.

Засгийн газрууд еврей, мусульман, хар арьстнууд, цыган, ЛГБТИ хүмүүс болон цагаачдыг ялгаварлан гадуурхах асуудлыг бодитой шийдвэрлэх ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн олон улсад Палестинчуудтай эв нэгдэлтэй холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх, Газын зурвас дахь Палестинчуудын эсрэг Израилын төрлөөр устгах гэмт хэргийг шүүмжилсэн дуу хоолойгоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ авсан. Герман улс “Голоос далай хүртэл” гэсэн уриа лоозонг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулсан. Их Британий засгийн газар Палестинтай холбоотой үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан бол Францад олон хүнийг “терроризмыг зөвтгөсөн” хэргээр шалгажээ. Испани улс Палестинтай эв нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн идэвхтнүүдийг “терроризмыг алдаршуулсан” хэрэгт холбогдуулан шалгасан.

Испани улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомжийг шинэчлэх Ардчиллын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан бол Болгар, Серби улс олон нийтийн оролцооны эсрэг стратегийн шүүхийн маргаан (SLAPPs) явуулсан.

Унгарын шинэ эрх баригчид иргэний нийгмийг онилсон бол Турк улсад засгийн газрыг тайван замаар эсэргүүцсэн хүмүүсийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсээр байна.

Улс орнууд тайван жагсагчдыг улам ихээр гутаан доромжлох, эрүүгийн ял оногдуулах, шударга бус болон шийтгэлийн хязгаарлалт тавих, өөрөөр сэтгэгчдийг нухчихын тулд урьд өмнө байгаагүй хэмжээнд дарангуйлах арга хэрэгсэл хэрэглэх болсноор тайван жагсаал цуглаан хийх эрх ноцтой халдлагад өртөв. Израил улс Палестины ард түмнийг төрлөөр устгаж байгааг эсэргүүцсэн хүмүүс болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар жагсагчдыг онцгойлон бай болгосоор байна.

Зарим эерэг өөрчлөлт гарсан. Их Британид жагсаал цуглааныг хязгаарлахын тулд цагдаагийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн зохицуулалтыг хууль бус болохыг тогтоосон бол Итали улсын шүүх гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан найман идэвхтний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах зорилгыг хүлээн зөвшөөрч цагаатгасан. Гэвч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой болон Палестиныг дэмжсэн жагсаал цуглаан хийхийг хориглох хүчин чармайлт үргэлжилсээр байна. Францад ийм эсэргүүцлийн жагсаалд хэт хязгаарлалт тогтоосон бол Финланд, Герман, Итали улсад жагсаалд оролцогчдын эсрэг шаардлагагүй эсвэл хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн хэмээн мэдээлсэн. Турк улс эсэргүүцлийн жагсаалыг бүхэлд нь хориглов. Нидерланд улсад тайван жагсагчдын эсрэг дрон болон царай таних технологийг ашигласан. Серби, Грек, Турк улсад жагсаалын үеэр цагдаа нар хүч хэтрүүлэн хэрэглэж, дур зоргоор баривчилжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван хуран цуглах эрх чөлөөг хүн бүр хэрэгжүүлэх орон зайг аливаа шалтаг, төрийн халдлагаас хамгаалах ёстой.

ХАРИУЦЛАГАГҮЙ ЗЭВСЭГ НИЙЛҮҮЛЭЛТ

Чех, Франц, Герман зэрэг улс Израил, Саудын Араб, АНЭУ-д зэвсгийн экспортоо үргэлжлүүлсээр байгаагаас үүдэн Европын хэд хэдэн улс хариуцлагагүй зэвсгийн солилцоонд оролцсон. Гэхдээ иргэний нийгмийн байгууллагууд Дани, Монтенегро дахь зэвсгийн нийлүүлэлтийг эсэргүүцэж гомдол гаргасан; Нидерланд хууль зүйн асуудлын улмаас F-35 сөнөөгч онгоцны эд ангиудыг Израил руу экспортлохыг зогсоосон; Испани, Бельги улс НҮБ-ын шинжээчид болон Олон улсын шүүхээс Израил руу зэвсгийн экспортоо зогсоох талаарх шаардлагыг биелүүлэв.

Засгийн газрууд хүний эрхийг ноцтой зөрчих, түүнийг дэмжихэд ашиглах эрсдэл өндөртэй улс орнуудад зэвсэг нийлүүлэхийг зогсоох ёстой.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС БОЛОН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ

Европын бүс нутаг колоничлолын өнгөрсөн түүхтэйгээ үргэлжлүүлэн тэмцэж, төрлөөр устгах гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн нөхөн төлбөр, шударга ёсыг баталгаажуулсаар байв. Хэд хэдэн улс ийм төрлийн гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын зөрүүг багасгах зорилго бүхий 2023 оны Любляна-Гаагийн конвенцод гарын үсэг зурсан. Бельги улсын шүүх Конго дахь колоничлолын үед хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн хариуцлагыг хүлээн зөвшөөрч, хохирлыг барагдуулах шийдвэр гаргасан.

Гэвч Босни Герцеговинийн улстөрчид төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэнээ үгүйсгэж, дайны гэмт хэрэгтнүүдийг алдаршуулсан хэвээр байна. Серби улс олон улсын эрх зүйн бүх төрлийн гэмт хэрэгт хариуцлага тооцох талаар бодитой хүчин чармайлт гаргаагүй бөгөөд үүний оронд Сребреницагийн хэлмэгдүүлэлтийн талаарх

НҮБ-ын тогтоолыг сулруулахад анхаарлаа хандуулсан. Хорват улсад дайны үеийн бэлгийн хүчирхийллийн хохирогчдын ихэнх нь тусгай статусын тэтгэмж авахаар бүртгүүлээгүй хэвээр байна. Их Британи улс Умард Ирландын уламжлалын тухай хуультай холбоотой хууль эрх зүйн сорилттой тулгарсан бөгөөд шүүхээс дээрх хуулийг Европын хүний эрхийн конвенцыг зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн.

Европын зарим улсын албаны хүмүүс Израилын Ерөнхий сайд Биньямин Нетаньяху болон Израилын Батлан хамгаалахын сайд асан Йоав Галлант нарын эсрэг гаргасан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн баривчлах шийдвэрийг хэрэгжүүлэхгүй гэдгээ ил тод зарлаж, зөвлөж байв.

Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэргийн талаарх бүх хэргийг бүх нийтээр харьяаллын зарчмаар дамжуулан шударга, хараат бусаар мөрдөн шалгах ёстой.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Европын орнууд болон ЕХ нь дүрвэгсэд, цагаачдын амь насыг хамгаалах үүргийг хилийн хяналтаас нэн тэргүүнд тавих бодлого, практикийг нэвтрүүлж чадаагүйн зэрэгцээ хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээлгэх найдвартай алхмуудыг авч хэрэгжүүлэх, шилжилт хөдөлгөөний менежментийн чиглэлээр гурвадгагч орноос хараат байдлыг бууруулах, аюулгүй, хууль ёсны арга замыг өргөжүүлэх зэрэг арга хэмжээ авч чадсангүй. Итали улс Албани улсын далайд аврагдсан орогнол хүсэгчдийг саатуулж, тэдний гомдлыг тус улсаас гадуур шалгахыг оролдсон. Тунис, Египет улсад хүний эрхийн зөрчил гарсаар байгааг үл харгалзан ЕХ тэдгээр улстай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсэн хэвээр байна. Хил дээр хүний эрхийн хүчирхийлэл үйлдэгдсэн хэвээр байгааг, түүнчлэн түрвэгсдийг Грекээс Турк руу, Кипрээс Ливан руу, Туркээс Сири, Афганистан, Эритрей рүү хууль бусаар буцааж байгаа талаарх мэдээлэл үргэлжилсээр байна.

ТББ болон хүний эрх хамгаалагчид гэмт хэргийн хадлагын бай болсоор байна. Грект хүний эрх хамгаалагчдыг дүрвэгсэд болон цагаачдад тусалсан хэрэгт ялласан хэвээр байна. НҮБ-ын гурван шинжээч Итали улс далайд аврах ажиллагаа явуулж байгаа хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг хязгаарлаж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.

Дүрвэгсэд болон цагаачид хүлээн авагч улсад хүний эрхийн дарангуйлалд өртсөөр байна. Унгар дахь Украины дүрвэгсэд орон сууц олгох талаарх төрийн дэмжлэгээ алдсан бол Ирланд, Бельги олон мянган орогнол хүсэгчид байргүй болсон.

Засгийн газрууд мөрдлөг хавчлага, хүний эрхийн зөрчлөөс зугтаж байгаа бүх хүнд аюулгүй байдал, олон улсын хамгаалалтад хамрагдах, хүний эрхийг ноцтой зөрчих бодит эрсдэлд хэн ч эргэж орохгүй байх баталгааг хангах ёстой.

ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Цагаачид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Зарим эерэг өөрчлөлт гарсан. Бельги улс холбооны урьдчилан сэргийлэх механизмыг бий болгосон бол Унгар улс хорих ангид ирэгч болон хоригдлуудыг биечлэн харилцахыг хориглосон хоригийг цуцалсан. Румын улс зүй бус харьцахтай тэмцэх таван жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Гэвч Албани, Итали улсын хорих газрын ачаалал хэтэрч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй байсан бөгөөд Хойд Македон, Болгарт эрүүдэн шүүсэн гэх мэдээлэл гарсан.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааг эцэс болгохын тулд яаралтай арга хэмжээ авч, гэмт хэрэгтнүүдийг шүүхэд шилжүүлэх ёстой.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бэлгийн хүчирхийлэлд ял шийтгэл завших асуудлыг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн улс хууль тогтоомждоо өөрчлөлт оруулсан. Польш, Чех, Нидерланд улс хүчингийн гэмт хэргийн тодорхойлолтод зөвшөөрөлд үндэслэсэн гэсэн утгыг оруулсан бол Хорват улс эмэгтэй хүний амь насыг хөнөөх үйлдлийг тусдаа эрүүгийн гэмт хэрэг болгон хуульчилжээ.

Гэвч жендэрт суурилсан хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байна. Румын улсад гэр бүлийн хүчирхийллийн хэрэг өмнөх жилүүдтэй харьцуулахад өссөн байна. Болгар, Хорват, Герман, Грек, Итали, Монтенегро, Португал, Испани, Турк зэрэг улсад голдуу хамтрагч, эсхүл хуучин хамтрагчдынхаа гарт амь насаа алдсан эмэгтэйчүүдийн тоо анхаарах өндөр түвшинд хүрсэн. Цагаач эмэгтэйчүүд, биеэ үнэлэгчид болон транс эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийн талаар гомдол гаргахад тогтолцооны саад бэрхшээлтэй тулгардаг. Франц улсад эдгээр саад тогторууд нь гомдлыг бүртгүүлэх эрхийг үгүйсгэх, албадан гаргахаар заналхийлэх зэргээр илэрдэг.

Засгийн газрууд жендэрт суурилсан хүчирхийлэлд ял завших явдлыг эцэс болгох ёстой.

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Зарим улс үр хөндөлтөд тулгарах саад бэрхшээлийг арилгах эерэг алхам хийсэн. Франц улс Үндсэн хуульдаа үр хөндөлтийг баталгаатай эдлэх эрх чөлөө хэмээн тодорхой тусгасан дэлхийн анхны улс болсон бөгөөд хэд хэдэн улс жирэмсэн хүмүүсийг үр хөндөлтийн эмнэлгүүдийн гаднах дарамтаас хамгаалах арга хэмжээг дэмжсэн.

Гэвч олон тооны улсад үр хөндөлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцож ял шийтгэж байгаа нь үр хөндөлт хийлгэхэд саад тогтортой хэвээр байна. Андорра улсад үр хөндөлтийг бүрэн хориглосон бол Польш улсад үр хөндөлтийг хатуу хязгаарласан хэвээр байна. Мальтад жирэмсэн хүний амь насанд эрсдэлтэй байх нь үр хөндөлтийг зөвшөөрөх цорын ганц хууль ёсны онцгой тохиолдол хэвээр байв. Англи, Уэльст хуулиас гадуур үр хөндөлт хийлгэсэн хэмээн буруутгагдаж буй эмэгтэйчүүдийг яллах ажиллагаа нэмэгдсэн.

Хорват, Итали, Португал зэрэг улс үзэл санаа, шашин шүтлэгийн үндэслэлээр үр хөндөлтийн тусламж үзүүлэхээс татгалзсан асуудал анхаарал татсан хэвээр байна. Ялангуяа Хорват, Словени зэрэг улсын хөдөө орон нутаг, эдийн засгийн алслагдсан бүс нутагт үр хөндөлт хийлгэх нь хүртээмжгүй байв.

Засгийн газрууд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц үйлчилгээ, тэр дундаа аюулгүй үр хөндөлтийн үйлчилгээ авах эрхийг баталгаажуулах ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Иргэд нийгмийн даатгалд хамрагдахад саад бэрхшээлтэй тулгарсан. Австри улсад эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гутаан доромжлол, хүнд суртал, хязгаарлалт бүхий хуулийн зохицуулалтай нүүр тулгарсан. Финланд улсад нийгмийн даатгалд ихээхэн таналт хийсэн нь бага орлоготой хүмүүсийн амьжиргааны зохих түвшинд аж төрөх эрхэд аюул учрууллаа. Их Британид нийгмийн даатгалын суурь тэтгэмж нь наад захын хэрэглээний зардлаас бага байв.

Эрүүл мэндийн дэд бүтцэд төсвийн хөрөнгө оруулалт хангалтгүйн улмаас Итали, Испани улсад эрүүл мэндээ хамгаалуулах эрх улам доройтож байна. Грек улсын эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүд үндэсний эрүүл мэндийн тогтолцоонд нүүрлэсэн мэдэгдэхүйц цоорхойг мэдээлсээр байна.

Их Британи улс даяар 4.3 сая хүүхэд ядуу амьдарч байгаа бөгөөд үр дагавар нь хар арьст болон үндэстний цөөнх хүүхдүүдэд илүүтэй нөлөөлж байна. Итали улсын хүн амын 10% нь нэн ядуу амьдарч байна.

Орон сууцны хүртээмж томоохон сорилт хэвээр байна. Польш улсад хямд үнэтэй орон сууцны хомсдол нь амьжиргааны хэвийн бус нөхцөл байдалд хүргэсэн. Андорра улсад иргэдийг өвлийн улиралд нүүлгэн шилжүүлэхээс хамгаалж чадаагүй бол Ирланд улсад орон гэргүй хүмүүсийн тоо түүхэнд байгаагүй дээд хэмжээнд хүрч нэмэгдсэн.

Засгийн газрууд хүн бүрийн эдийн засаг, нийгмийн эрхийг ялгаварлан гадуурхалтаас ангид байдлаар баталгаажуулах, тэр дундаа зохих нөөцийг хуваарилах, бүх нийтийн, иж бүрэн нийгмийн хамгааллыг хангах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Хүний үйл ажиллагаанаас үүдсэн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бүс нутгийн хэд хэдэн улс үер, ой хээрийн түймэр, хэт халалт зэрэг гамшигтай тулгарав. Испани улсад аравдугаар сард аадар бороо орж үер буусны улмаас 224 хүн амиа алдсан. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой агаарын халалт түүхэнд байгаагүй дээд хэмжээнд хүрч Грек, Португалид хүний амь нас эрсдэв.

Словяни улс ялгаруулалтын хэмжээг чангатгасан, Хорват улс 2030 он гэхэд 75% сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэхээр төлөвлөсөн, Унгар улсад сэргээгдэх эрчим хүчний өсөлт гарсан, Монтенегро улс байгаль орчны асуудлаас үүдэн уул уурхайн зөвшөөрлийг цуцалсан зэрэг бага боловч эерэг үр дүн гарсан. Гэвч олон орон уур амьсгалын бодлогын хэрэгжилтийг хангаж чадсангүй. Европын Хүний эрхийн шүүхээс Швейцарь улсын уур амьсгалын бодлого хангалтгүй байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн ноцтой сөрөг нөлөөллөөс үр дүнтэй хамгаалах эрхийг зөрчсөн хэмээн түүхэн чухал шийдвэр гаргав. ХБНГУ-ын уур амьсгалын төлөвлөгөөг хууль эрх зүйн хувьд хангалтгүй гэж үзсэн бол Туркийн уур амьсгалын бодлогыг маш хангалтгүй гэж үнэлэв. Нидерланд улс уур амьсгалын бодлогоо сулруулж, Норвеги улс чулуужсан түлшний шинэ хайгуулаа үргэлжлүүлж, Грек улс байгалийн хийн дэд бүтцийг өргөтгөж, Бельги улс чулуужсан түлшний татаасанд 15.5 тэрбум евро зарцуулсан. Европын орнууд хамтран уур амьсгалын санхүүжилтийн хэмжээг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх тухай COP29-ийн хэлэлцээрт хаалт хийв.

Засгийн газрууд шударга шилжилт хийх замаар чулуужсан түлшний хэрэглээ, үйлдвэрлэл, чулуужсан түлшний бүх санхүүжилтийг зогсоох ёстой. Тэд мөн уур амьсгалын санхүүжилт болон бага орлоготой орнуудад учирсан гарз, хохирлын санхүүжилтийг яаралтай нэмэгдүүлэх ёстой.

ХУВИЙН НУУЦТАЙ БАЙХ ЭРХ

Монтенегро улс хүний царай таних программ хангамжийн хэрэглээг түдгэлзүүлсэн, Франц улсын шүүх хиймэл оюун ухаанаар ажилладаг аудио хяналтын системийг илт хууль бус гэж үзсэн хэдий ч тагнах программ, нүүр царай таних технологийг хууль бусаар ашиглаж байгаа нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Сербийн эрх баригчдын зүгээс идэвхтнүүд болон бие даасан сэтгүүлчдийн эсрэг инвазив цахим шүүх шинжилгээний аргыг ашигласан. Герман улсад цагдаа нар хууль зүйн хангалттай үндэслэлгүйгээр царай таних технологийг ашигласан. Европын Хүний Эрхийн шүүхээс Польш улсыг Pegasus тагнуулын программыг ашигласантай холбоотой “нууц тандалт”-аар дамжуулан хувийн нууцын эрхийг зөрчсөн хэмээн буруутгасан бол Унгар улсын шүүх тус улсын мэдээлэл хамгаалах хяналтын байгууллага нь Pegasus-ийн онилсон дөрвөн хүний хэргийг үр дүнтэй шалгаж чадаагүй болохыг тогтоосон.

Засгийн газрууд тандалтын нийгэм байгуулж, шилжихээ зогсоох ёстой.

ОЙРХ ДОРНОД БОЛОН ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2024 онд Ойрх Дорнод болон Хойд Африкийн бүс нутгийг хямрал, мөргөлдөөн, үймээн самуун нөмөрлөө. Израилын Газын зурвас дахь ажиллагааны улмаас нас барагчдын тоо ноцтой хэмжээнд хүрч, төрлөөр устгах гэмт хэрэг боллоо. Түүнчлэн Израил улс Ливан дахь “Хезболла”-тай хийх зэвсэгт мөргөлдөөнөө улам хурцатгав. Өнгөрсөн арванхоёрдугаар сард Сирид Ерөнхийлөгч Башар аль-Асадыг гэнэт огцруулсан нь олон улс оронд өрнөж байгаа дарангуйллын дэглэмийг улам тэлж, тус бүс нутаг дахь хүний эрхийн зөрчилд хэдэн арван жилээр ял шийтгэл хүлээлгээгүйн үр дагаврыг илчлэн харууллаа.

Эзлэгдсэн бүс нутаг дахь Израилын цэргийн хүчний тасралтгүй довтолгоо нь Газын зурваст 18 жил хийж байгаа тус улсын хууль бус бүслэлтээс үүдсэн олон жилийн хүмүүнлэгийн хямралыг улам хурцатгалаа. Үүний улмаас тэнд байсан Палестинчуудын ихэнхийг нүүлгэн шилжүүлж, орон гэргүй, өлсгөлөн, амь насанд аюултай өвчин тусах эрсдэлд оруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрчим хүч, цэвэр ус авах боломжгүй болгожээ.

Ливан, Иран, Ирак, Сири, Йемен зэрэг улс мөргөлдөөнд татагдан оролцжээ. Иран болон Израил анх удаа харилцан бие биенийхээ нутаг дэвсгэрт шууд дайралт хийв. Есдүгээр сард Израил болон зэвсэгт “Хезболла” бүлэглэлийн хил дамнанас дайсагнал нь цэргийн ширүүн сөргөлдөөн болж хувирав. Израил Ливаны нутаг дэвсгэр даяар довтолж, энгийн иргэдэд сүйрлийн нөлөө учруулсан.

Дэлхий даяар сая сая хүмүүс Израилын Газын зурваст явуулж буй үйл ажиллагааг эсэргүүцэж байгаа хэдий ч 2024 оны турш дэлхийн улс орнуудын засгийн газрууд дангаараа болон олон талт байдлаар харгислалыг зогсоох талаар бодитой арга хэмжээ авч чадаагүй бөгөөд гал зогсоохыг уриалахдаа ч удаан хойрго байлаа. Энэ хооронд Израилын апартейдийн тогтолцоо эзлэгдсэн Баруун эрэгт улам ширүүсэж, Израилын оршин суугчид төрийн дэмжлэгтэйгээр Палестины энгийн иргэд рүү довтолох, хууль бус аллага хийх нь эрс нэмэгджээ.

Ирак, Ливи, Сири, Йемен зэрэг улсад удаан хугацаанд үргэлжилсэн мөргөлдөөний уршгаар олон сая хүний амь нас, ялангуяа гадуурхагдсан иргэдийг хохироосон бөгөөд ихэнх нь хоол хүнс, ус, шаардлагад нийцсэн орон байр, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрхээ эдэлж чадахгүйд хүрэв.

Олон улсын шударга ёсны механизмууд Израил, Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр болон Ливи улсад хариуцлага тооцох чухал алхмуудыг хийсэн. Гэвч Израилын холбоотнууд болон бусад хүчирхэг оролцогчид эдгээр хариуцлагын арга хэмжээний эсрэг дайралт хийж, хэрэгсэхгүй болгож, гэмт хэрэгтнүүдийг хамгаалж, ялгамжтай хандахын зэрэгцээ дүрэмд үндэслэсэн дэлхийн дэг журмыг зөрчихөд хүргэв.

Бүс нутаг даяар засгийн газар болон төрийн бус зэвсэгт этгээдүүд өөрөөр сэтгэгчдийг дарангуйлсаар байв. Эрх баригчид өөрөөр сэтгэгчид, шүүмжлэгчдийг цагдан хорьж, эрүүдэн шүүж, шударга бусаар яллаж, цаазаар авах ял зэрэг хатуу шийтгэл оноож байна. Онилогдсон хүмүүсийн дунд сэтгүүлчид, цахим тоймчид, улс төр болон үйлдвэрчний эвлэлийн идэвхтнүүд, Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлж

буй хүмүүс, хүний эрх хамгаалагчид байв. Зарим улсад аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаалыг дарахын тулд хууль бус, цаашлаад үхэлд хүргэх хүч хэрэглэж, хүчээр алга болгох, нийтээр нь дур зоргоор баривчлав. Эдгээр гэмт хэргийг үйлдэгчид бараг бүгд ял шийтгэлгүй үлдэв.

Жендэр, арьс үндэс, иргэний харьяалал, эрх зүйн байдал, угсаа гарал, хүйсийн илэрхийлэл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, нийгмийн анги давхаргаар нь ялгаварлах нь бүс нутгийн хэмжээнд газар авсан хэвээр байна.

Цаг агаарын эрс тэс үзэгдэл нэмэгдэх, усны хомсдол нүүрлэх гэх мэт удаан хугацааны туршид өрнөх гамшиг, уур амьсгалын хямралын хор уршиг нь хүмүүсийн амь насанд заналхийлж байгаа ч чулуужсан түлш олборлодог томоохон улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх дорвитой арга хэмжээ авсангүй.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

ГАЗ ДАХЬ ИЗРАИЛЫН ДОВТОЛГОО

2023 оны 10 дугаар сарын 7-нд Хамас болон Палестины бусад зэвсэгт бүлэглэлүүдийн Израилын өмнөд хэсэгт явуулсан олон хүнийг үхэлд хүргэсэн халдлагаас хойш 14 сарын дараа буюу 2024 оны эцэс гэхэд Газын зурваст тасралтгүй цэргийн дайралт хийсний улмаас 45,500 гаруй хүн амиа алдаж, 108,300 гаруй хүн шархаджээ. Олон Палестинчууд нуранган дороос хайртай хүмүүсийнхээ цогцсыг хараахан олж чадаагүй байна.

Жилийн туршид Эмнести Интернэшнл Израилын үйлдсэн дайны гэмт хэрэг, тухайлбал энгийн иргэд болон иргэний байгууламж руу шууд халдах, ялгаварлан гадуурхах, энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдэж, гэр бүлүүдийг олон үеэр нь устгасан үйлдлүүдийг баримтжуулсан.

Газын зүүн эргийн дагуу хамгаалалтын бүс байгуулах оролдлого хийхийн тулд Израилын цэргүүд бульдозер, гараар тэсрэх бөмбөг тавьж, хөдөө аж ахуйн газар, иргэний барилга байгууламжийг байнга сүйтгэж, байшин, сургууль, сүм зэргийг оролцуулаад бүхий л хорооллыг сүйтгэжээ.

Израилын хууль бус үйл ажиллагаа нь Газын хүн амын 90% болох 1.9 сая палестинчуудыг албадан нүүн шилжихэд хүргэж, урьд өмнө хэзээ ч байгаагүй хүмүүнлэгийн сүйрлийг санаатайгаар бий болгосон.

Эмнести Интернэшнлийн судалгаагаар Израил улс Газын зурвас дахь Палестинчуудыг устгах тухайлсан зорилгоор Геноцидийн конвенцоор хориглосон үйлдлүүдийг хийж, улмаар геноцид үйлдсэн болохыг тогтоосон. Эдгээр үйлдэлд энгийн иргэдийн амь насыг хөнөөх, бие махбод болон сэтгэл санааны хувьд ноцтой хохирол учруулах, тэдний амь насыг хохироох зорилгоор үхэлд хүргэх нөхцөлийг нь зориудаар бий болгох зэрэг хамаарна.

Израил Газын зурвас, түүний эргэн тойронд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээс удаа дараа татгалзаж, саад учруулсан. Израилын арми өнгөрсөн тавдугаар сард өмнөд хэсэгт орших Рафах хотод томоохон хэмжээний халдлага үйлдсэн. Рафах руу дайралт хийх нь энгийн иргэдэд маш их хор хөнөөл учруулна гэсэн олон улсын хамтын нийгэмлэг, тэр дундаа Израилын холбоотон орнуудын анхааруулга, түүнчлэн олон улсын шүүхийн хууль ёсны хүчинтэй шийдвэрүүдийг Израилын Засгийн газар үл тоомсорлов.

Израил улс “нүүлгэн шилжүүлэх” тушаалыг ар араас нь гаргаж, Газын зурвас дахь хүмүүсийг амьжиргааны дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээ муу, хоол

хүнсгүй жижиг бөгөөд хүн ам шигүү суурьшсан бүс нутгууд руу шахав. Үүний үр дүнд Газа дахь Палестинчуудын дийлэнх нь өлсгөлөнд нэрвэгдэж, өвчин хурдан тархаж байв. Израилын агаарын цэргийнхэн “Нүүлгэн шилжүүлэх” тушаалыг дагаж байсан энгийн иргэд, тэр дундаа Израилын аюулгүй хэмээн амласан газарт очсон иргэд рүү удаа дараа цохилт өгсөн.

Түүнчлэн Израил улс Газын зурвасаас палестинчуудыг дур зоргоор баривчилж, зарим тохиолдолд хүчээр алга болгосоор байна. Тэднийг Израил руу байнга шилжүүлж, ял оноож, шүүхээр хурал хийхгүйгээр гадаад ертөнцөөс тусгаарлан эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан.

Палестины зэвсэгт бүлэглэлүүд Газын зурвас дахь энгийн иргэдийн амьдардаг газар нутаг эсвэл ойролцоо байрлаж байгаа дотоодын дүрвэгсдэд зориулсан хуарангуудад байрлах болсон нь энгийн иргэдийн амь насанд аюул учруулж, хүн ам шигүү суурьшсан газруудад байлдагчдыг байрлуулахгүй байх олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ зөрчсөн байх боломжтой. Тэд энгийн иргэд, Израилчууд болон гадаадын иргэдийг барьцаалсан хэвээр байгаа нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн дайны гэмт хэрэг юм.

Палестинчуудын эсрэг Израилын апартейдын тогтолцоо олон арван жил үргэлжилж байна. Эзлэгдсэн баруун эрэгт Израилын оршин суугчдын Палестины энгийн иргэд болон тэдний өмч хөрөнгийн эсрэг халдлага эрс нэмэгджээ. Израилын төрийн дэмжлэгээр үйлдэгдэж байгаа газар нутгийг их хэмжээгээр булаан авах, байшин нураах, хууль бусаар хүч хэрэглэх зэрэг халдлага нь хүн төрөлхтний эсрэг хүчээр болон апартейдын эсрэг гэмт хэрэг юм.

Олон улсын хамтын нийгэмлэг Израил улсын Газа дахь харгислалыг зогсоохын тулд дорвитой арга хэмжээ авч чадсангүй. АНУ болон Баруун Европын улс орнууд зэрэг хүчирхэг улсууд Израилын үйл ажиллагааг илт дэмжиж, олон улсын эрх зүйн нийтлэг үнэ цэнийг алдагдуулсан. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл хэдэн сарын турш үр дүнтэй арга хэмжээ аваагүй бөгөөд зөвхөн гуравдугаар сард гал зогсоохыг уриалав.

1 дүгээр сарын 26-нд Олон улсын шүүх геноцидийн конвенцын дагуу Израилын эсрэг Өмнөд Африкийн гаргасан хэргийг шийдвэрлээд анхны түр арга хэмжээгээ гаргажээ. Үүний дараа 3 дугаар сарын 28, 5 дугаар сарын 24-нд дахин хоёр тогтоол гаргасан. Израил шүүхийн шийдвэрийг эсэргүүцэв. Гэвч зарим улс геноцидээс урьдчилан сэргийлэх үүргээ зөрчиж, геноцид болон дайны гэмт хэрэгт хамтран оролцох эрсдэлтэй гэсэн анхааруулгыг үл хайхран олон улсын эрх зүйг зөрчин зэвсэг хэрэгслээр Израилийг хангасан.

Арван нэгдүгээр сарын 21-нд Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) Израилын Ерөнхий сайд Бенжамин Нетаньяху, Батлан хамгаалахын сайд асан Йоав Галлант, Палестин дахь Аль-Кассамын бригадын командлагч Мохаммед Дейф нарыг дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр баривчлах тогтоол гаргасан.

Жилийн турш дэлхийн өнцөг булан бүрт Израилын Газын зурвас дахь үйл ажиллагааг эсэргүүцсэн сая сая хүнийг хамарсан жагсаал, цуглаан, эсэргүүцлийн цуглаан өрнөсөн боловч олон улс оронд үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах эрх чөлөөг ноцтойгоор хязгаарласан.

БУСАД ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Израилын Газын зурваст хийсэн дайралт нь Иран, Ирак, Ливан, Сири, Йемен зэрэг орнуудад зэвсэгт мөргөлдөөн, дайсагналд хүргэсэн бөгөөд тэдгээрийн заримд нь АНУ, Их Британий цэргүүд оролцсон юм.

Нэг жил үргэлжилсэн хил дамнасан халдлагуудын дараа Израил улс 9 дүгээр сарын 23-нд Ливанд цэргийн шинэ довтолгоо эхлүүлэв. 2023 оны 10 дугаар сарын 8-наас 2024 оны эцэс хүртэл Ливанд 4,047 хүн амиа алдаж, 16,600 хүн шархдаж,

1,2 сая хүн дүрвэжээ. Израилын цэргүүд Ливаны нийслэл Бейрут зэрэг хотын орон сууц, тариалангийн талбай, сургууль, сүм хийд, эмнэлгүүд рүү дайрчээ. Түүнчлэн Израилын цэргүүд хорь гаруй тосгоныг сүйтгэж, тэсрэх бөмбөг, бульдозер, экскаватор ашиглан энгийн иргэдийн барилгыг сүйтгэсэн. “Хезболла” зэвсэгт бүлэглэл жилийн турш Ливанаас Израилын хойд хэсэг рүү хэдэн зуун пуужин харваж, 100 гаруй хүний аминд хүрсэн.

Йемены Хутигийн зэвсэгт хүчин Улаан тэнгис, Адены булан, Энэтхэгийн далайд олон арван хөлөг онгоц руу дайрахдаа энгийн номхон далайчдыг хөнөөсөн бөгөөд тэдгээр хөлөг онгоцыг Израил, АНУ, Их Британитай холбоотой гэж үзжээ. Үүний хариуд АНУ-ын тэнгисийн болон агаарын цэргийн хүчнийхэн, зарим нь Их Британий цэргийн хүчинтэй хамтран Хутигийн объектуудад цохилт өгчээ. Хутичууд Израилын эсрэг хамгийн багадаа 48 удаа пуужин болон дроноор халдлага үйлдэж, нэг энгийн иргэнийг хөнөөсөн. Үүний хариуд 7 дугаар сарын 20-нд Израил Йеменд хүмүүнлэгийн тусламж хүргэхэд чухал ач холбогдолтой Ходейда боомт болон Рас-Катнибын цахилгаан станцыг бөмбөгдсөн бөгөөд дор хаяж зургаан энгийн иргэн амь үрэгджээ. Есдүгээр сарын 29-нд Израил Ходейда мужийн Ходейда, Рас Исса боомт, түүнчлэн Аль-Хали, Рас Катниб цахилгаан станцуудыг бөмбөгдөж, таван энгийн иргэн амиа алдаж, бусад олон хүн шархадсан.

Дөрөвдүгээр сард Сири дэх Ираны консулын газарт цохилт өгч, Ираны Исламын хувьсгалыг хамгаалагчдын бүлгийн долоон гишүүнийг хөнөөсний хариуд Иран улс Израил руу 300 гаруй пуужингаар харвасан. Аравдугаар сард ХАМАС-ын удирдагч Исмаил Хание, Хезболлагийн удирдагч Хассан Насралла нарыг устгасны хариуд Иран улс Израил руу 200 орчим баллистик пуужин харвасан. Мөн сард Израил улс Ираны 20 объектод цохилт өгч, нэг энгийн иргэн, дөрвөн цэргийн албан хаагч амь үрэгджээ.

Израил Газын зурвас болон Ливан дахь зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотойгоор Сири дэх цэргийн ажиллагаагаа нэмэгдүүлсэн. Арванхоёрдугаар сард Сирийн Ерөнхийлөгч Ассадыг түлхэн унагасны дараа Израилын арми НҮБ-аас тогтоосон Голаны өндөрлөг дэх зэвсэггүй хамгаалалтын бүсэд цэргээ оруулж, Голаны өндөрлөг дэх Израилын хууль бус суурьшлыг өргөжүүлэх дохио өгч, Сирид олон зуун агаарын цохилт өгсөн.

Израил улсын Газа болон Ливан руу хийсэн дайралтын улмаас Ард түмний дайчилгааны бүлгийн дэргэдэх зэвсэгт бүлэглэлийн Ирак дахь Исламын эсэргүүцэл улам эрчимжиж, Израил болон Голаны өндөрлөг дэх цэргийн объектууд болон дэд бүтцийг онилсон хэмээн тус бүлэглэл мэдэгдсэн байна.

Бүс нутгийн бусад хэсэгт удаан үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөн, түүний үр дагавар нь олон сая хүний амьдралыг сүйрүүлсээр байгаа бөгөөд мөргөлдөөнд оролцогч талууд (зарим нь гадаадын засгийн газрын дэмжлэгтэйгээр) дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн.

Сирид удаан үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд болон тэдний холбоотнууд хууль бус халдлага үйлдсэний улмаас олон тооны энгийн иргэд амь үрэгдэж, шархадсаны зэрэгцээ энгийн иргэдийн чухал хэрэгцээний дэд бүтцийг сүйрүүлсээр байна. Оны эхний хагаст ОХУ-ын дэмжлэгтэйгээр ерөнхийлөгч Ассадын засгийн газар зэвсэгт сөрөг хүчнийхний хяналт дор Сирийн баруун хойд хэсэгт довтолгоогоо нэмэгдүүлэв. Турк улс Сирийн зүүн хойд хэсгийн хот, тосгод руу удаа дараа цэргийн дайралт хийж, тэнд байрлаж буй курд бүлэглэлүүдтэй хийсэн дайныг үргэлжлүүлснээр энгийн иргэд амь үрэгдэж, энгийн иргэдийн чухал хэрэгцээний дэд бүтцэд хохирол учруулсан.

Арванхоёрдугаар сарын 8-нд сөрөг хүчнийхэн Сирийн Ерөнхийлөгч Ассадын засаглалыг түлхэн унагаж, түүний гэр бүлийнхний 50 жилийн турш үргэлжлүүлсэн дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг зэрэг хүний эрхийг өргөн хүрээнд зөрчиж байсан харгис хэрцгий, дарангуйллыг эцэс болгов.

Ливийн нийслэл Триполи, Ливийн баруун болон өмнөд хэсэгт өрнөсөн нөөц баялаг, улс төрийн нөлөөллийн хяналтын төлөөх зэвсэгт бүлэглэлүүдийн мөргөлдөөний улмаас энгийн иргэд амь үрэгдэж, иргэний байгууламжууд сүйдсэн.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх тал олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх, ялангуяа энгийн иргэд болон иргэний дэд бүтцэд шууд халдах, энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдэх явдлыг зогсоох ёстой. Хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчих, түүнийг дэмжих эрсдэл өндөр байгаа тохиолдолд гадаадын засгийн газрууд зэвсгийн шилжүүлэлтийг зогсоох ёстой.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРЖ БҮЙ НЬ

Бүс нутгийн эрх баригчид хүний эрхийн бүртгэл, эдийн засгийн бодлого, Газын зурвас дахь мөргөлдөөн болон нийгмийн асуудлын талаар цахим орчинд шүүмжлэлт эсхүл өөр үзэл бодол илэрхийлэх эрхийг зөрчсөөр байна. Зарим улсын засгийн газар сөрөг хүчний дуу хоолойг боомилох, шүүмжлэгчдэд хатуу шийтгэл оногдуулахын тулд терроризмтой холбоотой эсхүл “худал мэдээ” тараах гэмт хэрэгт тэднийг буруутгаж байна.

Иранд эрх баригчид жагсагчид, нүүрээ халхлах хууль тогтоомжийг зөрчсөн эмэгтэйчүүд, сэтгүүлчид, уран бүтээлчид, зохиолчид, эрдэмтэн судлаачид, их сургуулийн оюутнууд, ЛГБТИ хүмүүс, үндэстний болон шашны цөөнхийн гишүүд, хүний эрх хамгаалагчдыг байцаахын тулд дур зоргоор цагдан хорихын зэрэгцээ цаазаар авах, хорих, торгуулийн ял оногдуулах, гэмт хэрэгт шударга бусаар яллах, хүний эрхээ тайван замаар эдэлснийх нь төлөө ташуурдаж байна.

Иорданд эрх баригчдыг шүүмжилсэн, Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаар илэрхийлсэн, тайван жагсаал, олон нийтийн ажил хаялтад уриалсан хэрэгт буруутган Кибер гэмт хэргийн тухай хуулиар хэдэн зуун хүнд ял оногдуулсан. Иорданы эрх баригчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлснийхээ төлөө баривчлагдсан хүмүүсийн шударгаар шүүлгэх эрхийг удаа дараа зөрчсөөр байна.

Саудын Араб бодит эсвэл шүүмжлэлт байдлаар үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүсийг дур зоргоор цагдан хорьсоор байгаа бөгөөд ингэхдээ цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг эсэргүүцэх боломжийг иргэдэд олгоогүй. Ихэнх тохиолдолд эдгээр хүмүүсийн тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн үйлдлийг “терроризм”-ын гэмт хэрэгт тооцож, “бүхнийг барина” гэсэн хандлагаар урт хугацаагаар хорих, эсхүл тодорхой бус хэрэгт цаазаар авах ял оногдуулан шударга шүүхээр шүүлгэх эрхийг нь зөрчиж байна.

Хойд Африк даяар өөрөөр сэтгэгчдийг дарангуйлах явдал үргэлжилж, улам хурцадмал болсон. Тунисийн эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, бүх төрлийн өөрөөр сэтгэгчдийн эсрэг тэмцлээ улам эрчимжүүлж, улс төрийн сөрөг хүчний нэр хүнд бүхий гишүүд, сэтгүүлчид, олон нийтийн сүлжээ хэрэглэгчид, хүний эрх хамгаалагчид, хуульч, шүүмжлэгчдийг дур зоргоор баривчлах зорилгоор дарангуйллын хууль тогтоомж, үндэслэлгүй ял ашиглаж байна. Египетэд сэтгүүлчид, тайван жагсагчид, өөрөөр сэтгэгчид, сөрөг хүчний улстөрчид болон засгийн газрыг шүүмжлэгчдийг онилсоор байна. Марокко болон Баруун Сахарын эрх баригчид олон мянган хоригдлуудад хаан өршөөл үзүүлсэн ч сэтгүүлч, идэвхтнүүд, засгийн газрын шүүмжлэгчдийг онилсон хэвээр байв. Алжир улс үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, тайван жагсаал цуглаан, эвлэлдэн нэгдэх, тэр дундаа тайван эсэргүүцлийн жагсаалыг зогсоохын тулд терроризмтой холбоотой зохиомол хэргүүдийг байнга хэрэглэж байв. Ливи дэх цэргүүд болон зэвсэгт бүлэглэлүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван хуран цуглах эрхээ эдэлснийх нь төлөө олон зуун идэвхтэн, жагсагчид, сэтгүүлчид болон онлайн

контент бүтээгчдийг дур зоргоор баривчилж, цагдан хорьсон.

Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэх, тэр дундаа сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, идэвхтнүүдийн эдгээр эрхээ дарамт, хүчирхийлэл, ял шийтгэлээс ангид байдлаар хэрэгжүүлэх баталгааг хангаж, эрхээ эдэлснийхээ төлөө цагдан хоригдсон хүмүүсийг суллах шаардлагатай.

ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн бараг бүх улсын засгийн газрууд тайван жагсаал, цуглаанд саад учруулах, эсвэл хүчээр тараахын тулд янз бүрийн арга хэрэглэсэн.

Египетийн эрх баригчид төлөвлөсөн эсэргүүцлийн жагсаал болохоос өмнө хүмүүсийг хоморголон олноор баривчилж, зохион байгуулагдсан цөөн хэдэн жижиг эсэргүүцлийн жагсаалыг хүчээр дарсан. Тухайлбал, эрх баригчид 4 дүгээр сарын 23-нд Палестин, Суданы эмэгтэйчүүдтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн хүний эрх хамгаалагч эмэгтэйчүүд болон бусад цөөн хүн оролцсон эсэргүүцлийн жагсаалыг хүч хэрэглэн тараасан. Иракийн эрх баригчид засгийн газрын авлига, эдийн засгийн хүндрэл, төрийн үйлчилгээний чанаргүй байдлаас үүдсэн эсэргүүцлийн жагсаалыг тараахын тулд галт зэвсэг ашигласан.

Тунисийн эрх баригчид зөвхөн тайван жагсаалд нэгдсэнийх нь төлөө хүмүүсийг дур зоргоор цагдан хорьж, ялласны зэрэгцээ ийм зорилгоор “саад учруулсан” гэх үндэслэлгүй, тодорхойгүй гэмт хэргийг удаа дараа ашигласан. Йорданы хүчин 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 10 дугаар сарын хооронд Газын зурвас дахь Палестинчуудыг дэмжсэн томоохон эсэргүүцлийн жагсаалын үеэр олон мянган жагсагчид болон хөндлөнгөөс харж байсан хүмүүсийг баривчилсан бөгөөд 2024 оны эцсээр олонх нь цагдан хоригдсон хэвээр байв. АНЭУ-ын эрх баригчид тайван жагсаал цуглааныг дарангуйлж, тайван жагсагчид болон бусад эсэргүүцэгчдийг шүүхээр хоморголон шүүсэн.

Засгийн газрууд тайван жагсаал цуглаан хийх эрхийг хүндэтгэж, тайван жагсагчдыг нухчин дарах явдлыг зогсоох ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Бүс нутаг даяар хүмүүс сүйрэл дагуулсан мөргөлдөөн, эдийн засгийн болон өрийн хүнд цохилт, цаг уурын гамшгийн хохирол зэрэг олон тооны, үргэлжилсэн хямралтай нүүр тулгарсан. Өсөн нэмэгдэж буй инфляци, засгийн газрын алдаа дутагдал болон бусад хүчин зүйлүүд орон нутгийн бүс нутгийн хамгийн ядуу, хамгийн олон хүн амтай зарим орнуудын амьжиргаанд ноцтой дарамт учруулж байна. Энэ нь сая сая хүмүүсийг хүнсний эрсдэлд оруулж, амьдрах нөхцөлийг дордуулж, эрүүл мэнд, ус, амьжиргааны зохистой түвшинд аж төрөх эрхийг нь алдагдуулжээ.

Ливанд засгийн газрын алдаанаас үүдэж, улам гүнзгийрч байгаа санхүү, эдийн засгийн хямрал үргэлжилсээр байна. Засгийн газар хүмүүсийн эдийн засаг, нийгмийн тэр дундаа нийгмийн хамгааллын эрхийг хамгаалахад шаардлагатай шинэчлэлийг хийж чадсангүй. Энэхүү хямрал нь гадуурхагдсан бүлгүүдэд, тухайлбал, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, албан бус ажилчид, дүрвэгсдэд үзүүлэх шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд Израилын Хезболлатай хийсэн дайны улмаас улам хүндэрсэн.

Засгийн газар эрүүл мэнд, боловсролд зарцуулах төсвийн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн эдийн засгийн хямрал Египетийн иргэдийн нийгэм, эдийн засгийн эрхэд ноцтой нөлөөлсөн. Эрүүл мэндийн үйлчилгээг хувьчлах шинэ хууль

нь эрүүл мэндийн үйлчилгээ, ялангуяа ядуу хүмүүсийн эрүүл мэндийн хүртээмжийг алдагдуулсан. Эрх баригчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шаардсан ажилчид болон албадан нүүлгэн шилжүүлэхийг эсэргүүцсэн оршин суугчдыг нухчин дарахын тулд дарангуйлж, баривчилсан.

Олон оронд засгийн газрууд нь бага цалинтай ажилтнуудыг хөдөлмөрийн мөлжлөгөөс хамгаалж чадаагүй бөгөөд тэднийг аливаа шийтгэлээс айх айдасгүйгээр бие даасан үйлдвэрчний эвлэлд элсэх, байгуулах, ажил хаях эрхийг нь хаасан. Саудын Араб, Катар, АНЭУ зэрэг Персийн булангийн улс орнуудад бага цалинтай цагаач ажилтнууд ажил олгогчийн хөдөлмөрийн ноцтой мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, шаардлагад нийцээгүй орон байр, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж зохих үнэлгээтэй цалин авч чадахгүй байгаа бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажлаас үндэслэлгүй халагдсан хэвээр байна. Үүнд гэрийн үйлчлэгчид хамгийн ихээр өртөж байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь эмэгтэйчүүд байна.

Засгийн газрууд хүмүүсийн эдийн засаг, нийгмийн эрхийг хамгаалахын тулд яаралтай арга хэмжээ авах, түүний дотор хүн бүр, тэр дундаа гадуурхагдсан бүлгүүдэд хоол хүнс, ус, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх боломжийг олгодог бүх нийтийн нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох шаардлагатай. Хандивлагч улс орнуудын засгийн газар болон олон улсын санхүүгийн байгууллагууд энэ зорилгод хүрэхэд засгийн газруудыг дэмжихийн тулд яаралтай арга хэмжээ авах ёстой. Засгийн газар ажилтнуудын бие даасан үйлдвэрчний эвлэлд нэгдэх, байгуулах, ажил хаях эрхийг хамгаалахын зэрэгцээ бүх цагаач ажилчид, тэр дундаа гэрийн үйлчлэгчдийг хөдөлмөрийн хуулийн хамгаалалтад хамруулах ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

ОХИД БОЛОН ЭМЭГТЭЙЧҮҮД

Бүс нутаг даяар охид, эмэгтэйчүүдийг хууль эрх зүйн зохицуулалт болон практикт ялгаварлан гадуурхах, тэр дундаа чөлөөтэй зорчих эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, бие махбодын бие даасан байдал, өв залгамжлал, гэр бүл салалт, улс төрийн албан тушаал, хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор ялгаварлан гадуурхсан хэвээр байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл цахим болон цахим бус орчинд нийтлэг хэвээр, ч тэдгээрт ял шийтгэл оногдуулаагүй. Зарим улсад энэ төрлийн хүчирхийлэл нэмэгдэж, эмэгтэйчүүдийн хамгаалалт улам суларсан.

Алжир, Иракийн хууль тогтоомжид хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчдэд хохирогчтойгоо гэрлэх замаар ял шийтгэлээс мултрах боломж олголоо.

Йеменд Хути де-факто эрх баригчид болон зэвсэгт бүлэглэлүүд эмэгтэйчүүдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, эрэгтэй асран хамгаалагчийн бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр зорчихыг хориглосон хэвээр байна.

Иракийн Курдистан бүс нутагт зарим нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч эрх баригчид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхгүй хэвээр байгаа бөгөөд санхүүжилт багатай хамгаалах байрны системд хамгаалалт хүссэн амьд үлдэгсдийн эрх чөлөөг дур зоргоор хязгаарласаар байна. Түүнчлэн хууль тогтоогчид хувь хүний байдлын талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг оролдсон бөгөөд энэ нь охид, эмэгтэйчүүдийн хамгаалалтыг эрс дордуулсан.

Иранд эрх баригчид гивлүүр өмсөхөөс татгалзсан охид, эмэгтэйчүүдийн эсрэг нүүр таних технологи гэх мэт дижитал мөрдөн тандалтын арга хэмжээг дагаж мөрдөхийг эрчимжүүлэв. Аюулгүй байдлын эргүүлүүд нэмэгдэж, олон нийтийн газар охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлж, халдсаар байв.

Ливи дэх цагдаа болон зэвсэгт бүлэглэлүүд нийгэмд нөлөөлөгч эмэгтэйчүүд, контент бүтээгчдийг өөрсдийгөө илэрхийлэх арга барил, хувцаслалтаар нь онилон бай болгож байна. Арван нэгдүгээр сард Триполид төвтэй Үндэсний эв нэгдлийн засгийн газар эмэгтэйчүүдийг заавал гивлүүр зүүх үүрэг хүлээлгэж, “ёс суртахууны цагдаа”-аар дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаа зарлав.

ЛГБТИ ХҮМҮҮС

Бүс даяар бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэлд нь үндэслэн хүмүүсийг баривчилж, ялласан. Тэдний олонхыг нь ижил хүйстэнтэйгээ зөвшилцөн бэлгийн харьцаанд орсон хэрэгт буруутган, хатуу шийтгэл оногдуулсан. Ливи, Тунис, Иракт ЛГБТИ хүмүүсийн эрхэд халдах ажиллагаа эрчимжиж байна.

Ливи улсын нийслэл Триполи дахь Дотоодын аюулгүй байдлын агентлагийн цагдаа, бусад цагдаа болон зэвсэгт бүлэглэлүүд хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэлд нь үндэслэн дур зоргоор баривчилж, яллахын зэрэгцээ эрүүдэн шүүж “хэрэг хүлээсэн мэдүүлгүүдийг” олон нийтэд цацдаг. Тунист “ижил хүйстэнтэй холбоотой хэргээр” яллагдагчаар татагдах явдал нэмэгдсэн хэмээн ЛГБТИ бүлгүүд мэдээлсэн.

Дөрөвдүгээр сард Иракт анх удаа ижил хүйстнүүдийн бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцож, 15 жил хүртэл хорих ял оноохоор хуульчилсан. Шинэ хуульд ижил хүйстнүүдийн харилцааг сурталчлах, трансгендэрийн илэрхийллийг “сурталчлах” зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож, “эмэгтэйлэг үйлдэл” гэх мэт тодорхойгүй гэмт үйлдлийг нэмж оруулсан байна.

УГСААТНЫ БОЛОН ШАШНЫ ЦӨӨНХ

Бүс нутаг даяар үндэсний, угсаатны болон шашны нийгэмлэгийн гишүүд, цөөнхийн гишүүдийг хууль болон практикт, тэр дундаа шашин шүтэх, хавчлага болон хүний эрхийн бусад ноцтой зөрчлөөс ангид байх эрхтэй холбоотой ялгаварлан гадуурхалт гарсаар байна.

Израил улс эзлэгдсэн Баруун эрэг дэх Палестинчуудыг дарангуйлж, ноёрхох замаар апартейдын тогтолцоогоо улам бүр бэхжүүлэв. Албадан шилжүүлэх, захиргааны журмаар цагдан хорих, эрүүдэн шүүх, хууль бусаар алах, үндсэн эрх, эрх чөлөөг үгүйсгэх, хавчлага зэрэг хүний эрхийн олон төрлийн зөрчлийг системтэйгээр үйлдэж байсан.

Иранд Ахвази араб, Азербайжаны турк, балуч, курд, туркмен зэрэг үндэстний цөөнхүүд ялгаварлан гадуурхалттай нүүр тулсан нь тэдний боловсрол, ажил эрхлэлт, шаардлагад нийцсэн орон байр, улс төрийн албан тушаалд хүрэх боломжийг хязгаарласан. Бахай шашны цөөнхийн гишүүд өргөн хүрээтэй, системтэй хүний эрхийн зөрчилд өртсөн.

Засгийн газар арьс үндэс, үндэсний гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн, илэрхийллээр нь ялгаварлан гадуурхахыг зогсоох ёстой. Тэд хүн бүрийг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш эрх олгох, үзэл бодол, үзэл санаа, шашин шүтлэг, итгэл үнэмшлийн эрх чөлөөг хамгаалах, дэмжих, баталгаажуулах хууль эрх зүйн болон бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх ёстой.

ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ЦАГААЧ, ДҮРВЭГСЭД

Удаан үргэлжилсэн мөргөлдөөний улмаас олон тооны дотооддоо шилжин суурьшигчид Израил, Палестин, Ирак, Ливи, Сири, Ливан, Йеменд амьд үлдэхийн тулд томоохон сорилттой тулгарч байна. Ихэнх нь эрх баригчдын ялгаварлан гадуурхалт, төрийн үйлчилгээнд хамрагдах саад тотгор, гэртээ харих эрхийг нь хаах, зөвшөөрөлгүй буцахыг оролдсон тохиолдолд дарангуйлах, түүнчлэн чухал шаардлагатай хүмүүнлэгийн тусламжийг хязгаарлах, багасгах зэрэг хүндрэлтэй нүүр тулгарсан.

Ойролцоогоор 1.1 сая Иракчууд дотооддоо дүрвэсэн хэвээр байгаа бөгөөд тэдний ихэнх нь орон байр, ус, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг чухал хэрэгцээ, үйлчилгээ авахаар хичээж байна. Иракийн аюулгүй байдлын хүчнийхэн заримыг нь Исламын зэвсэгт бүлэглэлтэй холбоотой гэж үзэн дур зоргоор баривчилж, хүчээр алга болгож, цахилгаанд цохиулж, усан онгоцонд цохиулан эрүүдэн шүүсэн.

НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн агентлагийн мэдээлснээр Сири улсын дотооддоо дүрвэгсдийн тоо 7.2 саяд хүрчээ. Арванхоёрдугаар сард Ерөнхийлөгч Ассадыг огцруулсны дараа хүмүүнлэгийн болон аюулгүй байдлын байдал бүрхэг, тодорхойгүй хэвээр байна. Гэхдээ Европын олон улс Сиричүүдийн орогнол хүссэн хүсэлтийг түдгэлзүүлж байгаа асуудлыг эргэн харж, арга хэмжээ авахаа мэдэгдэв.

Засгийн газрын алдаа, олон улсын хамтын нийгэмлэг, тухайлбал чинээлэг улс орнууд зохих нүүлгэн шилжүүлэлт, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх замаар харууцлагаа хуваалцаж чадаагүйтэй холбоотойгоор дүрвэгсэд, орогнол хүсэгчид болон цагаачдын эрх бүс нутаг даяар зөрчигдөж байна. Ливан улсад байгаа 1.5 сая шахам Сирийн дүрвэгсдийн 90 орчим хувь нь нэн ядуу амьдарч, хоол хүнс, орон байр, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байна. Зарим тохиолдолд орон нутгийн эрх баригчид болон улс төрчдийн өдөөсөн дүрвэгсдийг үзэн ядсан үг хэллэг нь дайсагнасан орчныг улам хурцатгав. Үүний зэрэгцээ хоёр сая палестин, Сирийн 750,000 орчим дүрвэгчийг хүлээн авч байсан хөрш Иордан дахь олон дүрвэгсэд болон орогнол хүсэгчид ядууралд өртөж, нөхцөл байдал улам дордож байна.

Тунис цагаачид болон дүрвэгсдийг Алжир, Ливи рүү байнга хөөн гаргаж байгаа нь үл буцаах зарчмыг зөрчиж, эзгүй эсвэл алслагдсан хилийн бүсэд байгаа хүмүүсийг хоол унд, усгүй болгосоор байна. Тавдугаар сараас эхлэн эрх баригчид дүрвэгсэд болон цагаачдын эрхийг хамгаалдаг байгууллагуудыг нухчин дарангуйлж, тэдний нэн чухал үйлчилгээнд хамрагдах боломжийг бууруулсан.

Зэвсэгт бүлэглэлүүд болон ЕХ-ны дэмжлэгтэй эргийн хамгаалалтын ажилтнуудын далайд саатуулсан Ливи дэх дүрвэгсэд, цагаачид болон Ливи рүү хүчээр буцаасан хүмүүсийг тодорхойгүй хугацаагаар дур зоргоор цагдан хорьж, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах, айлган сүрдүүлж мөнгийг нь авах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хууль бусаар хөөх зэрэг зөрчилд өртөж байна.

Суданы зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж байгаа хэдий ч Египетийн эрх баригчид олон улсын эрх зүйг ноцтой зөрчин Суданы олон мянган иргэнийг дур зоргоор цагдан хорьж, хүчээр буцаасан.

Засгийн газар дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаачдыг эрх зүйн байдалд нь үндэслэн дур зоргоороо баривчлах явдлыг зогсоож, тэднийг цагдан хорих, нутаг буцаах, хоморголон хөөх, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахаас хамгаалах ёстой. Засгийн газар дотооддоо шилжин суурьшигчдыг эх орондоо сайн дураараа, аюулгүй, хүн ёсоор буцаах талаар тодорхой арга хэмжээ авах ёстой.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Бүс нутгийн ихэнх улс 2024 онд цаазаар авах ялыг хэвээр үлдээж, цаазаар авах ялыг оногдуулсан бөгөөд үүнд болгоомжгүйгээр хүний амь нас хохироох, олон улсын эрх зүгээр хамгаалсан ижил хүйстнүүдийн зөвшилцсөн бэлгийн харьцаа, шашны болон улс төрийн үзлээс татгалзах зэрэг үйлдлүүд, өөрөөр сэтгэгчдийг дуугүй болгох зорилгоор оноох хилс хэргүүд багтана. Хэд хэдэн улсад цаазаар авах ял гүйцэтгэсэн. Иракт өмгөөлөгч болон төрөл төрөгсдөд нь урьдчилан мэдэгдэхгүйгээр хүмүүсийг хоморголон цаазалсан. Ираны эрх баригчид цаазаар авах ялыг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хэрэгсэл болгон ашигласан хэвээр байна.

Засгийн газрууд цаазаар авах ялыг халахын тулд албан ёсоор цаазаар авах ял гүйцэтгэхийг хойшлуулахыг нэн даруй баталгаажуулах шаардлагатай.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Дээрх бүс нутагт уур амьсгалын өөрчлөлтийн хор уршиг, ихэнхдээ амь насанд заналхийлсэн үр дагавар, тэр дундаа цаг агаарын эрс тэс үзэгдэл, өсөн нэмэгдэж буй усны хомсдол зэрэг удаан хугацааны турш мэдрэгдэх гамшигт үзэгдэл, байгаль орчны буруу менежмент үргэлжилсээр байна. Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох, түүний нөлөөллийг бууруулах, хамгийн ихээр нөлөөлд өртсөн хүмүүст зохистой дэмжлэг үзүүлэх хангалттай арга хэмжээ авч чадсангүй.

Ирак усны хомсдолд орж, агаар, усны бохирдол нэмэгдэж байна. Хог хаягдлын үр ашиггүй менежмент, ойн хомсдол нь шороон шуурга, усаар дамждаг өвчлөлийг эрчимжүүлж, эмзэг бүлгийн хүн ам, ялангуяа нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүст харьцангуй ихээр нөлөөлж байна. Иордан мөн усны хомсдолд орсон бөгөөд нийлүүлэлт нь шаардлагатай хэрэгцээний гуравны хоёрыг л хангаж байв.

Аагим халуун Кувейтийг нөмөрч, 5 дугаар сарын сүүлчээр агаарын температур өмнөх жилийн мөн үеийн дунджаас 4°C-5°C-аар өндөр байсан нь түүхэн өндөр халалт юм. Гэвч 3 дугаар сард Кувейтийн төрийн өмчит газрын тосны корпорацийн гүйцэтгэх захирал тус улс 2035 он гэхэд газрын тосны олборлолтоо мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ хэмээн мэдэгдэж, 7 дугаар сард шинэ нөөц илэрвэл цаашид нэмэгдүүлэхээ зарласан.

Бусад улс орнууд чулуужсан түлшийг үе шаттайгаар зогсооход ахиц дэвшил гаргаж чадсангүй. Хоёрдугаар сард Бахрейн 400 газрын тосны цооног, 30 хийн цооног шинээр бий болгох замаар чулуужсан түлшний олборлолтыг өргөжүүлэх зорилгоор зээл авах хүсэлт гаргасан. Global Witness-ийн зургадугаар сард гаргасан тайланд АНЭУ-ын COP28 баг 2023 онд уур амьсгалын бага хурлыг зохион байгуулах үеэр төрийн өмчит газрын тосны компани болох Абу Даби Үндэсний Газрын тосны компанитай чулуужсан түлшний гэрээ хэлцэл хийснийг баталжээ. Мөн зургадугаар сард Саудын Арабын Эрчим хүчний сайд 2025-2027 оны хооронд газрын тосны олборлолтоо нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа зарласан.

Засгийн газрууд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг хязгаарлах, чулуужсан түлшний олборлолт, хэрэглээг зогсоох зэрэг уур амьсгалын хямралыг бууруулах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай. Хүний эрхэд нөлөөлөх эрсдэлийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг авахад тусламж шаардлагатай улс орнуудад нөөц бүхий бүх улс орнууд олгох санхүүжилтээ мэдэгдэхүйц нэмэгдүүлэх ёстой.

ЯЛ ЗАВШИХ

Бус нутаг даяар улс орнууд хүний эрхийг ноцтой зөрчсөн гэмт хэрэгтнүүдийг ял завшихад тус дөхөм үзүүлсээр байгаа нь гүнзгий хямрал нүүрлэсэн дотоодын шүүхийн тогтолцооны алдаа дутагдлыг онцлон илтгэж байна.

Апартейд болон хууль бус эзлэн түрэмгийллийн хүрээнд Палестинчуудын эсрэг Израилын удаа дараа үйлдсэн дайны гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчилд олон арван жил ял шийтгэл хүлээлгээгүй хэвээр байна.

2022 онд Мароккогоос Испаний Мелилла муж руу хил давахыг завдсан Сахарын цөлөөс урагш Африкийн цагаачдыг Марокко болон Испаний аюулгүйн хүчнийхэн үхэлд хүргэсний дараа хохирогчдын ар гэрийнхэнд үнэнг мэдэх, шударга ёс, нөхөн төлбөр олгох асуудлыг Мароккогийн эрх баригчид шийдвэрлэж чадсангүй.

Иран улсад 2024 он болон түүнээс өмнөх жилүүдэд үйлдэгдсэн хууль бусаар алах, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх, бусад зүй бусаар харьцах, хүчин болон бусад бэлгийн хүчирхийлэл зэрэг олон улсын эрх зүйг зөрчсөн гэмт хэрэг, эсхүл хүний эрхийг ноцтой зөрчсөн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахгүй байх нь хэвээр байна.

2020 оны 6 дугаар сар хүртэл Ливийн Тархуна хотод хүнийг алах, эрүүдэн шүүх, хүчээр алга болгох болон бусад хүнлэг бус үйлдэлд холбогдуулан аль-Каниат зэвсэгт бүлэглэлийн зургаан удирдагч, ахлах гишүүд болон холбоотнуудыг баривчлах шийдвэрийг Олон улсын эрүүгийн шүүхээс гаргасан.

Европын орнууд Сири улсад олон улсын зүйгээр хориглосон гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн хүмүүсийг үндэсний шүүхээрээ дамжуулан бүх нийтийн харъяаллын зарчмын дагуу мөрдөн шалгаж, ялласан хэвээр байна.

Засгийн газрууд нь олон улсын эрх зүйн эсрэг хүний эрхийн зөрчил, гэмт хэргийг нягт нямбай, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн шалгаж, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг иргэний шүүхээр шударгаар шүүн таслах замаар ял шийтгэл завшихын эсрэг тэмцэх ёстой.

ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН

ТӨЛӨВ БАЙДАЛ

2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САР

Зарим улс орны хууль тогтоомж, бодлогод эерэг өөрчлөлтүүд гарсан хэдий ч дэлхий дахинаа хүний эрх зөрчигдсөөр байна. Дарангуйлал газар авч, хүний эрхийг үл тоомсорлож, гишгэлж, хүний эрхийн хамгаалалт суларлаа.

Эмнести Интернэшнлийн 2024 онд хийсэн судалгаа зэвсэгт мөргөлдөөний үеэр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн, өөрөөр сэтгэгчдийг нухчин дарсан, ялгаварлан гадуурхалт, эдийн засгийн болоод уур амьсгалын шударга бус байдал, технологийг урвуулан ашиглаж хүний эрхийг зөрчсөн явдал байгааг дэлхийн хүний эрхийн чиг хандлагын гол сэдэв хэмээн онцоллоо. Зарим нэг эерэг өөрчлөлтийг эс тооцвол, улс орнуудын ялангуяа хүчирхэг улсууд олон улсын дүрэмд суурилсан тогтолцоог сүйтгэж, өөр өөр тивд дарангуйлал тархахад ихээр нөлөөлсөн хүний эрхийн энэ төлөв 2025 он болон түүнээс хойш улам даамжирсан хүний эрхийн ухралт руу түлхэж болзошгүй байна.

Тайланд 2024 онд дэлхийн 150 улс оронд гарсан хүний эрхийн асуудлыг баримтжуулж, дэлхий дахин, бус нутгийн түвшинд холбож, цаашид гарах чиг хандлагыг тодорхойлсон. Түүнчлэн засгийн газрууд, бусад талууд хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд хийж, хэрэгжүүлэх ёстой арга хэмжээг дурдлаа. Энэхүү тайлан нь бодлого боловсруулагч, удирдагч, нөлөөлөгч, идэвхтнүүд болон хүний эрхийг сонирхож буй хүн бүхэнд зайлшгүй унших материал байх болно.

www.amnesty.org
www.amnesty.mn

